

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2023 оны 03 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Ганчиг

1. ОРШИЛ	3
2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
2.1 Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголын төсөлд өгсөн санал.....	5
2.2 Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн санал, зөвлөмж.....	5
2.3 Төсөв, татварын асуудлаар зарим аймгуудад хийсэн судалгааны ажил	6
2.4 Монгол Улсын 2023 оны Нэгдсэн төсвийн төсөлд өгсөн зөвлөмж	7
2.5 Төсөвтэй холбоотой бусад хууль, тогтоомжийн төсөлд өгсөн санал.....	8
2.6 ТТБЗ-өөс өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилт	9
3. ХАМТЫН АЖИЛЛАГАА	10
3.1 Татварын боловсрол олгох үндэсний хөтөлбөр	10
3.2 “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлэг	11
3.3 Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн хэрэгжилт	14
3.4 “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг	16
3.5 “Төсөв-2023” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэг	17
3.6 Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дэмжлэг	17
3.7 Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал.....	17
4. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦСАН БАЙДАЛ	18
5. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	21
5.1 Зөвлөлийн хуралдаан.....	21
5.2 Хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд.....	22
6. ДҮГНЭЛТ	23
Хавсралт 1. ТТБЗ-өөс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	24
Хавсралт 2. “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний зөвлөгөөнд оролцогчдод зориулсан илгээлт	30
Хавсралт 3. “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж.....	31
Хавсралт 4. Сургалт-айлчлалын тайлан	33
Хавсралт 5. Өдрийн сонинд өгсөн ярилцлага	54
Хавсралт 6. Өдрийн сонинд өгсөн ярилцлага	57
Хавсралт 7. Зууны мэдээ сонинд өгсөн ярилцлага	62

1. ОРШИЛ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоолоор байгуулж, зөвлөлийн дүрмийг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 83 дугаар тогтоолоор баталсан. Дүрмийн дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь дарга болон 8 орон тооны бус гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар баталсан бөгөөд энэхүү бүрэлдэхүүнээр 4 жил ажилласан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (цаашид ТТБЗ гэж товчлох) нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх, тэдгээрийн суурь зорилт болсон төсвийн зардал, улсын өрийг хязгаарлах, төсвийг алдагдалгүй болгох, төсвийн иж бүрэн байдлыг хангуулах, төсвийн гадуурх ажил, үйлчилгээг ил тод болгож, улмаар төсвийг олон нийтийн болон мэргэжлийн байгууллагын нэгдсэн хяналтад оруулахад дэмжлэг үзүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллав.

ТТБЗ-ийн эрх зүйн зохицуулалт төдийгүй чадавх, зохион байгуулалтыг бэхжүүлэх эхний алхмууд хийгдлээ. УИХ-ын тогтоол, журмаар тодорхойлсон ТТБЗ-ийн бүрэн эрхийг хуулийн түвшинд хүргэх шаардлага тулгарч байна. Мөн ТТБЗ, УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн зүгээс төсөв, нийгэм, эдийн засаг, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх чадавх нэмэгдсэн хэдий ч сайжруулах хэрэгцээ, шаардлага болон орон тоо, хүн хүчний хувьд ч бэхжүүлэх ёстой.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх үүднээс Европын холбооны санхүүжилттэйгээр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд олон арга хэмжээг тайлант жилд зохион байгуулав. Төсөв хариуцсан УИХ-ын зарим гишүүд, тамгын газрын ажилтнууд, ТТБЗ-ийн гишүүд, ажлын албаны ажилтан нарт зориулан төсөв, түүний макро-эдийн засгийн харилцан холбоо, тэдгээрийн төсөөллийн тухай хэд хэдэн сургалтыг зайнаас зохион байгуулсан. Мөн Австри улсад очиж, сургалтад хамаарагдсан болно. ОУВС, Дэлхийн банк, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Японы техникийн туслалцаатайгаар хэрэгжиж буй төсөв, банк, санхүү, өр, зээл, макро-эдийн засгийн сэдэвтэй урт богино хугацааны сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулж байна. Тайлангийн хугацаанд ТТБЗ-ийн ажлын албаны нэг ажилтан Жайкагийн ахисан түвшний сургалтад явж, мөн сургалтад хамрагдсан 2 ажилтан Тамгын газарт нэмж авлаа. Эдгээрийн үр дүнд УИХ-ын ТБХ, ТТБЗ-ийн гишүүд, Сангийн яам болон бусад судалгааны ажлын албаны чадавх тодорхой хэмжээгээр сайжирсан бөгөөд үүнийг цаашид улам сайжруулах шаардлагатай байгааг уг төслийн хүрээнд өмнөх жил ажилласан олон улсын зөвлөх Паул Гарденер зөвлөмждөө тусгасан юм.

Цаашдаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бие дааж ажиллуулж, хараат бус үнэлгээ, шинжилгээ хийлгэж байх нь зайлшгүй. Төсвийг цаашдаа хяналтаас гаргахгүй буюу хяналттай байлгах үүднээс төсвийг зөвхөн батлагдах үед бус батлагдахаас нь өмнө санал, дүгнэлтээ гаргаж Төсвийн байнгын хороо, холбогдох газарт хүргүүлж байх, улмаар Засгийн газарт хүргүүлж өөрсдийн саналыг тусгуулах арга хэмжээг авах, хэрэв санал тусгагдаагүй бол олон нийтэд мэдээлж, тэдний дэмжлэгт тулгуурлан төсвийг Улсын Их Хуралд оруулах эсэхийг шийддэг олон улсын практикт хэрэглэгдэж буй арга механизмыг Монголд нутагшуулах шаардлагатай байна. Үүнийг төсвийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдэх тухай санал дэвшүүлж байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан боловч тус хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл 13 удаа өөрчлөлт оруулсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 2017 онд байгуулснаас хойш Засгийн газар 2018, 2019 онд төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажилласан боловч харамсалтай нь 2020, 2021 онд цар тахал болон УИХ, орон нутгийн ИТХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн нөлөөллөөс хамааран Монгол Улсын төсвийн алдагдал ихээхэн нэмэгдэж, 2021 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд дахин нэг удаа өөрчлөлт оруулаад байна. Төсвийг алдагдалгүй байлгах эсвэл дээд тал нь ДНБ-ний 2 хувь байх тухай хуулийн хязгаарыг 10 гаруй хувь нэгжээр 2016, 2020 оны сонгуулийн жилүүдэд нэмэгдүүлж буй нь хууль дээдлэх зарчмыг дэндүү ихээр зөрчиж байна гэсэн дүгнэлтэд хүрэхээр байгаа юм. Энэ юуг харуулж байна вэ гэхээр төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг өөрчилбөл тодорхой хэмжээний хязгаар дотор тухайлбал 5 хувиас хэтрэхгүй гэсэн хязгаар тогтоох нь чухал байна.

Ийм байдлыг дахин гаргуулахгүйгээр төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг буцаан хэвийн байдалд оруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэмжлэгийг авах, ТТБЗ өөрсдийн хүчин чармайлтыг улам нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд улсын төсвийн алдагдлыг дотоод, гадаадын зээл болон тусламжаар санхүүжүүлсээр ирсэн бөгөөд төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс өр болон ДНБ-ий харьцааны дээд хязгаарыг энэ хуулиар баталж, урт хугацаанд өрийг бууруулах стратеги баримталж байгаа боловч хуульд тусгагдсан өрийн дээд хязгаарыг удаа дараа төсөв болон төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх үеэр өөрчлөх нь төсвийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлж байгаа хэлбэр юм.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн тусгай шаардлагыг 4 жил тутам хянан үзэж байх, эдийн засгийн өсөлт хасах болсон, томоохон гамшиг , тухайлбал Ковид-19 цар тахлын хэмжээний зардалтай дүйцэхүйц гамшиг гарвал дээрх хоёр төсвийн тусгай шалгуурыг мөрдөхийг түр түдгэлзүүлэх хуулийн заалттай. Гэтэл энэхүү шалгуурыг өөрчилсөөр байгаа нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйл дэх “хууль дээдлэх” зарчимд нийцэж буй эсэх, улмаар төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээ Засгийн газрын өрийн эрсдэлийн судалгаагаар анхаарлын дээд түвшинд хүрчээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Энэ бүхэн цаашид Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд тусгагдсан төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилтод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах тухай асуудлыг хөндөн ярихад хүргэж мэдэхээр байгааг Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох байгууллага, олон нийтэд удаа мэдэгдээд байна.

Монгол Улсын үндсэн хуульд 2019 онд орсон өөрчлөлтөөр УИХ төсвийн талаарх өөрийн зарим бүрэн эрхийг хязгаарласан нь төсвийн алдагдал, өр зээлийг багасгахад чиглэсэн том алхам болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно” гэж заасны дагуу Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлага нэмэгдсэн. Иймд УИХ-ын чиг үүргийн хүрээнд төсвийн хяналтыг сайжруулж алдагдалгүй, өр үүсгэдэггүй төсөвтэй болоход чиглэсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дуу хоолой нэмэгдэж байгаа юм.

Хэдийгээр төсвийн орлого уул, уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны гадаад худалдааны үнэ, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдэж байгаа ч гэсэн ханш, үнэ хэвийн байдалд орох үед орлого дагуулан өсгөсөн зардлыг

бууруулахад хүндрэл үүсэх эрсдэлтэй юм. Үүнээс сэргийлэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зардлын хязгаарыг тогтоосон шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулах нь зүйтэй гэж үзэж байна. ТТБЗ-өөс төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 28-30 хувиас ихгүй байхаар төсвийн төслийг боловсруулах нь зохимжтой гэсэн саналтай байна.

2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрийн үйл ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд нийт 8 удаа хуралдаж дараах хуулийн төсөлд санал, зөвлөмж гарган зөвлөлийн дүрэмд зааснаар хараат бус, бие даасан үнэлгээ, дүгнэлт гаргах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

2.1 Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголын төсөлд өгсөн санал

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 2022 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа зарим төсөл, арга хэмжээний талаар санал, зөвлөмж хүргүүлсэн. Санал, зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. Нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг зорилтот бүлэгт зориулан хэрэгжүүлэх замаар дундаж цалингаас доош орлоготой иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам тогтоохыг дэмжиж байна. Тэгэхдээ нэг сая төгрөгөөс доош, эсвэл цалингийн доод хэмжээг 50 хувиар нэмэгдүүлсэн, эсвэл 800 мянган төгрөг дээр нэмэх 10 хувийн цалингаас доош цалинтайд хамаарахаар заах уу гэдгийг тооцохын хамт хугацааг сайтар бодож, зөвхөн энэ оны 5-12-р сараар хязгаарлаж чадах эсэхтэй холбож үзэх;

2. Хүүхдийн мөнгийг хуримтлал, хадгаламж хэлбэрээр байлгаж, харин хүсэлт гаргасан дунджаас доош орлоготой иргэдийн хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгох;

3. Урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын зардлыг эрэмбэлж, нэн шаардлагагүй зардлыг хасаж байгааг дэмжиж байгаа бөгөөд төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн орлого бүрдэлтийн хэмжээнд багтаан санхүүжилт хийхийг Засгийн газарт зөвшөөрөх.

2.2 Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн санал, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-ийн хэрэгжилт болон “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн төсөл”-тэй Төсвийн тогтвортой байдлын Зөвлөл танилцаад санал, дүгнэлтийг 2022 оны 05 дугаар сарын 17-ны хурлаар хэлэлцэн тохирсныг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Дүгнэлт, санал, зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. Монгол Улсын нэгдсэн төсвийг 2023 оноос эхлэн алдагдалгүй болгохоор төсвийн төсөл, төсөөлөлд тусгах;

2. Орлогыг өөдрөгөөр төсөөлж төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагууд болох тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал болон өрийн хязгаарт тулган төсөөллийг хийж байгаа нь орлого буурахад тусгай шаардлагууд зөрчигдөх эрсдэл үүснэ. Тиймээс орлогын өсөлтийг дагуулж зарлагыг нэмэхгүй байхыг санал болгосон;

3. Төлөвлөгөөт хугацаанд төлөгдөх хуваарьтай гадаадаас босгосон бондын 20-оос доошгүй хувийг төлж, үлдэх хэсгийг дахин санхүүжүүлэх арга хэмжээ авах;

4. Өрийн удирдлагын стратегид тусгасан гадаад зээлийн төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжилтийн эрх нээх, нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлэх, тайлагнахад анхаарах.

2.3 Төсөв, татварын асуудлаар зарим аймгуудад хийсэн судалгааны ажил

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Төсвийн тухай хууль, Татварын хуулиуд болон Шинэ сэргэлтийн бодлогын орон нутаг дахь хэрэгжилт, түүний үр дагаврын талаар Өвөрхангай, Архангай, Завхан аймгуудад судалгаа хийсэн. Судалгааны ажилд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, ажлын хэсгийн ахлагч Д.Даваасамбуу, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний референт Б.Одмандах, С.Тэгшжаргал нар ажилласан. Судалгааны ажлын хүрээнд Төсвийн тухай Монгол Улсын хууль, Татварын хуулиуд болон “Шинэ сэргэлтийн бодлого” хөдөө, орон нутагт хэрэгжиж буй байдал, түүний үр дүнгийн талаар анкетын судалгаа авч, эдгээр хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн талаар Өвөрхангай, Архангай, Завхан аймгийн төв болон Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагууд, төсөв, татвар хариуцсан мэргэжилтнүүд, мөн орон нутаг дахь Монголбанк, Арилжааны банкны удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзаж, мэдээлэл өгч, санал солилцож, фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хүн амын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар сум, аймгийн төсөвт ордог болсныг илүүтэй ашиглаж нэмэгдэл орлого олбол түүнийг орон нутагт үлдээх, нөгөө талаас зардал хэмнэх урамшууллын хөшүүрэг бий болгохын чухлыг тэмдэглэж байв.

Мөн судалгааны явцад арилжааны банк, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, бизнес эрхлэгчид болон иргэдийн төлөөллөөс авсан анкет судалгаанд нийт 66 хүн хамрагдсан байна. Судалгааны санал, дүгнэлтийн хэсгээс товч дурдвал:

1. Уулзалт ярилцлагын үр дүнгээс үзэхэд цар тахлын дараах худалдаа, бизнесийг сэргээх эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг хангахад зээллэг голчлон чиглэгдсэн байна. Харин цаашдаа нийт зээлдэгчдээс наад зах нь тухайн аймагт бусад салбарыг дагуулаад явах 2-3 томоохон зээлдэгчдийг олж, бүх талаас нь дэмжих нь зарчмын ач холбогдолтой гэдгийг оролцогчид онцлон тэмдэглэж байв.

2. Зам харилцаа, интернэт үйлчилгээ, цахилгааны хангамж харьцангуй сайжирсан байна. Аймгийн хэмжээний үйлдвэрлэлийн дулаан, уур, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээг бий болгож чадвал арилжааны банкнуудын

зүгээс үйлдвэрлэл, технологийг дэмжих зээл олгох боломж илүүтэй нэмэгдэхээр байна.

3. ТТБЗ-өөс санал болгож буй баялгийн сангийн тодорхой хэсгийг албан журмын үндсэн дээр хуулиар хүүхдийн болон өндөр насны хадгаламж хэлбэрээр банкинд хуримтлуулах нь нийт эдийн засгийг урт, дунд хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болгохын зэрэгцээ хүн амын хадгаламжгүй, өнөө маргаашаа аргацааж буй хэсгийн ирээдүйн амьдралын баталгааг бий болгож, аз жаргалтай, эрүүл амьдралыг бодит утгаар нь хэрэгжүүлэх боломжтойг ихэнх арилжааны банкныхан, бизнес эрхлэгчид талархан дэмжиж байсныг тэмдэглэе.

4. Улсын төсвийн эх үүсвэртэй сум хөгжүүлэх зээлийн сан (хоршоо хөгжүүлэх сан болсон), ЖДҮ-ийг дэмжих зээлүүдийг цаашдаа зөвхөн арилжааны банкнуудаар дамжуулан олгож байх шаардлагатай болохыг эдгээрийн эргэн төлөлтийн байдал тун хангалтгүй, бүртгэл мэдээлэл дутмаг зэрэг нь харуулж байгаа юм.

2.4 Монгол Улсын 2023 оны Нэгдсэн төсвийн төсөлд өгсөн зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр УИХ-д өргөн барьсан Монгол улсын 2023 оны төсвийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 10 дугаар сарын 06-ны өдөр дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн. Дүгнэлт, зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. УИХ-аас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд 13 удаа Засгийн газрын хүсэлтийн дагуу өөрчлөлт оруулаад байна. Мөн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг жил бүрийн 5 дугаар сард тогтоогоод дараа жилийн төсөв батлах үедээ өөрчилдөг явдал үргэлжилсээр байна. Иймд төсвийн тогтвортой байдлын тухай 2010 онд батлагдсан хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн тоо баримтуудыг 2 ангилж, заавал мөрдөх болон баримжаа үзүүлэлт хэлбэрээр ялгаж, олон улсын чиг хандлагын дагуу төсвийн хүрээний мэдэгдлээс дунд хугацааны зардлын хүрээний хязгаар болгон шинэчилж, төсөв захирагчдын үүрэг хариуцлага, эрхийг нэмэгдүүлэх асуудлыг судлах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийсэн.

2. 2023 оны төсвийн зарлагын нийт хэмжээ ДНБ-ий 37.6 хувь бөгөөд ийм хэмжээний зарлага хэрэгжихэд валютын нөөц хүрэлцэхгүй. Үүнийг дагаад инфляц ихэснэ. Геополитикийн хурцадмал байдал, баруун Европт болж буй эрчим хүчний хямрал, урд хөршид болж буй үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал гээд гадаад нөхцөл байдал хүнд байхад их хэмжээний өндөр хүүтэй зээл авч, хөрөнгө оруулалт, халамжийг санхүүжүүлж байгааг зогсоох хэрэгтэй.

3. Төсвийн нийт орлого 2023 онд өмнөх оноос их хэмжээгээр буюу 3.3 их наяд төгрөгөөр өсөөд байхад төсвөө алдагдалтай төлөвлөхөөс татгалзах ёстой гэсэн дүгнэлт хийж байна. Баялгаа эрчимтэй ашиглах цаг мөчид буюу Оюутолгойн далд уурхайг ашиглаж эхлэх, нүүрсийг их хэмжээгээр экспортлох боломж гарч буй өнөө үед төсвийн алдагдлыг зогсоож, байнга уламжлан өр тавьдаг явдалд цэг тавих нь цаг үеэ олсон хэрэг болно д орох эрсдэлээс хамгаалах нь чухал.

4. Монгол Улс дотоодод хуримтлуулсан валютын нөөцөөр 2023 онд төлөх гадаад өрийг дарах бололцоогүй тул зайлшгүй өндөр хүүтэй гадаад зээл авах шаардлага үүснэ. Мөн төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан зээл авч халамж тарааж байгааг буруу гэж үзэж байна. Иймд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн үйлдэл хийж, 2023 оны төсвийг алдагдалгүй батлах, эсвэл

алдагдлын хэмжээгээр хүүхдийн мөнгийг хүүтэйгээр хуримтлуулах тогтолцоог бий болгож, төсвийн алдагдлыг үүнээс хэтрүүлэхгүйгээр хязгаарлах шаардлагатай гэж үзэж байна.

5. Дэлхий дээрх хямралт нөхцөл байдлаас шалтгаалан үүссэн инфляцыг хязгаарлахын тулд улс орнууд бодлогын хүүгээ нэмж байна. АНУ 2022 онд 5 удаа нэмж хамгийн сүүлд 3.25 хувь болгоод байна. Энэ нь зах зээл дээрх бонд, зээлийн хүүг нэмэхэд хүргэнэ. Иймд 2023 онд төлөгдөх зээлийн дор хаяж 30 хувийг төлж, бусдыг дахин санхүүжүүлэх хэрэгтэй. Олон улсад их хэрэглэгддэггүй аргаар (өнөөгийн үнэ цэнээр тооцох) зээлийн хэмжээг бууруулан тооцож, мэдээллийн зөрүүтэй байдал бий болгохыг эцэслэх нь чухал. Хэрэв төсвийг алдагдалтай баталж өр тавих тохиолдолд зээлийн 50-иас доошгүй хувийг экспортыг дэмжих, импортыг орлох төсөлд зарцуулах шаардлагатай.

6. Улсын төсвөөс урьд жилүүдэд ДНБ-ий 4%-ийн хэмжээний санхүүжилтийг төсвийн хөрөнгө оруулалтад зориулдаг байсныгаа 2023 онд ч баримтлахаар төсөвт тусгажээ. Тэгэхдээ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь урьд онуудад эхэлж, өмнөх жилээс дараа жилд шилжин олон жил үргэлжилж, захиалагч, гүйцэтгэгч аль алиныг хүнд байдалд оруулахын зэрэгцээ дараа жилийн төсвийн зарлагыг өсгөх, үнийн өсөлтөөс төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх зэрэг олон хүндрэл үүсдэг байсан бэрхшээлийг багасгах, арилгах, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн Засгийн газар төсвийн хөрөнгө оруулалтын төслийг боловсруулсан байна. Хэдийгээр шинэ сэргэлтийн бодлого, том төслүүд (Нефтийн үйлдвэр, Дарханы зам, төмөр замууд, цахилгаан станцууд) болон 2023 оны төсөвт тусгагдсан дуусаагүй он дамжсан хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэхийг дэмжиж байгаа боловч эдгээртэй зэрэгцүүлэн олон төсөл, хөтөлбөр эхлүүлэх нь бараа, бүтээгдэхүүний эрэлтийг ихээр нэмэгдүүлж инфляц, валютын нөөц, төмөр замын хүчин чадал, цементийн хүчин чадалд ихээр нөлөөлж байгаа тул эдгээрийг эрэмбэлж шат дараатай эхлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

7. Ирээдүйн өв сан болон төсвийн тогтворжуулалтын сангуудад орлого төвлөрүүлэхийг хойшлуулах биш, тэдгээр санд төвлөрөх хөрөнгийг хүүхдийн хуримтлалын данс болон ажил эрхлэгчдийн ирээдүйн тэтгэврийн нэмэгдэл болгохоор тэдний нэр дээр хуримтлуулж, системийн ач холбогдолтой банкуудад жирийн хадгаламжийн хэлбэрээр байрлуулах хэрэгтэй.

8. Бүх төрлийн бэлэн ба бэлэн бус гүйлгээний орлого, зарлагыг заавал бүртгэдэг хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, улсын нэгдсэн мэдээллийн санд оруулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, зарлагын талаар улсын хэмжээний тайлан мэдээлэлтэй болж, хүн амын амьжиргааны түвшинг тогтоож, түүнийг харгалзан нийгмийн бүх төрлийн үйлчилгээ, халамж, тэтгэмж, тэтгэлэг, татварын болон бусад хөнгөлөлтүүдийг олгодог Үндсэн хуулийн зарчим, олон улсын жишгийг мөрдүүлэх шаардлагатай байна.

2.5 Төсөвтэй холбоотой бусад хууль, тогтоомжийн төсөлд өгсөн санал

Тэтгэврийн хувийн даатгалын тогтолцоог судалж, судалгааны урьдчилсан үр дүнг гаргасан бөгөөд Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороодод хүргүүлсэн. Цаашид нарийвчилсан судалгаа хийгдэж байна.

2.6 ТТБЗ-өөс өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс жилийн төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн дүгнэлт, зөвлөмжөө Сангийн яаманд хүргүүлдэг. Тус зөвлөлөөс 2021, 2022 онд гаргасан чухал санал, зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдлын талаар Сангийн сайдаас мэдээлэл хүлээн аваад байна. Зөвлөмжийн хэрэгжилт (Хавсралт 1)-ийн хэсгээс товч дурдвал:

№	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
1	Монгол Улсын нэгдсэн төсвийг 2023 оноос эхлэн алдагдалгүй болгохоор төсвийн төсөл, төсөөлөлд тусгах	<p>Монгол Улсын Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэж заасны дагуу жил бүр үе шаттайгаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг хуулийн дагуу бууруулан ажиллаж байна.</p> <p>2023 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн алдагдлыг 1,553.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувьтай тэнцүү байхаар төлөвлөсөн нь төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаас 0.8 хувиар, өнгөрсөн жилийн алдагдлаас 833.7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна.</p>
2	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг эцсийн дүндээ төсөв хариуцах учраас төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа Сангийн сайдын зөвшөөрлийг заавал авдаг болох. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж Сангийн яам, УИХ-д ирүүлдэг байх. Төр, хувийн хэвшлийн төслийг ил тод байлгах ёстой ба гэрээтэй холбогдсон аливаа зүйлийг гэрээлэгч-байгууллагын нууцад хамааруулахгүйгээр гэрээ байгуулагдмагц	<p>Засгийн газрын 2021 оны 36 дугаар тэмдэглэлийн дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн төслийг шинээр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж хуулийн төслийг боловсруулав. Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын дагуу хуулийн тандан судалгаа, концессын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаа болон олон улсын харьцуулсан судалгааг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулж, хуулийн төслийг өргөн барихад холбогдох зөвшөөрлүүдийг авахаас гадна УИХ-ын ажлын хэсэг, хувийн хэвшил, олон нийт, олон улсын байгууллагуудын дунд хэлэлцүүлгүүд зохион байгуулж, хуулийн төсөлд санал авч, ирүүлсэн саналыг тусгасан.</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, 2022 оны 6-р сарын 3-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг гишүүдийн 72.8 хувь нь дэмжсэн. Хуулийн төслийг УИХ-ын 2022 оны намрын чуулганаар хэлэлцүүлэн</p>

	нийтэд мэдээлж, УИХ-д хүргүүлж байх.	батлуулахаар төлөвлөж байна. Хуулийн төсөлд төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахад Сангийн сайдаас зөвшөөрөл авч байх, тайланг Сангийн яам болон УИХ-д ирүүлдэг байх, төр, хувийн хэвшлийн төслийг ил тод байлгах, нууцын зэрэглэлээс бусад гэрээг олон нийтэд мэдээлж байх заалтыг оруулсан.
3	Макро-эдийн засгийн гол үзүүлэлт бол Монгол орны хувьд төлбөрийн тэнцэл мөн гэж үзэж, төлбөрийн тэнцлийн байдалд жил бүр судалгаа хийж, түүнд үндэслэн төсвийн болон макро-эдийн засгийн төсөөлөл хийж байх	Төсвийн төслийг боловсруулахад шаардлагатай эдийн засгийн дотоод ба гадаад орчны болон түүхий эдийн дэлхийн зах зээлийн төлөв байдлын шинжилгээг хийж, төсвийн төсөлд тусган ЭЗХЯ, Монголбанк, Уул уурхайн компаниудын холбогдох талуудтай хэлэлцэн, төсвийн төсөлд ашигласан макро эдийн засгийн болон төлбөрийн тэнцлийн төсөөллийг гаргасан. Тухайлбал зэс, газрын тос, нүүрсний дэлхийн зах зээлийн талаар судалж, дотоодын экспортлогч томоохон үйлдвэрүүдийн 2023 оны төлөвийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Харин төлбөрийн тэнцлийн төсөөллийг Монголбанк, ОУВС-тай эдийн засгийн нөхцөл байдлын талаар удаа дараагийн хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр Монголбанкны төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцийн суурь төсөөллийг авч ашигласан.

2020, 2021 онд гаргасан чухал 11 зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн ТТБЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Эдгээрийн хэрэгжилтийг гаргуулахаар 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр 76 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлсэн. ТТБЗ-өөс өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн сайд 10 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн бөгөөд тус зөвлөмжүүдийн ихэнх нь хэрэгжиж байгаа гэсэн мэдээллийг ирүүлээд байна.

3. ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1 Татварын боловсрол олгох үндэсний хөтөлбөр

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Монгол Улсын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Татварын боловсрол олгох үндэсний хөтөлбөрийн загвар боловсруулах чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд Татварын боловсрол олгох нэгдсэн тогтолцоог бий болгон хөгжүүлж, бэхжүүлэхэд чиглэсэн 4 зорилт дэвшүүлж, 05 дугаар сарын 26-ны өдөр “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний анхдугаар зөвлөгөөнийг ТТБЗ, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Монголбанк, Боловсролын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн нийгэмлэг, Боловсролын мэдээлэл технологийн төв, Их дээд сургуулиудын төлөөлөл бүхий 100 гаруй хүнийг оролцуулан зохион байгуулав. Зөвлөгөөнд оролцогчид бүгд хамтран ажиллахаар санал нэгдсэн. ТТБЗ-өөс илгээлт (Хавсралт 2) хүргэж, татварын талаар зарим санаа, мэдээлэл өглөө. Тухайлбал, Татварын боловсролыг нийт хүн ам, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд системтэйгээр олгох нь манай орны хувьд тулгамдсан зорилт болсныг мэдээлэв. Мөн шударга ёс, ухаалаг, жаргалтай амьдралыг татварын зөв тогтолцоо, ёс зүйтэй нийгэм, хуулийн мөрдөлтөөр хангадаг болохыг олон улсын шилдэг туршлага харуулж байна. Монгол

Улсын Үндсэн хуулиар иргэдэд хүлээлгэсэн хууль сахих, бусдыг хүндлэх, татвар төлөх, эх орноо хамгаалах дөрвөн үүргийг онцгойлон заажээ. Татвар төлөх нь угаасаа хүний нийгмийн хөгжил дэх төрт улсын үндсэн шинж бөгөөд өдгөө тогтвортой хөгжлийн суурь эх үүсвэр юм.

3.2 “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлэг

Монгол Улсын Их Хурал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Төрийн ордонд “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг нээж Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Олон Улсын Валютын сангийн суурин төлөөлөгч Юн Сок Хёнг нар дэлгэрэнгүй үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Э.Бямбажав, Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар илтгэл тавьсан. Энэхүү хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Баттөмөр, Ж.Батсуурь, Ж.Батжаргал, Б.Пүрэвдорж, С.Бямбацогт, Х.Булгантуяа, Д.Ганбат, Г.Амартүвшин, Х.Ганхуяг, Д.Сарангэрэл, Т.Доржханд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, олон улсын байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, төр захиргааны байгууллагын ажилтнууд оролцов.

УИХ-ын дарга Г.Занданшатар: хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ өнгөрөгч гуравдугаар сард танилцуулсан төлбөрийн тэнцлийн мэдээллийг дахин сануулав. Тэрбээр, нийгэм, эдийн засгийн гол асуудлуудын үндсэн зангилаа нь төлбөрийн тэнцэл болсныг онцлоод манай улс сүүлийн 10 гаруй жилийн турш төлбөрийн тэнцэл, урсгал дансны хос алдагдалтай явж ирсэн нь эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгож, өр үүсэх үндсэн шалтгаан болсон гэдгийг тэмдэглэлээ. Урсгал төлбөрийн тэнцлийн алдагдал сүүлийн 10 жилийн дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 19.5 хувьтай тэнцэж байгаа нь гадаад өр нэмэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл юм. Нөгөө талаар эдийн засгийн өсөлт хүртээмжгүй байгаагаас ядуурал дорвитой буурахгүй байна. Хэдийгээр манай улс сүүлийн 14 жилийн хугацаанд гадаад худалдааны нийт 4.7 тэрбум ам.долларын ашигтай байсан боловч урсгал дансны үйлчилгээний тэнцлээр -15.5 тэрбум, анхдагч орлогын тэнцлээр -14.9 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан нь нийт урсгал данс 28.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарахад хүргэсэн байна. Өөрөөр хэлбэл, энэ алдагдлыг гадаад өрөөр санхүүжүүлсэн буюу энэ хугацаанд гадаад өр мөн хэмжээгээр буюу 27.1 тэрбум ам.доллароор өсжээ. Манай улс сүүлийн 14 жилд зэсийн экспортоос 21.4 тэрбум, нүүрснээс 22 тэрбум, нефтиэс 4.4, алтнаас 7.1, төмрийн хүдрээс 5.8 тэрбум ам.доллар буюу нийт экспортын 73.8 тэрбум ам.долларын орлого олсон. Гэвч нөгөө талдаа энэ хугацаанд хүнс 7.1 тэрбум, автомашин 5.1, бензин шатахуун 13.5 тэрбум гэх мэт нийт 69.1 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн импортолж, үүний дээр гадаад улсуудад тээврийн үйлчилгээнд 3.2 тэрбум, аялал жуулчлалд 3.6 тэрбум гэх мэтээр нийт 15.5 тэрбум ам.доллар үйлчилгээний төлбөр төлжээ. Эдгээр үүссэн өр төлбөр нэмэгдэхийн хэрээр гадагшаа зээлийн хүү, хөрөнгө оруулалтын ногдол ашигт төлдөг төлбөр нэмэгдсээр байна. Тухайлбал, өнгөрсөн 14 жилийн хугацаанд зээл, бондын хүүд 6.4 тэрбум ам.доллар, хөрөнгө оруулалтын ногдол ашиг, хүүгийн төлбөрт 7.8 тэрбум ам.доллар төлсөн байна.

УИХ-ын дарга Г.Занданшатар, “Монгол Улсад үүсээд буй төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал, үүнээс үүссэн гадаад өрийн эмзэг байдлыг шийдэх гарч

бол Үндэсний хуримтлал болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц бодлого гэдгийг онцоллоо. Үүнийг хэрэгжүүлэхэд засаглалыг бэхжүүлэх, түүний тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх нь нэн тэргүүний асуудал. Үүнд эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, хариуцлага ил тод байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Улсын төсөв бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдээ зөв эрэмбэлэх шаардлага тулгарч байна. Үүнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зөвлөлдөх ардчиллыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй. Түүнчлэн хууль, эрх зүйн шинэчлэл хийх замаар бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж чадсанаар дотоодод ажил эрхлэлт, үйлдвэрлэл нэмэгдэхэд түлхэц болно. Ингэснээр үндэсний хуримтлал бүрдэж, макро эдийн засаг тогтворжино. Улмаар иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, өсөлт илүү хүртээмжтэй болж, ядуурал буурах боломж бүрдэнэ” гэлээ.

Сангийн сайд Б.Жавхлан: 2022 оны 5 дугаар сарын байдлаар Монгол Улсын нийт гадаад өр 33.8 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнээс Засгийн газрын өр 8.5 тэрбум ам.доллар, Монголбанкны өр 2.6 тэрбум ам.доллар, арилжааны банкуудын өр 1.7 тэрбум ам.доллар, шууд хөрөнгө оруулалт буюу компани хоорондын зээллэг 12.3 тэрбум ам.доллар, аж ахуйн нэгжүүдийн өр 8.2 тэрбум ам.доллар байна. Гадаад валютын албан нөөц ойролцоогоор улсын нийт гадаад өрийн 10 орчим хувьтай тэнцсэн. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээг хөгжиж буй орнуудын өрийн хязгаарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад 2-3 дахин их байгааг Сангийн сайд Б.Жавхлан “Гадаад өрийн удирдлага, цаашдын зорилго” сэдвээр танилцуулсан илтгэлдээ дурдсан.

Засгийн газраас 2012 оноос хойш 3-10 жилийн хугацаатай Чингис, Дим сам, Мазаалай, Хуралдай, Гэрэгэ, Номад, Сенчири зэрэг нийт долоон бонд гаргасан байдаг. Засгийн газрын өр 2021 онд 26.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнийг өнөөдрийн үнэ цэнээр тооцвол ДНБ-ий 50.8 хувьтай тэнцэх болжээ. Өрийн бүтцийн хувьд 2016 онд Засгийн газрын өрийн 52 орчим хувь нь арилжааны нөхцөлтэй зээл байсан бол 2021 оны байдлаар 33.6 хувь болтол бууруулжээ. Харин Засгийн газрын зээлийн ашиглалтыг авч үзвэл 40 орчим хувийг барилгын салбарт, 26 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад, 14 орчим хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байгаа бол 13 орчим хувийг зөвлөх үйлчилгээнд зарцуулжээ. Цаашид Засгийн газраас мөчлөг сөрсөн өрийн удирдлагын менежментийг хэрэгжүүлнэ гэж байгаа. Ялангуяа донор улсуудаас, хөгжлийн түншүүдээс авдаг зээлийг аль болох багасгана. Одоо байгаа зээлүүдийн ашиглалтынх нь үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлого чиглэл барьж байна. Олон талт хөгжлийн түншүүдээс авах зээлийн хөтөлбөр, зээлийн ашиглалтыг зөвхөн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд, өөрөөр хэлбэл УИХ-аас баталсан хөрөнгө оруулалт, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд баталсан хөрөнгө оруулалтуудын хүрээнд л ашиглана гэсэн хатуу бодлого баримтална гэдгийг Сангийн сайд танилцуулав.

ОУВС-ийн Суурин төлөөлөгч Юн Сок Хёнг: Олон улсын валютын сангаас Монгол Улсын эдийн засгийг өмнө нь долоон хувиар өснө гэж тооцоолж байсан бол нэг хувь болгож бууруулсан. Олон улсын валютын сан 2022 оны эдийн засгийн төлөв, нөхцөл байдлын тооцооллыг хийж байхдаа экспорт эрчимтэй сэргэж, эдийн засгийн тэлэлтийн жил болно гэж өнгөрсөн онд тооцоолж байсан. Хэдий тийм боловч таамаглаж байгаагүй ОХУ болон Украины асуудал, мөн БНХАУ-д “коронавирус”-ийн халдварын тархалт нэмэгдэж, хатуу хөл хорио тогтоосон нь нөхцөл байдлыг өөрчилсөн. Монгол Улсын эдийн засагт гадаад орчинд өрнөж буй “шок”-уудад маш өртөмтгий, эмзэг байгаа учраас цаашид төсвийн бодлогыг сайжруулж, зарцуулалтаа танах хэрэгтэй. Төсвийн дэмжлэгийг зөвхөн дэмжлэг

авах шаардлагатай, зорилтот бүлгийн иргэдэд олгох нь зүйтэй гэдгийг Олон улсын валютын сангийн Суурин төлөөлөгч Юн Сок Хёнг тэмдэглэсэн юм.

Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат: Үндэсний аудитын газраас 2018-2020 оны байдлаарх шинээр олгосон болон үргэлжилж буй гадаад зээл, тусламжийн ашиглалтад аудит хийсэн. Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ 2018 онд өмнөх оноос 22.3 хувиар, 2019 онд 14.3 хувиар, 2020 онд 28.9 хувиар тус тус өсжээ. Нийт авсан зээлийн 44 орчим хувь нь төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсан бол 16.5 хувь нь зам тээвэр, 7.2 хувь нь эрчим хүч, 5.3 хувь нь усан хангамж, хотын дэд бүтэц, 4.6 хувь нь эрүүл мэнд, 2.5 хувь нь боловсролын салбарт зарцуулагджээ. Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагын зээлээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүй. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн нь нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бууруулсан, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдахгүй байгааг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат тавьсан илтгэлдээ онцолсон.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Э.Бямбажав: Манай улсын эдийн засгаа дэмжих, тэлэх зорилт, дотоод гадаад өрөөр санхүүжүүлэх бодлого нь “өртэй, эмзэг эдийн засаг”-т хүргэж байгааг тэмдэглээд төсвийн урхагшсан алдагдал нь өр зээл өсөх суурь шалтгаан болсоор Монгол Улсыг гадаад өрийн шалгуур үзүүлэлтүүдээр дефолт болох эрсдэлтэй 10 улсын тоонд оруулж байгаа гэдгийг анхаарууллаа. Мөн манай улсын гадаад өрийн удирдлагыг сайжруулахад одоогийн хууль, журам, стратегийг өөрчлөх шаардлагатай. Тодруулбал, гадаад зээлийг цаашид экспортыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд ашиглах хэрэгтэй. Ингэхдээ тухайн зориулалтаар төлөвлөгөөт хугацаанд гаднаас авах зээлийн хатуу хязгаарыг тогтоож, мөрдөх нь зүйтэй гэлээ. Түүнчлэн гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь өөрийн үйл ажиллагаа, орлого, ашгаараа зээлийн төлбөрөө гүйцэтгэх чадвартай байгаа нөхцөлд гаднаас зээлийн эх үүсвэр татах хатуу зарчмыг хуульчлах, хэрэглээ болон халамжийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхийг хориглох эрх зүйн орчин хэрэгтэйг онцлон тэмдэглэсэн.

Хэлэлцүүлэгт оролцогчид валютын гадагшлах урсгалыг хязгаарлах, дотогшлох урсгалыг нэмэгдүүлэхийн тулд жил бүр төлбөрийн тэнцлийн байдалд судалгаа хийж, түүнийг үндэслэн төсвийн болон макро эдийн засгийн төсөөлөл хийх хэрэгтэйг хэлж байлаа. Мөн Монгол Улсын төсвийг алдагдалгүй болгож, төсвийн хяналтыг чангатгаж, шалгуур үзүүлэлтүүдийг хатуу мөрдөж ажиллах замаар Засгийн газрын өрийн түвшинг багасгах, экспортод чиглэсэн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжих, экспортын даатгалын санг байгуулах, гадаад хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн таатай орчинг бий болгох хэрэгтэй талаар байр сууриа илэрхийлж байлаа. Түүнчлэн батлан гаргасан хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах асуудлыг ч хөндлөө. Хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн санал, зөвлөмж (Хавсралт 3)-ийн хэсгээс товч дурдвал:

1. Макро-эдийн засгийн гол үзүүлэлт бол Монгол орны хувьд төлбөрийн тэнцэл мөн гэж үзэж, төлбөрийн тэнцлийн байдалд жил бүр судалгаа хийж, түүнд үндэслэн төсвийн болон макро-эдийн засгийн төсөөлөл хийж байх;

2. Үндэсний аудитын газрын илтгэлд дурдсанаар 2018-2020 онд Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд (хөтөлбөрийн зээл ороод) зориулсан нь Засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Иймд Монгол Улсын төсвийг алдагдалгүй баталж, төсвийн хяналтыг

чангатгаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хатуу мөрдөж ажиллах замаар Засгийн газрын өрийн түвшинг багасгах;

3. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээний ДНБ-тэй харьцуулсан харьцаа хөгжиж буй орнуудын өрийн хязгаар үзүүлэлтээс 2-3 дахин их байгаад дүгнэлт хийж, хувийн хэвшлийн болон Засгийн газрын өрийг багасгах, ялангуяа өндөр хүүтэй зарим компани хоорондын хөрөнгө оруулалтын зээл, бонд зэргийг өнөөгийн үнэ цэнээр хямдруулан тооцохгүй байх, хүүг нь багасгах, зогсоох арга замыг олж шийдэх, гадаад дотоод зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эргэн төлөлтийг оновчтой шийдэх;

4. Үндэсний хуримтлал болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх. Үндэсний хуримтлал, ажиллах хүчний оролцооны түвшин бусад орнуудтай харьцуулахад нэн доогуур байгаа нь суурь асуудал бөгөөд өр үүсэх үндсэн шалтгаан юм. Төсөв, мөнгө болон эдийн засгийн бодлогын хэрэгслийг юуны түрүүнд дотоод хуримтлал бий болгох, цаашлаад хөрөнгө оруулалтын урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглүүлэх замаар гадаад зээлийн хэрэгцээг багасгах. Монгол Улсын түүхий эд, хүн хүчний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, үүний дотор ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх;

5. Экспортлогчдыг төрөөс тусгайлан дэмжих хэрэгтэй гэдэгт бүгд санал нэгдэж, экспортыг дэмжих олон улсын сайн жишиг болсон механизм, арга хэрэгслийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх. Экспортод чиглэсэн үйлдвэрлэгчдийг тэргүүн байранд тавьж, бүх талын туслалцаа үзүүлэх, экспортыг хааж боогдуулдаг аливаа шийдвэр нь үндэсний эрх ашигт үл нийцэх бөгөөд ийм үйлдэл гаргахгүй байхыг уриалж, зах зээл судлал, үнэ, тарифын орчин, реклам сурталчилгааг эрс сайжруулж, төрийн дэмжлэг үзүүлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн батлан даалт, экспортын санхүүжилтийн болон даатгалын сан, холбогдох арга хэрэгслийг бий болгох.

3.3 Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн хэрэгжилт

Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн Удирдах Хорооны 2022 оны 05 дугаар сарын 27-ны 2021/02 тоот тогтоолоор батлагдсан тус төслийн 2022-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Макро эдийн засаг, төсвийн удирдлагыг бэхжүүлэх 1 дүгээр хэсгийн нэг дэх дэд бүрэлдэхүүний заалт (1.1)-ээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (цаашид “ТТБЗ” гэх)-ийн чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд нийт 3 арга хэмжээг баталсан. Тус арга хэмжээнүүдийн хүрээнд:

1. Макро эдийн засгийн төсөөллийн хэрэгсэл/загвар хөгжүүлэх, эрх зүйн орчин, ТТБЗ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндэсний зөвлөхийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ажиллуулсан.

2. Улсын Их Хурлын зарим гишүүд, Улсын Их Хурлын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, түүний ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамны төлөөлөл бүхий нийт 9 төлөөлөгч Бүгд Найрамдах Австри улсын Төсвийн зөвлөл, Парламентын төсвийн оффис, Сангийн яам, Төрийн үйлчилгээ, соёл, спортын яам, Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах “Төсвийн дүрэм, гүйцэтгэл, хяналт” сэдэвт сургалт-айлчлалыг 2022 оны 08 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Уг сургалт-айлчлалын зорилго нь Австри улсын төсвийн шинэчлэл, гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт, макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөл боловсруулах аргачлал, үйл явц, төсвийн дүрмийн мониторинг, гүйцэтгэлийн хяналт, хөндлөнгийн үнэлгээг хэрэгжүүлж буй байдалтай газар дээр нь танилцаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын туршлагаас суралцахад чиглэсэн болно. Сургалт-айлчлалын товч тайланг хавсралт 4-өөс үзнэ үү.

Сургалт-айлчлалын хүрээнд танилцсан байгууллага, үйл ажиллагааны чиглэл

Сангийн яам: Сургалт-айлчлалын хөтөлбөрт тусгагдсаны дагуу эхний өдөр Австри улсын Сангийн яамны төсвийн 2 дугаар газрын ахлах зөвлөх Бенедикт Гамиллшег “Аккруэл бүртгэл, төсвийн гүйцэтгэл, тайлагнал”, мөн “Гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт” сэдвээр танилцуулга хийж, Монголын төлөөлөлтэй харилцан ярилцав. Энэ хүрээнд Австри улсын засаг захиргааны болон төсвийн бүтэц, хууль эрх зүйн зохицуулалт, төсвийн үйл явц, түүний цаглавар, төсвийн үйл явцад оролцогчдын оролцоо, хамтын ажиллагаа, аккруэл нягтлан бодох бүртгэл, тайлагнал, гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үзүүлэлт ба төсвийг уялдуулах талаар салбарын сайд нарын хүлээх үүрэг хариуцлага, төсөвт тулгамдаж буй асуудлыг тодорхой танилцуулж сургалт-айлчлалд оролцогчдын асуултад хариулж, харилцан мэдээлэл солилцсон.

Эдийн засгийн судалгааны хүрээлэн: Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн Макро эдийн засаг ба Европын эдийн засгийн судалгааны нэгжийн ахлах эдийн засагч Ханс Питлик хүрээлэнгийнхээ үйл ажиллагааны талаар, мөн “Төсвийн төсөөлөл боловсруулах нь” сэдвээр дэлгэрэнгүй танилцуулав. ЭЗСХ нь 1927 онд Бизнесийн мөчлөгийн дүн шинжилгээ хийх институт байдлаар анх байгуулагдсан, Ханс Питлик тус байгууллагад 16 жил ажиллаж байна. ЭЗСХ нь үйл ажиллагаагаа 5 бүлэгт хувааж ажилладаг. Тухайлбал, 1) Макро эдийн засаг ба Европын эдийн засгийн судалгаа, 2) Хөдөлмөрийн эдийн засгийн судалгаа, 3) Аж үйлдвэр, инновацын бодлого, 4) Бүтцийн өөрчлөлт, бүс нутгийн эдийн засаг, 5) Байгаль орчны эдийн засаг, эрчим хүч, хөдөө аж ахуй. Эдгээрээс Макро эдийн засаг ба Европын эдийн засгийн судалгааны бүлэг нь улсын салбарын эдийн засгийн судалгааг хийж, төсвийн төсөөлөл боловсруулах ажлыг хариуцаж ажилладаг байна. Тус хүрээлэнд 100 орчим хүн, үүнээс 60 хувь нь судлаачид ажилладаг. Ханс Питлик ЭЗСХ-гийн зүгээс төсвийн төсөөллийг хэрхэн боловсруулж, төсвийн орлого, зарлагын богино, дунд хугацааны төсөөллийг хийдэг, мөн эцсийн үр дүнгээ хэрхэн дүгнэж, олон нийтэд түгээдэг талаар танилцуулж асуулт, хариулт өрнүүлэв.

Төсвийн зөвлөл: Австрийн Төсвийн зөвлөлдөх зөвлөлийн Ажлын албаны эдийн засагч Алена Бачлейтнер биднийг хүлээн авч, “Төсвийн дүрмийн мониторинг”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Төсвийн зөвлөлийн чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, төсвийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тайлагнал, төсөөлөл боловсруулах арга зүй, тулгарч буй сорилт, сургамжийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, сургалт-айлчлалд оролцогчдын асуултад хариулж, харилцан мэдээлэл солилцсон. Төсвийн зөвлөлийн цахим хуудсанд тус зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авах боломжтойг тайлбарласан болно (<https://www.fiskalrat.at/en/organization.html>).

Төрийн үйлчилгээ, соёл, урлаг, спортын яам: Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Засгийн газрын Урлаг, соёл, төрийн алба, спортын яамны Холбооны Гүйцэтгэлийн удирдлагын албыг төлөөлж Роман Шнейдер 2022 оны 8 дугаар сарын 18-ны өдөр гарцад буюу гүйцэтгэлд суурилсан үнэлгээний талаар илтгэл тавьсан. Тэрээр “Гүйцэтгэлийн хяналт ба гүйцэтгэлд суурилсан төсөв”, “Хөтөлбөрийн

мониторинг ба үнэлгээ”-ний асуудлаар дэлгэрүүлэн тайлбарлаж, асуултад хариулж, ярилцав.

Парламентын төсвийн алба: Австрийн Парламентын төсвийн албаны ажилтан Petra Gschiel, Markus Riegler нар “Австрийн парламентын төсвийн хяналт дахь Парламентын төсвийн албаны үүрэг” сэдвээр танилцуулга хийж, Австрийн төсвийн үйл явцад Парламентын гүйцэтгэх үүрэг, төсвийн мөчлөг дэх Үндэсний зөвлөлийн төсвийн эрх мэдэл, Парламентад төсвийг хэлэлцэн батлах үйл явцын онцлог, Төсвийн байнгын хорооны үйл ажиллагаа, Парламентын төсвийн албыг байгуулсан үндэслэл, холбогдох баримт бичгүүд, ПТА-ны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, мандат, үзүүлж буй үйлчилгээ, судалгаа, шинжилгээний ажлын каталог, хийдэг төсвийн шинжилгээний бодит жишээ, ашигладаг эдийн засгийн загварууд, зардлын тооцоолол, төрөөс хэрэгжүүлсэн бодлогын хуваарилалтын болон эдийн засаг, байгаль орчны үр нөлөөг тооцсон жишээ баримт, Парламентын зүгээс төсвийн засаглалыг сайжруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй тайлбарлаж ярилцсан болно.

Сургалт-айлчлалд оролцогчид хөтөлбөрт тусгагдсаны дагуу *Вена дахь Дэлхийн банкны оффист* зочилж, Санхүүгийн тайлагналын шинэчлэлийн төв (Centre for Financial Reporting Reform <https://cfr.worldbank.org/programs/pulsar>)-ийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан мэдээлэл солилцлоо. Уулзалтын хүрээнд Европын болон Төв Азийн улсуудад зөвлөгөө өгдөг тус төвөөс хэрэгжүүлдэг үйл ажиллагаа болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын хөтөлбөрүүд болох PULSAR, EduCop, STARER, FASE, REPARIS зэрэг хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв.

Сургалт-айлчлалд оролцогчдын бүрэлдэхүүн: Сургалт-айлчлалд хууль батлах, хяналт тавих, гүйцэтгэх түвшний байгууллагуудын төлөөлөл болох УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүн Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн, Зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба хариуцсан референт Б.Одмандах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Д.Балжинням, Синхрон орчуулагч Д.Халиун, СЯ-ны Төрийн сангийн Төлбөр тооцооны хэлтсийн дарга Л.Наранчимэг, СЯ-ны Төсвийн газрын зарлагын хэлтсийн ахлах зөвлөх Т.Батсүх нар хамрагдав.

Сургалтын үнэлгээ: Сургалт-айлчлалд оролцогчдоор Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс тусгайлан бэлтгэсэн сургалтын үнэлгээний хуудсыг бөглүүлсэн бөгөөд үнэлгээ өгсөн оролцогчдын 80 хувь нь энэ удаагийн сургалтыг “маш сайн” гэж үнэлсэн бөгөөд цаашид сургалт-айлчлалын үр дүнг илүү сайжруулахын тулд уулзалт хийсэн байгууллагуудтай тогтвортой харилцаа тогтоож, хамтран ажиллах, мөн холбогдох байгууллагуудаас мэргэжилтнүүдийг урьж Монголд лекц уншуулж туршлагаас нь судлах нь чухал болохыг онцолсон болно.

3.4 “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг

2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороотой хамтран зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нээж үг хэлж, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Андрей Михнев, Монголбанкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Стратеги судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн судалгааны төвийн дарга Н.Энхбаяр,

Үндэсний статистикийн газрын дарга Б.Батдаваа, Нээлттэй нийгэм ТББ-ын дэргэдэх төсвийн зөвлөлийн зохицуулагч Д.Оюунбадам нар илтгэл тавьсан. Илтгэлүүдийн дараа Төрийн байгууллагууд, Мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллагууд, эрдэм судлаачдын төлөөлөл болох 120 гаруй хүмүүсээс зарим оролцогчид санал, дүгнэлт гаргасан.

3.5 “Төсөв-2023” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэг

2022 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороотой хамтран “ТӨСӨВ-2023” сэдэвт хэлэлцүүлгийг холбогдох яам, агентлаг, төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн багш нар, эрдэмтэн судлаачид, олон нийтийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс танилцуулсан зөвлөмж, илтгэлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг Улсын Их Хурлын гишүүд болон олон нийтэд танилцуулсан.

3.6 Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дэмжлэг

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 6.4-д “Зөвлөлийн үйл ажиллагаанд УИХ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана” гэж заасан байдаг. Үүний дагуу ТТБЗ нь УИХТГ-ын Төсвийн хяналт, шалгалтын хэлтсээс авсан зарим мэдээ, мэдээллийг дурдвал:

- Жилийн төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг биелүүлсэн эсэх болон бусад шинжилгээ, судалгаа;
- Монгол Улсын нэгдсэн төсөв болон гадаад худалдааны сарын бүрийн гүйцэтгэл;
- Улсын Их Хурал, Засгийн газрын хурлаар хэлэлцэж буй зарим хууль тогтоомжийн төсөл.

3.7 Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал

Тайлант хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нийт 44 албан бичгийг дараах байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа. Үүнд:

- Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарас Зөвлөлийн санал, зөвлөмж хэрэгжүүлэхтэй холбоотой дэмжлэг хүсэх тухай;
- Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд Зөвлөлийн санал, дүгнэлт, зөвлөмж, тайлан хүргүүлэх талаар (5 удаа);
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд Зардал санхүүжүүлэх тухай, Санал хүргүүлэх тухай, Томилолтоор ажиллах талаар (15 удаа) ;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр ирүүлэх тухай (1 удаа);
- Сангийн яаманд сургалтын төлөвлөгөө батлуулах тухай, Зөвлөлийн санал, дүгнэлт хүргүүлэх тухай, мэдээлэл хүсэх тухай, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар (9 удаа);
- Эдийн засаг, хөгжлийн яаманд нэр хүргүүлэх тухай, Санал зөвлөмж хүргүүлэх тухай (3 удаа);
- Гадаад харилцааны яамнаас мэдээлэл хүсэх тухай, Бүгд Найрамдах Австри Улсын виз авахад дэмжлэг хүсэх талаар (2 удаа);

- Монголбанкнаас мэдээлэл хүсэх тухай, Санал, зөвлөмж хүргүүлэх талаар (2 удаа);
- Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн нэгжид санал хүргүүлэх тухай, төлбөр шилжүүлэх тухай, гэрээг цуцлах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах талаар (6 удаа) албан бичиг хүргүүлж ажиллав.

4. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦСАН БАЙДАЛ

Төсвийн бүрдлийг хангах эдийн засгийн бодлого явуулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн мөн чанарыг нийгэмд таниулах, энэ хүрээнд төсвийн алдагдлыг багасгаж, өр үүсэхээс сэргийлэх, хуримтлалыг төр, засгийн мэдэлд бус, хувь хүн, банкны хариуцлагад хуулиар албан журмаар шилжүүлж, урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэх талаарх ТТБЗ-ийн санал, санаачилгыг нийт иргэдэд хүргэж, тэдний санал хүсэлт, дэмжлэг авах үүднээс телевиз, сонин, сэтгүүл, цахим хуудсанд нийт 13 удаа ярилцлага өгсөн. Үүнд:

1. 2022.04.19-ны өдрийн Ийгл Телевизийн “Зочны цаг” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн гишүүн Э.Бямбажавын өгсөн ярилцлага.
2. 2022.04.22-ны Өдрийн сонины дугаарт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн “НДШ-ийг буцааж олгох нь нийгмийн эмзэг хэсэгт очих мөнгөнөөс хумсалдаг, хавтгайрсан халамжийн шинж” сэдэвт ярилцлага. Хавсралт 5-аас үзнэ үү.
3. 2022.05.23-ны Өдрийн сонины дугаарт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн “Баялгийн өгөөжийг хувь хүний хуримтлалд зарцуулах нь илүү үр дүнтэй” сэдэвт ярилцлага. Хавсралт 6-аас үзнэ үү.
4. 2022.05.26-ны Өдрийн сонины дугаарт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” сэдэвт зөвлөгөөнд оролцогчдод хүргүүлсэн илгээлт.
5. 2022.05.26-ны “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” сэдэвт үндэсний анхдугаар зөвлөгөөнд ТТБЗ-ийн гишүүн Г.Алтанзаяагийн танилцуулсан “Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд татварын боловсролын үндэсний хөтөлбөрийг бий болгох шаардлага, загвар” сэдэвт илтгэл.
6. 2022.06.28-ны Өдрийн сонины дугаарт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим сэдэвт хэлэлцүүлэг”-ийн талаар өгсөн ярилцлага.
7. 2022.10.03-ны өдрийн Ийгл Телевизийн “Зочны цаг” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн ярилцлага.
8. 2022.10.19-ны өдрийн “Төсөв-2023” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэгт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн “2023 оны төсөвт өгсөн зөвлөмж”-ийн талаарх илтгэл.
9. 2022.10.21-ний өдрийн TV8 телевизийн “Чухал сэдэв” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн ажлын албаны референт Б.Одмандах өгсөн ярилцлага.
10. 2022.10.25-ний өдрийн 25 дугаар телевизийн “Ам нээвэл” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн ярилцлага.
11. 2022.10.26-ны өдрийн Ийгл Телевизийн “Нэг сэдвээр” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн гишүүн Л.Отгонтуяагийн өгсөн ярилцлага.

12.2022.10.27-ны өдрийн Ийгл Телевизийн “Тоон Тойм” нэвтрүүлгээр ТТБЗ-ийн гишүүн Л.Отгонтуяагийн өгсөн ярилцлага.

13.2022.11.01-ний Зууны мэдээ сонины дугаарт ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн “Төсөв алдагдалгүй байх бүрэн боломж бий” сэдэвт ярилцлага. Хавсралт 7-оос үзнэ үү.

Дээрх ярилцлагын онцлох хэсгээс дурдвал:

- Татварын ерөнхий газар, татвар төлөгчид, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг гээд мэргэжлийн байгууллага болон бусад холбогдох төрийн байгууллагууд хамтран эдийн засаг тогтвортой хөгжихөд татварын бодлого ямар нөлөөтэй вэ гэдгийг тодорхойлохоор “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” гэсэн сэдэвт зөвлөгөөн зохион байгуулах гэж байгааг бид баяртай хүлээж авч, дэмжин хамтарч ажиллахаар болсон. Үүгээр дамжуулж нийгэмд бага ч гэсэн татвар төлөх ёстой, шударга ёсыг бүрдүүлцгээе, татвар төлдөггүй хүмүүсийг нийгэмд гарган ирж, далд эдийн засгийг ил болгоё гэсэн чиглэл рүү зөвлөгөөнийг ашиглах юмсан гэсэн ойлголттой байгаа юм. Монгол Улс маань хэвлэл мэдээллийнхэн, төрийн бүх албан хаагчид, төрийн түшээд, ерөнхийлөгчөөсөө эхлээд сумын Засаг дарга, улсдаа татвар төлдөг бүх хүн энэ нийгмийн оршин тогтнох үндэс, тогтвортой хөгжлийн оршин тогтнох үндэс нь төсөв тогтвортой байх явдал. Төсөв тогтвортой байхын үндэс нь иргэд татвараа төлдөг байх ёстой. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний санхүүжилт татварын орлогоор бүрдэж байгаа. Энэ нь байхгүй болчихвол төр боловсрол, эрүүл мэнд, цагдаа, цэргийн болон халамжийн үйлчилгээг, улс орноо удирдах үйлчилгээг яаж үзүүлэх вэ? Тийм боломжгүй болно. Ийм учраас улс орны тогтвортой хөгжилд татварын боловсрол бол маш чухал ач холбогдолтой юм.
- Нийгмийн халамж хамгааллын арга хэмжээг зорилтод бүлэгт зориулан хэрэгжүүлэх зарчмаар дундаж цалингаас доош орлоготой иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам тогтоохыг дэмжиж байна. Тэгэхдээ нэг сая төгрөгөөс доош гэхүү, эсвэл цалингийн доод хэмжээг 50 хувиар нэмэгдүүлсэн, эсвэл 800 мянган төгрөг дээр нэмэх 10 хувийн цалингаас доош цалинтайд хамаарахаар заах уу гэдгийг тооцохын хамт хугацааг сайтар бодож, зөвхөн энэ оны 5-12-р сараар хязгаарлаж чадах эсэхтэй холбож үзэх.
- 2022 оны төсвийн хөрөнгө оруулалт өмнөхөөсөө бараг 2 дахин нэмэгдсэн. Оруулж ирсэн төслүүдийн 70-80 хувь нь цаашид зардал шаардсан, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл болон хүмүүсийг ажилтай болгох төслүүд маш цөөхөн байсан. Хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд хүмүүсийг ажилтай болгох цаашдаа үйлдвэрлэх өсгөх төслүүдэд зарцуулах шаардлагатай. Үүнээс биш газар болгонд клуб хэрэгтэй, биеийн тамирын заал хэрэгтэй, зам хэрэгтэй. Эдгээрээс аль вэ гэдгийг зөв эрэмбэлж эхний ээлжид өөрийн боломждоо тулгуурлаж хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх хэрэгтэй. Хоёрдугаарт хөрөнгө оруулалтад хөрөнгө хүрэхгүй болохоор амсуулаад, амсуулаад баталчихдаг байдлыг зогсоож ТЭЗҮ-д тулгуурлаж 1 жил юм уу, 1 жил хагас гэж байна уу гэдэгт нь багтаан дуусгах шаардлагатай юм.
- Монгол Улсын 2020, 2021 оны нэгдсэн төсвийн нийт орлого нь урсгал зардлыг санхүүжүүлэхээс хэтрэхгүй, хөгжил, хөрөнгө оруулалтад зарцуулах төсвийн өөрийн эх үүсвэргүй болж, гадны зээл, төсвийн тогтворжуулалтын болон ирээдүйн өв сан, төсөвт хуримтлагдсан нөөцөө бүрэн ашигласан. Төсвийн урсгал зардлын мөн чанарыг айл гэрээр төсөөлбөл тухайн өрх бүх орлогоо хоол

хүнс, цахилгаан дулаан, хувцас, гэр ахуйн хэрэглэл зэрэг өдөр тутмын хэрэглээнд ашиглаад дуусаж нэг оёдлын машин ч авч чадахгүй байгаатай адил ойлголт билээ. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төсвийн алтан дүрэм бол төсвийн урсгал тэнцлийг ямагт ашигтай байлгаж, ашгаар нь эдийн засгийн хөгжлийг дэмжихэд хөрөнгө оруулдагт оршдог. Иймээс Засгийн газраас санаачилсан төсвийн хэмнэлтийн бодлогыг талархан хүлээн авч дэмжиж, цаашдаа төсвийн дунд хугацааны төсвийн зарлагын хүрээний мэдэгдлээр дамжуулан байнгын механизм болгох санал дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл, төсвийн суурь зардлуудад урт хугацаанд мөрдөх лимит болгон тогтоож, түүнээс хэмнэлт гаргах, ончтой зүйлд шилжүүлэн зарцуулах эрх олгох зэргээр төсөв захирагчдын төсөв хэмнэх сонирхол, хариуцлагыг өндөрсгөх хөшүүрэг болгох саналыг өгч байгаа. Олон оронд ийм туршлага дэлгэрч буй юм билээ.

- Бидний зүгээс хүсэж ирсэн бас нэг зүйл бол ядахдаа төсвийн зардлаар импортыг дэмжихгүйн тулд дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ ажлын байр бий болгоход чиглэсэн худалдан авалтыг тендергүйгээр дэмжих боломжийг судлах саналыг 2022 оны төсвөөс эхлэн тавьж байгаа.
- Хүүхдийн мөнгийг ирээдүйд нь зориулж хуримтлал болгох тухай Засгийн газар, Сангийн яамны санал ихэнх эцэг эхчүүдийн санаа бодолд нийцнэ гэж ойлгож байна. Хоёр гурван жилийн өмнө зарим сумдаар орж, банкны салбарынхаас асууж тодруулахад хүүхдийн мөнгөнийхөө 40-50 хувийг эцэг эхчүүд хадгаламж болгодог гэж байсан. Дээрээс нь жаахан шахалт болгон хуулийн шаардлага, үндэслэл бий болговол иргэд дагана гэсэн бодол байна. Мөн Монголын хөгжлийн ирээдүй гэгээлэг болно. Монгол Улс жилдээ нэг их наяд төгрөгийн хүүхдийн хадгаламж бий болгож, чадвал энэ мөнгө хадгаламжийнхаа хүүгийн хамт хөдөлмөрийн насанд хүрэх 16 жилийн турш нийтдээ улсын хэмжээнд 50 их наяд төгрөг болно. Үүнийг өнөөгийн ДНБ 40 орчим их наяд төгрөгтэй харьцуулан бодоход асар их мөнгө, банк, санхүүгийн салбарт цугларч, зээл, хөрөнгө оруулалтын урт хугацааны томоохон эх үүсвэр бүрдэнэ.
- Төрөөс аливаа тэтгэмж, дэмжлэг болон татвар, шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхдээ иргэдийн орлоготой холбох, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, улс орныхоо зээлжих зэрэглэлд илүүтэй анхаарч, өрийг багасгах, төсөвт онцгой нөлөөтэй нүүрс зэргийн борлуулалтыг дэмжих арга замыг олох, үнэгүйдээд буй мал аж ахуйн зарим түүхий эдийн үнэгүйдлийг багасгах, чадавхыг сайжруулах зэрэг санал, санаачилга гаргаж байгаа.
- 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтад шинэ төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүйгээр, 10-15 жилээр төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулдаг дутагдлыг засах, арилгахаар төсөл зохиосныг ТТБЗ бүрэн дэмжиж, Засгийн газраас боловсруулсан төсвийн хөрөнгө оруулалтын төслийг дэмжихийг УИХ-д уриалж байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын төслөөс үзэхэд зарчмын хувьд шүүмжлэх, хасах, нэмж тусгах, жишээ нь нөхөн үйлдвэрлэл нэмэгдүүлэх, цаашдаа төсөвт орлого оруулах объект бараг байхгүй, төсөл, арга хэмжээний үлэмж ихэнх нь цаашдаа төсвийн зардлыг өсгөхөд хүргэх, “тойргийн хөрөнгө оруулалтаас хөгжлийн хөрөнгө оруулалт руу” шилжиж чадаагүй гэх мэт маш олон санал шүүмж гарч болох ч 2023 оны хувьд шинэ төсөл, объектод төсвийн хөрөнгө оруулалт хийхгүйгээр дуусаагүйгээ цөөлөх, дуусгах, журамлах, цаашдаа хууль, журмаа мөрдөх боломжтой болоход чиглэсэн төлөвлөлтийг ТТБЗ дэмжиж байна.

- Хавар төсвийн хүрээний мэдэгдлээ Улсын Их Хурлаар батлахдаа үүнийгээ хэрэгжүүлэх оролдлого хийдэг. Гэсэн хэдий ч намар төсөв өргөн барихдаа дахин үүнийгээ өөрчлөөд байгаа нь төсвийн сахилга батгүй, төсвийн хариуцлагагүй байгаагийн нэг илрэл гэж үздэг.

5. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Зөвлөлийн хуралдаан

ТТБЗ-ийн хурлыг Zoom аппликешнээр зохион байгуулж, 8 удаа хуралдсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн.

2022.04.11-ний өдрийн хуралдаанаар:

- ТТБЗ-ийн 2021 оны жилийн тайланг хэлэлцэх, түүнд өгөх санал
- “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний анхдугаар зөвлөгөөнд ТТБЗ-ийн оролцоо
- 2022 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн ажил

2022.04.20-ны өдрийн хуралдаанаар:

- 2022 оны төсвийн тодотголд ТТБЗ-өөс өгөх санал

2022.05.05-ны өдрийн хуралдаанаар:

- МУЗБТ-ийн нэгжээс ирүүлсэн санал
- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл

2022.05.17-ны өдрийн хуралдаанаар:

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ТТБЗ-өөс өгөх санал

2022.06.03-ны өдрийн хуралдаанаар:

- 2021 оны үйл ажиллагааны эцсийн тайлан
- Дэлхийн банкны төслийн нэгжээс ирүүлсэн чиглэл
- Төсөв, татварын асуудлаар Өвөрхангай, Архангай, Завхан аймгуудад хийх судалгааны ажил

2022.06.24-ны өдрийн хуралдаанаар:

- “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгийн зохион байгуулалт

2022.09.28-ны өдрийн хуралдаанаар:

- Бүгд Найрамдах Австри Улсад 2022.08.14-21-нд зохион байгуулагдсан “Төсвийн дүрэм, гүйцэтгэл, хяналт” сэдэвт сургалтын тайлан
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнөөс дутуу хийгдсэн арга хэмжээнүүд

- 2021, 2022 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан чухал санал, зөвлөмжүүдийн хэрэгжилт
- Төсөл хэрэгжүүлэх нэгжээс ирүүлсэн албан бичиг

2022.10.05-ны өдрийн хуралдаанаар:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн төсөл болон түүний дагалдах зарим хуулийн төсөлд өгөх зөвлөмж

5.2 Хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд

ТТБЗ-ийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд 2021 онд гадаад зөвлөх Паул Гардинер ажилласан бөгөөд зөвлөх ажлын хүрээнд хэд хэдэн зөвлөмжүүдийг өгсөн. Үүний нэг нь Зөвлөлийн хүний нөөцийг чадавхжуулах явдал байсан. Уг зөвлөмжийн хүрээнд:

- ТТБЗ болон УИХ-ын ТХШХ-ийн ажилтнуудад зориулсан макро-эдийн засаг, төсөв, төлбөрийн тэнцэл, инфляцын төсөөллийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулав.
- Макро-эдийн засаг, төсвийн төсөөлөл хийх аргачлалын талаарх сургалтын цуврал материал орчуулж, бэлтгэн ТТБЗ-ийн гишүүдэд танилцуулсан. (Macro-fiscal forecasting approaches training modules):
 - *Forecasting Macroeconomic Variables*
 - *Forecasting Revenue*
- ТТБЗ-ийн болон УИХ-ын ТХШХ-ийн ажилтнуудад зориулсан макро-эдийн засаг, төсөв, төлбөрийн тэнцэл, инфляцын төсөөллийг боловсруулах чадавхыг бэхжүүлэх сургалтыг Монголбанк, МУИС-тай хамтран 2022 оны 01 дүгээр сарын 10-25-ны хооронд зохион байгуулсан.
- 2022 оны 02 дугаар сарын 07-18-ны хооронд Австри Улсын Joint Vienna Institute-ээс зохион байгуулсан төсөв, санхүү, өрийн удирдлага болон холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны талаарх онлайн сургалтад Зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, зөвлөх Д.Ганбат, ажлын албаны ажилтан Г.Оюун-Эрдэнэ нар хамрагдаж кэйсүүд дээр ажилласан. Тус сургалтад оролцсон 4 албан тушаалтнаас 3 нь тус сургалтыг амжилттай төгсөж сертификат авсан.
- 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Эдийн засгийн ухааны доктор Ч.Хашчулууны “Монгол Улсын Макро эдийн засгийн хөгжил, ойрын ирээдүйн төлөв” сэдэвт сургалт зохион байгуулж, ТТБЗ-ийн гишүүд, ТХШХ-ийн албан хаагчид мэдээлэл солилцов.
- Олон улсын валютын сангийн “Кавказ, Төв Ази, Монголын бүсийн орнуудын бүс нутгийн чадавхыг хөгжүүлэх төв”-өөс зохион байгуулдаг онлайн цуврал сургалтад тогтмол хамрагдаж байна.
- ТТБЗ-ийн ажлын алба хариуцсан референтээр Б.Одмандах 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн томилогдон ажиллаж байна.
- Дэлхийн банкны төслийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны зарим гишүүд, Сангийн яам, ЗГХЭГ, Зөвлөлийн гишүүн, ажлын албаны ажилтан зэрэг нийт 9 хүн Бүгд найрамдах Австри улсад зохион байгуулагдсан “Төсвийн дүрэм, гүйцэтгэл, хяналт” сэдэвт сургалт-айлчлалд хамрагдсан.

6. Дүгнэлт

1. Төсвийн орлого уул, уурхайн бүтээгдэхүүний орлого, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдэж байгаа ч орлого буурсан үед орлого дагаж өссөн зардлыг бууруулахад хүндрэл үүсэх эрсдэлтэй юм. Үүнээс сэргийлэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зардлын хязгаарыг тогтоосон шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулах нь зүйтэй гэж үзэж байна. ТТБЗ-өөс төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 28-30 хувиас ихгүй байхаар төсвийн төслийг боловсруулах нь зохимжтой гэсэн саналтай байна.

2. Төсвийн урхагшсан алдагдал, эсвэл алдагдалтай ч төсвийн зардлыг нэмэгдүүлсээр байгаа нь эцсийн дүндээ өр зээл өсөх шалтгаан болсон. Монгол Улсын хувьд Улсын төсвийн алдагдлыг дотоод, гадаадын өр болон тусламжаар санхүүжүүлсээр ирсэн бөгөөд Төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс өр болон ДНБ-ны харьцааны дээд хязгаарыг энэ хуулиар баталж, урт хугацаад өрийг бууруулах стратеги баримталж байгаа боловч хуульд тусгагдсан энэхүү өрийн дээд хязгаарыг төсөв хэлэлцэх үеэр удаа дараа өөрчилж, хуульд заасан хэрэгжих хугацааг нь хойшлуулсан өөрчлөлт оруулж байна. Монгол Улсын Засгийн газар, Монголбанк тулгамдсан өр зээлийг хойшлуулсан, бага хүүтэй бонд зээлийн хэрэгслээр дахин санхүүжилт хийж богино хугацаандаа хүндрэлийг зөөлрүүлсэн сайн талтай ч хойшилсон өр, нэмэгдсэн зээлийн үйлчилгээний төлбөр дарамт болж үлдсээр байгаа юм. Иймд төсвийг 2023 оноос эхлэн алдагдалгүй болговол зохино.

3. Өр нэмэгдэж буй гол шалтгаан бол төсвийн алдагдлаас гадна Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцэл олон жил алдагдалтай гарч, улмаар төсөвт ихээхэн ачаалал нэмэх хандлагатай болсонтой холбоотой. Урсгал данс ийнхүү алдагдалтай байгаа нь гадаадаас авах санхүүжилтийн хэрэгцээг үүсгэж байна. Иймд Экспортлогчдыг төрөөс тусгайлан дэмжих хэрэгтэй гэдэгт бүгд санал нэгдэж, экспортыг дэмжих олон улсын сайн жишиг болсон механизм, арга хэрэгслийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх; Экспортод чиглэсэн үйлдвэрлэгчдийг тэргүүн байранд тавьж, бүх талын туслалцаа үзүүлэх, экспортыг хааж богдуулдаг аливаа шийдвэр нь үндэсний эрх ашигт үл нийцэх бөгөөд ийм үйлдэл гаргахгүй байхыг уриалж, зах зээл судлал, үнэ, тарифын орчин, реклам сурталчилгааг эрс сайжруулж, төрийн дэмжлэг үзүүлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн батлан даалт, экспортын санхүүжилтийн болон даатгалын сан, холбогдох арга хэрэгслийг бий болгох хэрэгцээ үүсээд байна.

4. Үндэсний хуримтлал болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх. Үндэсний хуримтлал, ажиллах хүчний оролцооны түвшин бусад орнуудтай харьцуулахад нэн доогуур байгаа нь суурь асуудал бөгөөд өр үүсэх үндсэн шалтгаан мөн. Төсөв, мөнгө болон эдийн засгийн бодлого хэрэгслийг юуны түрүүнд дотоод хуримтлал бий болгох, цаашлаад хөрөнгө оруулалтын урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглүүлэх замаар гадаад зээлийн хэрэгцээг багасгах; Монгол Улсын түүхий эд, хүн хүчний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүх талын дэмжлэг үзүүлэх, үүний дотор ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх

5. Баялгийн сангийн тодорхой хэсгийг албан журмын үндсэн дээр хуулиар хүүхдийн болон өндөр насны хадгаламж хэлбэрээр банкинд хуримтлуулах нь нийт эдийн засгийг урт, дунд хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болгохын зэрэгцээ хүн амын хадгаламжгүй, өнөө маргаашаа аргацааж буй хэсгийн ирээдүйн амьдралын баталгааг бий болгож, аз жаргалтай, эрүүл амьдралыг бодит утгаар нь хэрэгжүүлэх боломжтойг юм.

Хавсралт 1. ТТБЗ-өөс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Сангийн сайдын 2022 оны 10 дугаар

сарын 17 өдрийн 01/7088 тоот

албан бичгийн хавсралт 1

№	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
1	Монгол Улсын нэгдсэн төсвийг 2023 оноос эхлэн алдагдалгүй болгохоор төсвийн төсөл, төсөөлөлд тусгах	<p>Монгол Улсын Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гэж заасны дагуу жил бүр үе шаттайгаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг хуулийн дагуу бууруулан ажиллаж байна.</p> <p>2023 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн алдагдлыг 1,553.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувьтай тэнцүү байхаар төлөвлөсөн нь төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаас 0.8 хувиар, өнгөрсөн жилийн алдагдлаас 833.7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна.</p>
2	Төрөөс аливаа тэтгэмж, дэмжлэг болон татвар, шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхдээ тухайн хувь хүн, тэдний гэр бүлийн орлогын болон татварын тайлан гаргуулж, тодорхой босго буюу нэг хүнд ногдох орлогын тодорхой дүнгээс доош орлоготой бол тэтгэмж, хөнгөлөлт үзүүлдэг журам тогтоох. Өнөөгийн регистрийн санамжид тайлан, мэдээг оруулах цаашдаа татвар төлөгчийн бүртгэл, төлсөн бүх нийгмийн даатгалын шимтгэлийг иргэний шинэ бүртгэлийн дугаарын санамж буюу чипэд оруулахаар тооцох. Цаашдаа энэ зарчмыг нийгмийн халамжийн бүх арга хэмжээнд нэвтрүүлэх	<p>Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 292 тоот тушаалаар батлагдсан “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу татвар төлөгч нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхдээ татварын тайлан, тайлангийн хавсралт мэдээ, нотлох баримт, хөнгөлөлтөө буцаан авах хүсэлтийг татварын албанд ирүүлдэг. Татварын хөнгөлөлтийг тухайн тайлант хугацаанд татвар төлөгчийн төлсөн татвараас буцаан олгох, ногдуулан төлсөн татварын дүнгээс тооцох замаар эдлүүлдэг зохицуулалттай. Харин татвар төлөгч нэгж нь хувь хүн эсвэл аж ахуй нэгж байх тул өрхөөр орлогоо тайлагнах боломжгүй. Иймд холбогдох тухай хууль тогтоомжид заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байна.</p> <p>Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэвэр, тэтгэмжийг Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь регистрийн бүртгэлийн дагуу шалгасны үндсэн дээр олгож байна. Өрхийн амьжиргааны түвшинтэй уялдаж олгодог хүнсний талон болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зорилтод бүлэгт чиглүүлэх тохиолдолд одоогоор шууд иргэний орлогын түвшнээр тодорхойлох боломжгүй байна. Учир нь албан ёсоор бүртгэгдсэн мөнгөн орлого болох цалин хөдөлмөрийн хөлснөөс гадна албан бус буюу бүртгэгдээгүй орлого эдийн засагт өндөр</p>

		<p>байгаа тул бүх өрхүүдийг хамруулан хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.</p> <p>Тиймээс өнөөдөр энэ хоёр төрлийн мөнгөн шилжүүлгийг өрхийн орлогыг орлуулан тооцох(proxy means testing) аргачлал ашиглан хэрэгжүүлж байна. 2023 оны төсвийн жилээс эхлэн хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 91 хувьд олгохоор тооцож төсвийн төсөлд тусгасан. Үлдэх 9 хувьд ногдох хүүхдийн амьдарч байгаа өрхийн амьжиргааг орлого ба хэрэглээний түвшинд нь үндэслэн шалгах аргачлалыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Ингэхдээ өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас тухайн өрхийн гишүүний авсан цалин хөлс, хадгаламжийн хүүд төлсөн татвар зэргийг төрийн мэдээллийн нэгдсэн сан болон бусад системүүдээс шалгаж тогтоох боломжтой юм.</p>
3	Хүүхдийн мөнгийг хуримтлал, хадгаламж хэлбэрээр байлгаж, харин хүсэлт гаргасан дунджаас доош орлоготой иргэдийн хүүхдийн мөнгийг бэлнээр үргэлжлүүлэн олгох	<p>2022 оны төсвийн жилд Хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв санд хуримтлал хэлбэрээр байршуулж хүсэлт гаргасан өрхийн хүүхдэд бэлэн мөнгө хэлбэрээр сар бүр олгож байна. Энд өрхийн орлогын түвшнээр шалгуур тогтоогоогүй ба УИХ-аас баталсан Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу хүсэлт гаргасан тохиолдол бүрт олгож байгаа болно. Өрхийн амьжиргааны түвшнийг дан ганц орлогоор тодорхойлох боломж бүрдсэн үед зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд өнөөдөр төрийн мэдээллийн нэгдсэн сан дахь өгөгдлийг ашиглан тодорхой босго тогтоох асуудал нь техникийн хувьд бүрэн боломжтой болсон.</p>
4	Дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төр худалдаж авахдаа тендер шалгаруулалт явуулахаас татгалзаж, шууд гэрээгээр худалдан авах ба үнэ нь олон улсын зах зээлийн үнээс 20 орчим хувиар өндөр байхыг зөвшөөрөх	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 10.1.1 дэх хэсэгт “Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглоно” гэж, 10.1.2 дах хэсэгт “Энэ хуулийн 10.1.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална” гэж тус тус заасан. Ингэснээр дотоодын бараа худалдан авах тендер шалгаруулалтын оролцогч нь олон улсын зах зээл дээрх үнээс дээш хэтэрч болох аливаа хязгаарлалтгүй байна.</p> <p>Хуулийн дээрх зохицуулалтыг зохих ёсоор хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайдын 2021 оны 124, 144 дүгээр тушаалаар батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөх буй бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгүүдэд захиалагч</p>

		<p>дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад багтсан барааг зөвхөн дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тусад нь багцлахыг үүрэг болгосон. Мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11 дэх заалтад “энэ хуулийн 10.1.2-т заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч үйлдвэрлэсэн бол” гэрээ шууд байгуулах боломжтой байхаар заасан.</p>
5	<p>Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээний ДНБ-тэй харьцуулсан харьцаа хөгжиж буй орнуудын өрийн хязгаар үзүүлэлтээс 2-3 дахин их байгаад дүгнэлт хийж, хувийн хэвшлийн хийгээд Засгийн Газрын өрийг багасгах, ялангуяа өндөр хүүтэй зарим компани хоорондын хөрөнгө оруулалтын зээл, бонд зэргийг өнөөгийн үнэ цэнээр хямдруулан тооцохгүй байх, хүүг нь багасгах, зогсоох арга замыг олж шийдэх, гадаад дотоод зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эргэн төлөлтийг оновчтой шийдэх</p>	<p>ОУВС-гийн 2013 онд гаргасан өнөөгийн үнэ цэнэ тооцох аргачлалд* хөнгөлөлттэй зээл түлхүү авдаг орнуудын өрийн шинжилгээг 5 хувийн хоргодуулах хүүтэйгээр тооцож өрийн дарамтыг олдог байна. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо зөвхөн хөнгөлөлттэй гадаад зээлийн хувьд 5 хувийн хоргодуулах хүүтэйгээр тооцдог байна. Иймд Засгийн газрын гадаад болон дотоод үнэт цаасны үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцдоггүй болно.</p> <p>Түүнчлэн, Засгийн газрын гадаад үнэт цаасыг 2012-2016 оны хооронд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор 1.5 тэрбум ам.доллар, төсвийн алдагдал нөхөх зориулалтаар 0.7 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээтэйгээр арилжаалсан бол өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд буюу хугацаа нь тулсан гадаад бондын эргэн төлөлтийг дахин санхүүжүүлэх зориулалтаар 3.0 тэрбум ам.доллартой тэнцэх гадаад үнэт цаасыг арилжаалсан байдаг. Энэхүү үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжилт хийх замаар 2017 онд “Хуралдай” бондын 600.0 сая ам.доллар, “Гэрэгэ” бондын 800.0 сая ам.доллар, 2020 онд “Номад” бондын 600.0 сая ам.доллар, 2021 онд “Сенчири” бондын 1,000.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>“Сенчири” өрийн зохицуулалтын арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлснээр хугацаа тулаад байсан “Чингис” болон “Гэрэгэ” бондуудын төлбөрийг түүхэндээ хамгийн бага хүүгийн түвшин буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллартой тэнцэх хэмжээтэйгээр арилжаалсан бөгөөд энэ нь Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрийг 21.0 сая ам.доллароор хэмнэж, гадаад валютын 1,000.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний нөөцийг хадгалж үлдсэн байдаг.</p> <p>Цаашид, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасан зорилт 2-т “Засгийн газрын гадаад үнэт</p>

		цаас төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна” гэж заасан байдаг. Энэхүү зорилтыг хангахаар 2023 оны 05 дугаар сард эргэн төлөх хуваарьтай “Гэрэгэ” бондын төлбөр болох 533.1 сая ам.доллар, 2024 оны 09 дүгээр сард эргэн төлөх хуваарьтай “Хуралдай” бондын төлбөр болох 600.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төсөвт дарамт учруулахгүйгээр өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.
6	2023 онд төлөгдөх 3 том дүнтэй бондын 20 орчим хувийг төлөх, бусдыг дахин санхүүжүүлэх бэлтгэлийг хангахаар 2023 оны төсөвт тусгах	<p>Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 2 дугаар зорилтын хүрээнд Гэрэгэ бондын тодорхой хэмжээний төлбөрийг дахин санхүүжүүлж, үлдсэн хэсгийг төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү дахин санхүүжилтийн хүрээнд үнэт цаас шинээр гаргах зөвшөөрөл авахаар төсвийн тухай хууль дагаж тогтоолын төслийг боловсруулсан.</p> <p>Түүнчлэн, Монгол Улсын Хөгжлийн банкны арилжаалсан 2023 онд төлөх хуваарьтай бондуудын төлбөрийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулах эсхүл дахин санхүүжүүлэх боломжгүй болсон зайлшгүй тохиолдолд Засгийн газрын зүгээс олон улсын зах зээл дэх нөхцөл байдлыг харгалзан үзэж, өрийн баталгаа гаргах замаар МУХБ-ны дахин санхүүжилтийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр Улсын Их Хурлын тогтоол боловсруулсан.</p>
7	Гадаадын хөрөнгө оруулалтын ихээхэн хэсэг нь уул уурхайн салбарт, түүний дотор эрдэс түүхий эдийг олборлох, тээвэрлэхэд чиглэсэн байгааг анхааралдаа авч, тэдгээрийг боловсруулах, мөн сэргээгдэх эх үүсвэр болох мал аж ахуй болон нар салхины зэрэг нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулагдах хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих арга, механизмыг боловсруулж, нэвтрүүлэх. Үүний тулд экспортын эцсийн бүтээгдэхүүнд татварын нэн таатай орчин бүрдүүлэхэд анхаарах	“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасны дагуу экспортод гаргасан ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд албан татварын тэг хувь хэрэглэх замаар зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
8	Төсвөөс олгох зээлийн хөнгөлөлтийн зөрүүг багасгах арга замыг олж тогтоох, эсвэл төмөр зам, эрчим хүч, газрын тос, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслүүдийн	Төсвөөс олгох зээлийн хөнгөлөлтийн зөрүүг багасгах арга замыг олж тогтоох, эсвэл төмөр зам, эрчим хүч, газрын тос, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслүүдийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хэрэгжүүлж буй

	<p>хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх. Энэ чиглэлээр бонд гаргах, эсвэл энэ чиглэлийн бондыг худалдан авах баталгаа гаргах, харин төсвийн алдагдлыг бондоор санхүүжүүлэхээс аль болох татгалзах</p>	<p>эрчим хүч, төмөр замын төслүүдийг санхүүжүүлэх зорилготой 2.0 их наяд төгрөг хүртэл гаргах үнэт цаасанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 8-3/1321 тоот албан бичгээр олгосон.</p> <p>Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээнд “Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзаж, өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэр ашиглахыг эрмэлзэнэ,” гэж тусгасны дагуу төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргаагүй болно.</p>
9	<p>Экспортын үйлдвэрлэлийг дэмжих даатгал, зээлийн баталгаа, татвар, зээлийн хөнгөлөлт санхүүжилтийн хэрэгсэл зэргийг хамарсан иж бүрэн механизм бүрдүүлж хэрэгжүүлсэн байх</p>	<p>“Үндэсний давхар даатгал” ТӨХК нь Монгол Улсын уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор МУ-ын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай хамтран хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд экспортын шинэ төрлийн санхүүжилтийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Экспортын даатгалын газар нь гадаадын худалдан авагч зээлээр авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг арилжааны болон улс төрийн эрсдэлүүдээс шалтгаалан төлөөгүй тохиолдолд учирсан хохирлыг экспортлогчдод нөхөн төлөх экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, хөгжүүллээ.</p> <p>Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй экспортлогчид ихэвчлэн бэлэн мөнгөөр, урьдчилж төлбөрөө төлөх нөхцөлөөр бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг. Худалдан авагчдад бараа хүлээн авснаас хойш 30, 60 эсвэл 90 өдрийн дараа төлбөр төлөх уян хатан нөхцөлийг санал болгодог олон улсын зах зээлд энэ нь сул тал болж байна. Экспорт эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ зээлээр олгосноор борлуулалтын орлогоо өсгөх, шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадвараа сайжруулах давуу талууд бий болдог. Түүнчлэн, экспортын зээлийн даатгалын гэрээ нь арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас экспортын худалдааны санхүүжилт авахад баталгаа, барьцаа хөрөнгө болох боломжтой байдаг. Уг боломжийг бүрдүүлэх зорилгоор “Үндэсний давхар даатгал” ХК нь Монголбанк болон арилжааны банкнуудтай холбогдох хэлэлцээр, уулзалтуудыг зохион байгуулж, хамтран ажиллаж байна.</p>

10	<p>Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг эцсийн дүндээ төсөв хариуцах учраас төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа Сангийн сайдын зөвшөөрлийг заавал авдаг болох. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж Сангийн яам, УИХ-д ирүүлдэг байх. Төр, хувийн хэвшлийн төслийг ил тод байлгах ёстой ба гэрээтэй холбогдсон аливаа зүйлийг гэрээлэгч-байгууллагын нууцад хамааруулахгүйгээр гэрээ байгуулагдмагц нийтэд мэдээлж, УИХ-д хүргүүлж байх.</p>	<p>Засгийн газрын 2021 оны 36 дугаар тэмдэглэлийн дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн төслийг шинээр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулсан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын дагуу хуулийн тандан судалгаа, концессын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаа болон олон улсын харьцуулсан судалгааг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулж, хуулийн төслийг өргөн барихад холбогдох зөвшөөрлүүдийг авахаас гадна УИХ-ын ажлын хэсэг, хувийн хэвшил, олон нийт, олон улсын байгууллагуудын дунд хэлэлцүүлгүүд зохион байгуулж, хуулийн төсөлд санал авч, ирүүлсэн саналыг тусгасан.</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, 2022 оны 6-р сарын 3-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-аар хэлэлцүүлэхийг гишүүдийн 72.8 хувь нь дэмжсэн. Хуулийн төслийг УИХ-ын 2022 оны намрын чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. Хуулийн төсөлд төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргахад Сангийн сайдаас зөвшөөрөл авч байх, тайланг Сангийн яам болон УИХ-д ирүүлдэг байх, төр, хувийн хэвшлийн төслийг ил тод байлгах, нууцын зэрэглэлээс бусад гэрээг олон нийтэд мэдээлж байх заалтыг оруулсан.</p>
11	<p>Макро-эдийн засгийн гол үзүүлэлт бол Монгол орны хувьд төлбөрийн тэнцэл мөн гэж үзэж, төлбөрийн тэнцлийн байдалд жил бүр судалгаа хийж, түүнд үндэслэн төсвийн болон макро-эдийн засгийн төсөөлөл хийж байх</p>	<p>Төсвийн төслийг боловсруулахад шаардлагатай эдийн засгийн дотоод ба гадаад орчны болон түүхий эдийн дэлхийн зах зээлийн төлөв байдлын шинжилгээг хийж, төсвийн төсөлд тусган ЭЗХЯ, МБ, Уул уурхайн компаниудын холбогдох талуудтай хэлэлцэн, төсвийн төсөлд ашигласан макро эдийн засгийн болон төлбөрийн тэнцлийн төсөөллийг гаргасан. Тухайлбал зэс, газрын тос, нүүрсний дэлхийн зах зээлийн талаар судалж, дотоодын экспортлогч томоохон үйлдвэрүүдийн 2023 оны төлөвийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.</p> <p>Харин төлбөрийн тэнцлийн төсөөллийг МБ, ОУВС-тай эдийн засгийн нөхцөл байдлын талаар удаа дараагийн хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр МБ-ны төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцийн суурь төсөөллийг авч ашигласан.</p>

Хавсралт 2. “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний зөвлөгөөнд оролцогчдод зориулсан илгээлт

ИЛГЭЭЛТ

“Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний зөвлөгөөнд оролцогч Та бүхэнд УИХ-ын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлж, мэндчилж байна.

Тус зөвлөгөөнийг санаачлагчид, зохион байгуулагчид, нэн ялангуяа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Татварын Ерөнхий газрын хамт олон, багш эрдэмтэн судлаачид та бүхэн татварын үйл хэрэг, ач холбогдлыг нийгэмд хүргэхэд жинтэй хувь нэмэр оруулж ирснийг сайшаан тэмдэглэж байна. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд татварын мөн чанарыг ойлгуулах үйл ажиллагааг дэмжиж, “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний зөвлөгөөнд оролцож буй төрийн түшээд, албан хаагчид, судлаачид, өөрсдийн төлөөллийг илгээсэн нийт байгууллага хамт олон, түүний дотор Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Монголбанк хийгээд хэвлэл, олон нийтийн байгууллагууд цаашид татварыг бүх нийтийн үйлс болгон, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд анхдагч үүрэгтэй болохыг хүмүүний оюун санаанд суулган нэвтрүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс захиалан хийлгэсэн судалгааны дүнгээр дэлхий нийтийн жишгийн дагуу татварын боловсролыг нийт хүн ам, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд системтэйгээр олгох нь манай орны хувьд тулгамдсан зорилт болсныг тогтоосны зэрэгцээ шударга ёс, ухаалаг, жаргалтай амьдралыг татварын зөв тогтолцоо, ёс зүйтэй нийгэм, хуулийн мөрдөлтөөр хангадаг болохыг олон улсын шилдэг туршлага харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэдэд хүлээлгэсэн хууль сахих, бусдыг хүндлэх, татвар төлөх, эх орноо хамгаалах дөрвөн үүргийг онцгойлон зааж баталгаажуулжээ. Татвар төлөх нь угаасаа хүний нийгмийн хөгжил дэх төрт улсын үндсэн шинж бөгөөд өдгөө тогтвортой хөгжлийн суурь эх үүсвэр билээ.

Чанартай боловсрол, эмнэлгийн үйлчилгээ, хүртээмжтэй нийгмийн хамгаалал, мөн төрийн бүх үйл хэргийг татвараас бүрдүүлсэн орлогоос санхүүжүүлдэг жирийн үнэнийг нийгэмд мэдүүлэх, иргэн та бас ашиг орлого, татвараа тодорхойлж, нийгмийн үйлчилгээг авах эрхтэй болдог зах зээлийн зарчимтай гэдгийг боловсролын тогтолцоогоор дамжуулан ойлгуулах учиртай юм.

Их тоон өгөгдөл бүрдэх боломж нэмэгдсэн, мэдээлэл технологийн хөгжил эрчимжсэн зэрэг нь улс орныг дижитал бүртгэл, мэдээллээр дамжуулан удирдах нөхцлийг ханган өгч буй бөгөөд энэ чухал цаг үед “Тогтвортой хөгжилд татварын боловсролын үүрэг” үндэсний зөвлөгөөн болж байгаад ихээхэн ач холбогдол өгч байна.

Та бүхэн Монгол улсынхаа хөгжлийг улам түргэтгэх, хүн ардаа ажилтай, хүрэлцэхүйц мөнгөн орлоготой болгохын тулд татварын боловсролын бодлогыг тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр үнэтэй санал, зөвлөмж гаргана гэдэгт итгэл дүүрэн байна. Зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсье.

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
ДАЛРАЙН ДАВААСАМБУУ**

2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр
Улаанбаатар хот

Хавсралт 3. “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж

Төрийн ордон

2022 оны 06 дугаар сарын 28

Монгол Улсын Их Хурал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Төрийн ордонд “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг нээж Улсын Их Хурлын дарга Г.Зандашатар, Олон Улсын Валютын сангийн суурин төлөөлөгч Юн Сок Хёнг нар дэлгэрэнгүй үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монголбакны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Э.Бямбажав, Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар илтгэл тавьсан. Энэхүү хэлэлцүүлэгт эрдэмтэн судлаачид, олон нийтийн төлөөлөл, төр захиргааны байгууллагын ажилтнууд, Монголбанкны удирдлага, Олон улсын байгууллагын төлөөлөгчид, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд оролцож дараах нэгдсэн санал, зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

1. Макро-эдийн засгийн гол үзүүлэлт бол Монгол орны хувьд төлбөрийн тэнцэл мөн гэж үзэж, төлбөрийн тэнцлийн байдалд жил бүр судалгаа хийж, түүнд үндэслэн төсвийн болон макро-эдийн засгийн төсөөлөл хийж байх;
2. Үндэсний аудитын газрын илтгэлд дурдсанаар 2018-2020 онд Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд (хөтөлбөрийн зээл ороод) зориулсан нь Засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Иймд Монгол Улсын төсвийг алдагдалгүй баталж, төсвийн хяналтыг чангатгаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хатуу мөрдөж ажиллах замаар Засгийн газрын өрийн түвшинг багасгах;
3. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээний ДНБ-тэй харьцуулсан харьцаа хөгжиж буй орнуудын өрийн хязгаар үзүүлэлтээс 2-3 дахин их байгаад дүгнэлт хийж, Хувийн хэвшлийн хийгээд Засгийн газрын өрийг багасгах, ялангуяа өндөр хүүтэй зарим компани хоорондын хөрөнгө оруулалтын зээл, бонд зэргийг өнөөгийн үнэ цэнээр хямдруулан тооцохгүй байх, хүүг нь багасгах, зогсоох арга замыг олж шийдэх, гадаад дотоод зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эргэн төлөлтийг оновчтой шийдэх;
4. Үндэсний хуримтлал болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх. Үндэсний хуримтлал, ажиллах хүчний оролцооны түвшин бусад орнуудтай харьцуулахад нэн доогуур байгаа нь суурь асуудал бөгөөд өр үүсэх үндсэн шалтгаан мөн. Төсөв, мөнгө болон эдийн засгийн бодлого хэрэгслийг юуны түрүүнд дотоод хуримтлал бий болгох, цаашлаад хөрөнгө оруулалтын урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглүүлэх замаар гадаад зээлийн хэрэгцээг багасгах; Монгол Улсын түүхий эд, хүн хүчний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүх талын дэмжлэг үзүүлэх, үүний дотор ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх;
5. Экспортлогчдыг төрөөс тусгайлан дэмжих хэрэгтэй гэдэгт бүгд санал нэгдэж, экспортыг дэмжих олон улсын сайн жишиг болсон механизм, арга хэрэгслийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх; Экспортод чиглэсэн үйлдвэрлэгчдийг тэргүүн байранд тавьж, бүх талын туслалцаа үзүүлэх, экспортыг хааж богдуулдаг аливаа шийдвэр нь үндэсний эрх ашигт үл нийцэх бөгөөд ийм үйлдэл гаргахгүй байхыг уриалж, зах зээл судлал, үнэ, тарифын орчин, реклам сурталчилгааг эрс сайжруулж, төрийн дэмжлэг үзүүлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн батлан даалт, экспортын санхүүжилтийн болон даатгалын сан, холбогдох арга хэрэгслийг бий болгох;

6. Гадаадын хөрөнгө оруулалтын ихээхэн хэсэг нь уул уурхайн салбарт, түүний дотор эрдэс түүхий эдийг олборлох, тээвэрлэхэд чиглэсэн байгааг анхааралдаа авч, тэдгээрийг боловсруулах, мөн сэргээгдэх эх үүсвэр болох мал аж ахуй болон нар салхины зэрэг нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулагдах хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих арга, механизмыг боловсруулж, нэвтрүүлэх. Үүний тулд экспортын эцсийн бүтээгдэхүүнд татварын нэн таатай орчин бүрдүүлэхэд анхаарах;
7. Хөрш ОХУ, БНХАУ түүнчлэн АНУ, БНЭУ, БНСУ зэрэг 3 дахь хөршийн орнуудтай гаалийн тарифын гэрээ хэлэлцлийг явцыг эрчимжүүлж холбогдох үр дүн гаргах;
8. Төлбөрийн балансад сөрөг нөлөө үзүүлж байгаа (техник туслалцаа, ажиллах хүчин, инженерчлэл, тооцоо судалгаа, зураг төслийн шинжтэй) үйлчилгээ, ажлыг Монголдоо гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлж зээл, тусламж, хөрөнгө оруулалтын гадагшлах урсгалыг бууруулах;
9. Эрчим хүчний хараат байдлаас гарах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бий болгох үүднээс цахилгаан, дулааны үнийг хөрөнгө оруулалт, өртгөө нөхөх хэмжээнд тогтоох;
10. Гадаад зээл, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой, үр дүнтэй ажил хийж хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг оновчтой хөгжүүлж, аль болох Засгийн газрын баталгаа гаргахаас зайлсхийж, хариуцлагыг нэмэгдүүлэх;
11. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлдэг нь төсөл, арга хэмжээг удаашруулж нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг бууруулж байгаад зохих дүгнэлт хийж хууль тогтоомжийг мөрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авах;
12. Монгол Улсын нийт гадаад өрийн эргэн төлөлтөд 2023-2026 онд нийт 13.3 тэрбум ам.долларын өр төлбөр хүлээгдэж байгаа тул зээлжих зэрэглэлийн үнэлгээг сайжруулах, төгрөгийн бусад валюттай харьцах ханшийг тодорхойлогч суурь хүчин зүйл болох төлбөрийн тэнцлийн олон жилийн турш өндөр алдагдалтай байгаа урсгал дансны алдагдлыг бууруулахад эдийн засаг, төсөв, мөнгөний бодлогыг чиглүүлэх;
13. Гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь өөрийн үйл ажиллагаа, орлого, ашгаараа зээлийн төлбөрөө эргүүлэн төлөх чадвартай байгаа нөхцөлд гаднаас зээлийн эх үүсвэр татах хатуу зарчмыг хуульчлах;
14. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг өөрчлөх бус, зайлшгүй нөхцөлд түр түдгэлзүүлж, нөхцөл байдал сайжирсан үед зохистой шаардлагаа буцаан сэргээн хэрэглэж, түр түдгэлзүүлсэн шийдвэрээ хүчингүй болгож байх.

Жич: Хэлсэн үг, илтгэлүүдийг <https://cloud.parliament.mn/index.php/s/erewXiiL3s3EZ5T> сайтад байршуулав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ,
ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**



ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСАД ЗАСАГЛАЛЫГ
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСАД ХИЙСЭН
“ТӨСВИЙН ДҮРМЭЭС ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХҮРТЭЛХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”
СЭДЭВТ СУРГАЛТ-АЙЛЧЛАЛЫН ТАЙЛАН**

2022 оны 8 дугаар сарын 14-21-ний өдөр

НЭГ. ОРШИЛ

Улсын Их Хурлын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Австри Улсад ажиллаж, Үндэсний зөвлөлийн Тамгын газар болон Холбооны Сангийн яамны төлөөлөлтэй ажил хэргийн уулзалтыг хийсэн юм. Энэхүү уулзалтаар Австри улсын Үндэсний зөвлөлөөс улсын төсөв батлах, хяналт тавих, төсвийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны талаар туршлага судлах сургалт-айлчлалыг зохион байгуулах боломжтой талаар мэдээлж, сургалтыг 2022 оны 8 дугаар сард зохион байгуулахаар тохиролцсон болно.

Үүний дагуу Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, түүний ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамны төлөөлөл бүхий нийт 9 албан хаагч Бүгд Найрамдах Австри улсын Төсвийн зөвлөл, Парламентын төсвийн оффис, Сангийн яам, Төрийн үйлчилгээ, соёл, спортын яам, Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах “Төсвийн дүрмээс төсвийн гүйцэтгэл хүртэлх үйл ажиллагаа” сэдэвт сургалт-айлчлалд 2022 оны 08 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд хамрагдлаа.

Сургалт-айлчлалын хүрээнд Бүгд Найрамдах Австри Улсын хэмжээнд хэрэгжиж буй төсвийн төлөвлөлтөөс төсвийн гүйцэтгэл хүртэлх гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа, мөн хууль тогтоох байгууллагын зүгээс төсвийн хяналт тавих, төсөв батлах бүхий л үе шат, зохион байгуулалтад оролцож буй арга, хэлбэр, үйл ажиллагааны механизм, байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаатай танилцав.

**ХОЁР. СУРГАЛТ-АЙЛЧЛАЛЫН ЗОРИЛГО, ТАНИЛЦСАН БАЙГУУЛЛАГА, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ОРОЛЦОГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН, СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ,
ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД**

Австри улсын төсвийн шинэчлэл, гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт, макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөл боловсруулах аргачлал, үйл явц, төсвийн дүрмийн мониторинг, гүйцэтгэлийн хяналт, хөндлөнгийн үнэлгээг хэрэгжүүлж буй байдалтай газар дээр нь танилцаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын туршлагаас суралцахад уг сургалт-айлчлалын зорилго оршино.

Сургалт-айлчлалд оролцогчдын бүрэлдэхүүн: Сургалт-айлчлалд хууль батлах, хяналт тавих, гүйцэтгэх түвшний байгууллагуудын төлөөлөл болох УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүн Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн, Зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба хариуцсан референт Б.Одмандах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Д.Балжинням, Синхрон орчуулагч Д.Халиун, СЯ-ны Төрийн

сангийн Төлбөр тооцооны хэлтсийн дарга Л.Наранчимэг, СЯ-ны Төсвийн газрын зарлагын хэлтсийн ахлах зөвлөх Т.Батсүх нар хамрагдав.

Сургалт-айлчлалын үр дүнд цаашид ТБХ, ЗГХЭГ, СЯ, ТТБЗ, ТХШХ-ийн зүгээс төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн төсвийг төлөвлөх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын үр дүн дээшилж, УИХ-ын гишүүд, ТТБЗ-ийн гишүүд, төрийн албан хаагчдын чадавх бэхжихийн зэрэгцээ эдгээр байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ойлголцол сайжирна гэж үзэж байна.

Цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх санал

1. *УИХ дахь төсвийн хэлэлцүүлгийг бодлогод илүүтэй чиглүүлэх:* Бүгд Найрамдах Австри улсын парламент нь төсвийн шинэ бүтэц хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь парламентын гишүүд зардлын зүйл анги бүрийг нарийн хэлэлцэж цаг их зарцуулдаг байсныг өөрчлөн стратегийн чиглэлээр хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэхэд илүүтэй нөлөөлсөн байна. Иймд Монгол Улсын төсвийн бүтцийг мөн шинэчлэн боловсруулж, УИХ-ын гишүүдийг төсвийн хэлэлцүүлэгт сонгуулийн тойрог дахь хөрөнгө оруулалтыг түлхүү ярихаас илүүтэйгээр Улс орны хөгжлийн стратегийг дэмжихэд чиглэсэн шинэ сэргэлтийн бодлогын хөрөнгө оруулалт, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаарх хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, орон нутагт Улаанбаатар хотоос илүү цалинтай ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн үйлдвэрийн хөрөнгө оруулалтын талаар мэтгэлцээн өрнүүлдэг болгох

2. *Хараат бус статустай, чадварлаг Эдийн засгийн судалгааны хүрээлэнг ажиллуулах:* Австрийн Эдийн засгийн судалгааны хүрээлэн нь нийгэм, эдийн засаг, төсөв санхүүгийн үзүүлэлтүүдээр хараат бус дүн шинжилгээ, төсөөллийг хийж олон нийтэд мэдээлэн бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц чухал үүрэг гүйцэтгэдэг байгууллага юм. Манай орны хувьд 2022 онд Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулсан бөгөөд энэхүү яамны дэргэд Эдийн засгийн судалгааны хүрээлэнг хараат бус, бие даасан статустайгаар байгуулан макро эдийн засаг, төсвийн богино, дунд, урт хугацааны төсөөлөл, таамаглалыг үндэслэлтэйгээр боловсруулах ажлыг хариуцуулан, сар бүр тогтмол мэдээлэл гаргаж, хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд бодитой мэдээллийг хүргэдэг байх нь төр, хувийн хэвшил, иргэдийн шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлэх боломжтой юм.

3. *Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс төсвийн тусгай шаардлагад тавих хяналтын эрхзүйн зохицуулалтыг сайжруулах:*

4. *Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албыг бэхжүүлэх:* Австри Улсын Төсвийн зөвлөл нь 15 гишүүнтэй, Ажлын алба нь 7 албан хаагчийн бүрэлдхүүнтэйгээр төсөв, төсвийн бодлого, төсвийн дүрэм, дунд хугацааны төсвийн зардлын хүрээ, улсын өр зэрэгт хараат бус дүн шинжилгээ хийж, Парламент болон олон нийтэд мэдээлэх үүргийг гүйцэтгэж байна. Манай Улсын хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь 9 гишүүнтэй, Ажлын алба нь 2 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Монгол улсад засаглалын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2021 онд ТТБЗ-ийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх олон улсын зөвлөхөөр Паул Гарденар ажилласан бөгөөд түүний өгсөн зөвлөмжид ТТБЗ-ийн Ажлын алба доод тал нь 5 үндсэн ажилтантай байж макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөл боловсруулах боломжтой талаар дурдсан болно. Иймд ТТБЗ-ийн ажлын албаны орон тоог нэмэгдүүлэн гишүүдийг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж, УИХ-ын гишүүд болон олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэдэг байх нь зүйтэй гэж үзэж байна.

ГУРАВ. АВСТРИ УЛСЫН ТУРШЛАГА

Төсвийн төлөвлөлтөөс төсвийн гүйцэтгэл хүртэлх гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа

Австри улсын Эдийн засгийн судалгааны хүрээлэн (WIFO)

Төсвийн төсөөлөл боловсруулж буй байдал: Австрийн Эдийн засгийн судалгааны хүрээлэн (WIFO) нь 1927 онд Бизнесийн мөчлөгийн дүн шинжилгээ хийх институт байдлаар анх байгуулагдсан. Өнөөдөр Австри дахь эдийн засгийн судалгааны тэргүүлэх институт бөгөөд ашгийн бус, шинжлэх ухааны үйл ажиллагаагаа улс төр, бизнесээс хараат бусаар явуулдаг. Байгууллагын зорилго нь нийгэм, эдийн засгийн сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах, эдийн засгийн мэдээлэл шаарддаг бизнес, нийгэмд шийдвэр гаргах үндэслэлийг бий болгохын тулд суурь эрдэм шинжилгээний судалгаа, бодлогын хооронд гүүр бий болгох явдал юм.

ЭЗСХ нь үйл ажиллагаагаа 5 бүлэгт хувааж ажилладаг. Тухайлбал, 1) Макро эдийн засаг ба Европын эдийн засгийн судалгаа, 2) Хөдөлмөрийн эдийн засгийн судалгаа, 3) Аж үйлдвэр, инновацийн бодлого, 4) Бүтцийн өөрчлөлт, бүс нутгийн эдийн засаг, 5) Байгаль орчны эдийн засаг, эрчим хүч, хөдөө аж ахуй. Эдгээрээс Макро эдийн засаг ба Европын эдийн засгийн судалгааны бүлэг нь улсын салбарын эдийн засгийн судалгааг хийж, төсвийн төсөөлөл боловсруулах ажлыг хариуцаж ажилладаг байна.

Тус хүрээлэнд 100 гаруй гаруй ажилтан ажилладгаас 60 гаруй нь судлаачид юм. ЭЗСХ-гийн бүтцэд удирдлага, судалгааны бүлгүүд болон туслах үйлчилгээний хэсгүүд багтдаг. Тус хүрээлэнгийн Гүйцэтгэх зөвлөл нь ЭЗСХ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, жилийн төсвийг батлах, Ерөнхий Ассамблейг хуралдуулах зэрэг үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын зөвлөл нь ЭЗСХ-д стратегийн асуудал, судалгааны үйл ажиллагааны чиг баримжаа олгох талаар зөвлөгөө өгдөг.

Үйл ажиллагааны хамрах хүрээ

- Эдийн засаг, нийгэм, экологийн чиг хандлагын дүн шинжилгээ, таамаглал
- Холбогдох сэдвээр шинжлэх ухааны судалгаа, дүн шинжилгээ хийх
- Чанарын баталгаатай эдийн засгийн өгөгдөл нийлүүлэх
- Эдийн засгийн бодлогын арга хэмжээний үр нөлөөг үнэлэх
- Үндэсний болон олон улсын түвшинд нотолгоонд суурилсан эдийн засгийн бодлогын зөвлөгөө өгөх
- Эдийн засгийн бодлогын талаар олон нийт, олон улсын байгууллагуудад шударга мэдээлэл өгөх, (бизнесийн) судалгааг боловсруулах, хэрэгжүүлэх.

ЭЗСХ нь микро, макро эдийн засаг, бүс нутаг, байгаль орчны асуудалд дүн шинжилгээ хийх нарийвчилсан загваруудыг боловсруулж, эдийн засгийн нарийн төвөгтэй ноу-хауг хөгжүүлдэг.

ЭЗСХ-ээс төсвийн төсөөлөл боловсруулж буй туршлага: ЭЗСХ-ийн ойрын болон дунд хугацааны төсвийн төсөөлөл нь ЭЗСХ-ээс хийдэг урьдчилсан таамаглалын нэг хэсэг болдог. Богино хугацааны таамаглал нь тухайн жил болон ирэх жилийг хамарна. Харин дунд хугацааны таамаглал нь богино хугацааны таамаглалаас давсан буюу богино хугацаанд үндэслэн 3 жилээр тооцогддог. *Өөрөөр хэлбэл*, дунд болон богино хугацааны макро эдийн засгийн төсөөллийн бүрэлдэхүүн хэсэг болгож төсвийн төсөөллийг уялдаатай хийдэг ч үр дүн нь тусдаа гардаг. Богино хугацааны таамаглал нь тухайн жил болон ирэх жилийг буюу 1, 2 жилийг хамардаг бол дунд хугацааны таамаглалыг богино хугацааны таамаглалд суурилан түүнээс хойшхи 3 жилийг хамруулан тооцоолдог.

ЭЗСХ-ийн төсвийн төсөөлөл нь макро эдийн засгийн "албан ёсны" таамаглалын заавал хийгдэх ёстой хэсэг биш боловч бид сайн дураар хийдэг гэж болно. Макро эдийн засгийн төсөөллийг албан ёсоор хийдэг, үүн дээр нэмэлт мэдээлэл болгож төсвийн төсөөллийг хийдэг гэсэн үг. Макро таамаглалын төсөвт үзүүлэх нөлөөг эдийн засгийн гол үзүүлэлтүүд болох ДНБ-ий өсөлт, инфляцийн түвшин гэх мэтээр тооцдог. Төсөөлөл бүр харилцан уялдаатай байдаг.

Мэдээллийг хүлээн авагчид нь адил: Төсвийн төсөөллийг Сангийн яам авдаг, түүнчлэн нийгмийн бусад оролцогчид авдаг. Иргэд, хэвлэл мэдээллийнхэн ч сонирхоно.

ЭЗСХ нь төсвийн байдалд мониторинг хийдэггүй, зөвхөн "төвийг сахисан" төсөөлөл хийж, төсөөллийн үр дүнгээ "мэдээлэгч"-ийн үүрэг гүйцэтгэдэг. Төсвийн дүрмийг дагаж мөрдөхгүй байсан ч Сангийн яаманд нөлөөлөл үзүүлэх үүрэггүй (BE, LU, SI дахь институцийн зохицуулалттай төстэй).

Засгийн газрын төлөвлөгөө нь төсвийн дүрэмд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих үүргээ Төсвийн зөвлөлд шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын төсвийн төсөөлөлд мониторинг хийх нь Төсвийн зөвлөлийн үүрэг болсон (хуучин "Штаатсцүльденаусшусс")

Төсвийн таамаглалын үр дүнг холбогдох байгууллагуудын төлөөлөлд танилцуулдаг. Төсвийн төсөөллийн үр дүнг олон нийтэд хүргэх нь манай хүрээлэнгийн гол үүрэг юм. Бид олон нийтийн мэтгэлцээнд өндөр ач холбогдолтой үр дүнг мэдээлэх үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж буйн мэдээлэл гэх мэтэд үндэслэн бидний үйл ажиллагааг хянаж байна гэсэн үг.

Төсвийн төсөөлөл боловсруулах (бэлтгэл ажил): Төсвийн хувьсах өгөгдлийн орлого, зарлагын задаргаатай өгөгдөл гардаг. Орлого, зарлагын мэдээллийг яаж гаргахыг бид өөрсдөө шийддэггүй. Харин Европын холбооны стандарт буюу үндэсний тооцооны систем (ESA)-ийн тодорхойлолт, загварыг ашиглан төсвийн төсөөллийг хийдэг. Өөрөөр хэлбэл, "General Government"-ний жилийн нарийвчилсан төсөөлөл зарлага ба орлого гэсэн үг.

Энэ нь ЭЗСХ-ийн макро эдийн засгийн ерөнхий таамаглалын салшгүй хэсэг, үйл явц болдог. ЭЗСХ-ийн урьдчилан таамагласан макроэдийн засгийн суурь мэдээллийг бусад судлаачид/тэнхимүүд ашигладаг. Дээр дурдсан 5 чиглэлээр судалгааг хийж, манай экспертүүд суурь дараах мэдээллийг гаргаж өгдөг. Жишээлбэл, хөдөлмөрийн зах зээл, хэрэглээ, хүний нөөц, орлого, цалин урамшуулал, мөнгөний бодлогын төсөөлөл – инфляци, хүүгийн түвшин гэх мэт.

Заримдаа суурь мэдээллийг тогтмол өгөгдөл хэлбэрээр, заримдаа iterative байдлаар ашигладаг. Ихэвчлэн өгөгдөл дамжуулалт 2 урсгалтай болдог. Өөрөөр хэлбэл, ЭЗСХ-ийн төсвийн төсөөллийг судлаачид бас ашигладаг. Бид судлаачидтай уулзаж, мэдээлэл солилцож, өөр хоорондоо нягт хамтран ажилладаг. Суурь мэдээллээс гадна гадаад өгөгдлийн санг ашигладаг. Олон улсын байгууллагуудын болон төсвийн тайлан гэх мэт.

ЭЗСХ-ийн хяналт, үнэлгээнд ашигладаг төрөл бүрийн мэдээллийн эх сурвалж, төсвийн баримт бичгүүд бий. Тухайлбал::

- Холбооны Засгийн газар, Сангийн яамны сар бүр ("Монацерфолге")-ийн, жилийн болон дунд хугацааны төсвийн баримт бичиг, тайлан мэдээ
- Австри улсын төсвийн улирлын статистик мэдээлэл
- Австрийн тогтвортой байдлын хөтөлбөр
- Орон нутгийн төсвийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй, Орон нутагт төсвийн хэсэгчилсэн, нарийвчилсан мэдээлэл гарна.
- Холбооны улсын төсвийн талаар нарийвчилсан мэдээлэл болон төсвийн гадуурх үйл ажиллагаа болох эмнэлэг, төрийн өмчит компани, төмөр зам (хувийнх) гэх мэт төсөвт хувь нэмэр оруулдаг байгууллагын мэдээлэл гарах боломжтой.

ЭЗСХ-ийн бусад баримт бичигт хийсэн дүн шинжилгээнд үндэслэдэг. Зарим суурь мэдээллийг олж авахад хэцүү.

- Төсвийн зөвлөл болон Парламентын төсвийн албатай мэдээлэл солилцдог.
- Мөн албан бус мэдээллийг бас ашигладаг. Жишээлбэл, Австрийн төмөр замын компани (ÖBB)-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- Тэтгэврийн комиссын хяналт, хэтийн төлөв
- Цалин хөлсний гэрээ (төрийн салбарын үйлдвэрчний эвлэл)
- Боломжтой хэвлэл мэдээллийн мэдээлэл
- Зарим мэдээллийг "уламжлалт түншүүд"-ээсээ авч ашигладаг.

Ялангуяа ЭЗСХ-ийн эдийн засгийн шинжилгээнд үндэслэсэн хүлээгдэж буй төсвийн төсөөллийн боловсруулалт их сонирхолтой. "Бодлогод өөрчлөлт орохгүй" гэсэн зарчмаар таамаглаж тооцно. Засгийн газрын шинэ төсөл, татварын бодлогын өөрчлөлт нь хэлэлцүүлэх шатанд байсан ч тооцоонд оруулдаггүй. Харин аль хэдийн батлагдсан, хүчин

төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн мэдээлэл, эсвэл Парламент батална гэсэн "бат" таамаглалд үндэслэн төсвийн үр дагаврыг тооцдог (гэхдээ үргэлж тийм биш ...).

"Засгийн газраас гаргасан мэдээгдэл/мэдээлэлд хэрхэн хандах вэ?" буюу Засгийн газрын мэдээгдэл хэр магадлалтайг нягтална.

- Прагматик бодол: "Ямар бодлогын өөрчлөлтүүд нь хэрэгжих магадлалтай вэ?" гэдгийг нягталж, хэрэв хэрэгжвэл төсөвт яаж нөлөөлөхийг тооцох ёстой гэсэн үг. Үүний тулд дараах асуултуудад хариулна.
- "Эдгээр бодлогын арга хэмжээний төсөвт үзүүлэх хүлээгдэж буй нөлөө юу вэ?"
- Үүрэг хариуцлага хүлээхгүй улс төрийн санал уу? эсвэл улс төрийн хатуу амлалт уу? Гэх зэргээр ЭЗСХ-ийн төсвийн төсөөллийн цаана байгаа таамаглалуудыг тодорхой, илэн далангүй ярих нь маш чухал.

Энд анхаарах зүйл нь бид өөрсдийн таамаглалыг хоёрдмол утгагүйгээр болгож байж төсөөллийг хийх ёстой. Учир нь бусадтай судалгааны үр дүнгээ хуваалцана.

Төсвийн төсөөллийг боловсруулахдаа ЭЗСХ-ийн бусад мэргэжилтнүүдээс авсан мэдээллийг рекурсив ба "интерактив" үйл явц талаас нь харгалзан үзнэ. Жишээ нь. хөдөлмөрийн зах зээл, орлого, хэрэглээний таамаглал, үнэ инфляци гэх мэт. Эмпирик, эсвэл "макро эдийн засгийн мэдрэмж"-ийн онолд үндэслэн "тооцоолсон" гол хувьсагчууд, жишээлбэл, цалин, цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн болон цалин, түүнтэй адилтгах орлогын татвараас төсөвт төвлөрөх орлого, жишээлбэл, хувийн хэрэглээний зардалтай холбоотой НӨАТ-ын орлого, ялангуяа дунд хугацааны төсвийн төсөөлөлд хамаатай өөр мэдээлэл ихэвчлэн байдаггүй.

Макро эдийн засгийн загварчлалыг төсвийн төсөөлөлдөө хэрхэн ашигладаг талаар: Дунд хугацааны төсөөллийг хийхэд их ач холбогдолтой. Богино хугацаанд төсөвт өөрчлөлт орж болно. Гэхдээ дунд, урт хугацаанд мэдээлэл бага байдаг.

ЭЗСХ-ийн статус, санхүүжилт: Хараат бус, өвөрмөц статустай. Зарим суурь санхүүжилтийг Сангийн яам, Төв банк зэрэг төрийн байгууллагаас авдаг. Нийгмийн түншүүд, Үйлдвэрчний эвлэлийн холбоод бас санхүүжилт өгдөг. Дотоод, гадаадын төслүүдээс санхүүжилт олдог. Тухайлбал, Итгэлцлийн сан, Европын холбооноос санхүүжилт авдаг.

ЭЗСХ нь Засгийн газар хөндлөнгөөс нөлөөлдөггүй бие даасан байгууллага тул хараат бус статустайгаараа бахархдаг. Судалгааныхаа үр дүнг Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлдэг. Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Судалгааны хамтрагчид: Судалгааг аль аль хувилбараар хийдэг. Бие даасан судалгааны үр дүнгээ олон нийтэд мэдээлдэг. Их, дээд сургуулиудтай, Венийн эдийн засгийн их сургуультай олон судалгааг хамтарч хийдэг. Тодорхой хэлбэл, Ковид-19-ийн үед олон судалгаа хуримтлагдсан байсан тул хамтарсан. Ахисан түвшний судалгааны хүрээлэнтэй өрсөлдөгч хэдий ч хамтарч ажилладаг. Судалгааны нийгэмлэгтэй судалгаагаа уялдуулж, хамтарч ажилладаг.

Төсвийн төлөвлөлт: Дунд хугацааны төсвийн зарлагын хүрээ (МТЕФ буюу ДХТЗХ) нэвтрүүлсэн Австри улсын туршлага

Уламжлалт хэлбэрийн төсөвлөлт нь орцод суурилсан (input based) бөгөөд зардал өндөр, төвлөрсөн шинжтэй, мөнгөн суурьт бөгөөд олон жилийн хөгжлийн төлөвлөгөөг харгалзахгүй байсан тул ДХТЗХ-г хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. СЯ нь Хэрэг эрхлэх газар (ХЭГ)-тай тохиролцож, бусад чиглэлийн яамдын чиг үүрэгт оролцох эрхгүй ч шинэчлэлийг дэмжих зорилгоор, гарсан үр дүнд нь суурилсан урамшуулал олгохыг зөвшөөрөхөөр тохирсон. Энэ шинэ үүргийн хүрээнд ХЭГ яамдын гүйцэтгэлийн үнэлгээ, биелэлтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх эрх, үүрэгтэй болсон.

ДХТЗХ нь 5 чиглэлээр (Rubrics гэж нэрлэдэг, хэд хэдэн яамдыг хамарсан) 30 төсөв (яамдаар) тогтооно. 4 жилийн хэтийн төлвийг буюу холбогдох зардлын хязгаарыг стратегийн тайлантай хамт баталж өгнө (n+4, жил бүр нэг жилийг нь нэмнэ). Хоёр төрлийн төсвийн хязгаар зааж өгнө. Хязгаар нь дараах 5 салбараар тогтоогдоно (Rubrics). Үүнд:

1. Хууль, аюулгүй байдал (Төрийн ерөнхий хэргийн газар, Шүүх болон Аюулгүй байдал)

2. Ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд гэр бүл
3. Боловсрол, судалгаа, урлаг, соёл
4. Эдийн засаг, дэд бүтэц, байгаль орчин
5. Санхүүгийн удирдлага

Эхний хязгаар (nominal fixed ceiling) - Тогтоосон хэмжээний ¾ нь. Хоёр дахь хязгаар (variable ceiling) – тогтоосон үзүүлэлтээс хамааран өөрчлөгдөнө. Автомат тооцоолох боломжийг оруулах ба эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран зорилтод үзүүлэлт, зардал өөр өөр байна. Энэ хүрээнд тогтвортой байдлын хөтөлбөр, яамдын хүний нөөцийн дээд хязгаарыг тогтоож өгнө. Хугацааны хувьд зарцуулалтыг хойшлуулах (хавраас-намар) зөвшөөрдөг, мөн мөнгөн болон санхүүгийн үзүүлэлтүүдийг аккурель болон мөнгөн сууриар зааж өгнө.

Австрийн төсвийн шинэчлэлээс авах сургамж:

- Шинэчлэлийг Засгийн газар загвар гаргаж манлайлан хэрэгжүүлэх хэрэгтэй, хэн нэгэн зөвлөх үйлчилгээнд найдах хэрэггүй.
- Бусад улсын туршлагыг сайн судлах (Швейцарийн туршлага)
- Загварыг гаргахад хэдэн жил шаардсан, бэлтгэлдээ хугацаа зарцуулах.
- Парламент дахь улс төрийн шийдвэр, дэмжлэг чухал нөлөөтэй.
- Гаднаас цөөн хэдхэн зөвлөх авч хэрэгжүүлсэн бөгөөд, өөрсдийн албан хаагчдыг чадавхжуулах.
- Оролцогч талууд болох төрийн албан хаагч, улс төрчид, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сонирхогч иргэдийн мэдлэг, чадвар чухал нөлөөтэй. Үүнийг сайжруулахын тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгаа их явуулж байсан.
- Тасралтгүй сургалт, бусдад мэдээллээ байнга хуваалцах хэрэгтэй, шинэчлэлийн давуу тал, үнэ цэнийг давтан сайн хэлж байх хэрэгтэй, шаардлагатай бол үүнд цаг зарцуулах хэрэгтэй.
- Төсвийн шинэчлэл хийхэд аль түвшинд хийх вэ гэдэг нь чухал. Үндсэн хуулиар зааж өгвөл, эргэж буцахгүй тогтвортой, гэхдээ уян хатан байдал муу. Илүү уян хатан байлгах гээд зөвхөн журмаар зохицуулбал, буцаад хуучин систем рүү орох эрсдэлтэй байдаг.

2009 оноос Дунд хугацааны төсвийн төлөвлөлт, стратегийн шинэчлэлийг эхлүүлж, төсвийн журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх болсон. Яамдад үлдэгдэл төсвийг дараа жил рүү шилжүүлэх, өөрсдөө ач холбогдолтой ажлаа эрэмбэлж зарцуулах боломж олгосон.

Ингэснээр “12-р сарын халуурал-ханиад” (December Fever) буюу 12-р сард хэт өндөр зардал гардаг байсан явдлыг зогсоосон бөгөөд яамд хэрэгтэй зүйлсээ хэрэгтэй цагт нь худалдан авах боломжтой болсон. Жишээ нь, нэгэн төслийн бэлтгэлд зориулан компьютер худалдан авах ёстой, түүний төсөв нь энэ жил батлагдсан, гэхдээ төслийн бэлтгэл ажил гүйцээгүйгээс болоод одоогоор худалдан авах шаардлага үүсээгүй гэж бодъё. Ийм тохиолдолд заавал одоо компьютер худалдан авч хадгалах шаардлагагүй. Дараа нь яг хэрэгцээтэй үед нь тохирсон хүчин чадлын, орчин үеийн компьютер худалдан авах боломжоор нь хангаж байгаа юм. Ингэснээр яамд төсвөө хураалгана гэсэн айдасгүй болсон бөгөөд мөн зарцуулалтаа илүү хариуцлагатай, ач холбогдолтой зүйлсэд зарцуулж, өөрсдөө ч бүрэн хариуцлага хүлээх болсон байна.

Австри улсын нягтлан бодох бүртгэл-Аккруэл суурьтай бүртгэл

Австри улсын Сангийн яам аккруэл бүртгэлийг хэрхэн нэвтрүүлж ирсэн талаарх туршлагаа танилцуулав. Танилцуулгад аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл ба төсвийн гүйцэтгэл, Австрийн улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын аккруэлд шилжих үйл явц, бодлогод тулгарч буй сорилтууд гэсэн сэдвүүд багтсан байлаа.

Австри улс нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэгжүүлэхдээ дараах үе шатуудыг туулсан. Үүнд:

- 2004 - 2007: сургалт судалгаа, уулзалт, үндсэн хууль болон төсвийн хуулинд өөрчлөлт орох төслийг боловсруулсан. Үндсэн хуулинд холбогдох өөрчлөлтийг

тусгаснаар тулгуур зарчмыг бат бөх тавьж өгсөн бөгөөд төсвийн хуулиар илүү тодорхой зааж өгсөн байна. Энэ үйл явцыг "гүүрийг шатаах" гэж нэрлэжээ.

- 2009 оноос шинээр өөрчлөлт орсон эрх зүйн актуудыг үе шаттайгаар мөрдөж эхэлсэн (2009 онд 1-р шат, 2013 оноос 2-р шат).
- 2009 – 2013: IT системүүдийг туршсан, нягтлан бодох бүртгэлийн гарын авлага, нарийвчилсан дүрэм журмыг боловсруулсан, мөн эхлэлийн тайлан балансын жишиг төслийг боловсруулсан
- 2013 оноос хойш: аккруэл суурьтай төсөв, нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлийг бүрэн хэрэгжүүлсэн гэж хэлж болхуйц ахицтай байна. Цөөн хэдэн стандартыг тодорхой шалтгааны улмаас хэрэгжүүлээд нэмэлтээр бэлтгэл ажил хугацаа шаардлагатай болсноор хэрэгжүүлээгүй байна.

Эрх зүйн орчны шинэчлэлийг дараах үе шатаар хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нэгдүгээр түвшин: Үндсэн хуулинд суурь үзүүлэлт (шударга, үнэн зөв үзэл) -г шигтгэж өгсөн.
- Хоёрдугаар түвшин: Төсвийн хуулиндаа холбогдох өөрчлөлтийг оруулж өгсөн.
- Гуравдугаар түвшин: Дагалдах журмыг шинэчлэн батлуулсан.
- Дөрөвдүгээр түвшин: Гарын авлага, зааврыг нарийвчлан боловсруулсан
- Шинэчлэлийн загвар: Зөвлөхүүд биш төрийн алба (Сангийн яам) боловсруулсан шинэчлэл нь удирдлагын хүрээнд өмчлөл, мэдлэгийг бий болгож байна.

Яагаад аккруэл нягтлан бодох бүртгэл болон төсөвлөлт гэж?

- Аккруэл систем нь бэлэн мөнгөний системээс илүү сайн мэдээлэл өгдөг. Тухайлбал: Мөнгө суурьт тайлан нь орлогыг харуулдаг боловч хөрөнгийн бууралтыг харуулгүйгээс ирээдүйн болон өнөөгийн үнэ цэнийг дутуу илэрхийлдэг. Мөн өглөг авлагын бүртгэл аккруэл сууриар зөв мэдээлэгдэх боломж бүрддэг.
- Аккруэл нь бэлэн мөнгийг орлохгүй боловч нэмэлт хэтийн төлөвийн талаар ойлголт өгдөг. Бэлэн мөнгөний менежмент нь аккруэл системийн салшгүй хэсэг.

Нэвтрүүлэлт- Австри улс юуг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлэв:

- Шинэ эрх зүйн орчны хэрэгжилтийг хангахад Австри улсын сангийн яамны холбогдох газар хэлтэс манлайлан оролцсон ба бусад мэргэжлийн институтыг татан оролцуулсан. Тухайлбал төрийн сургалт хариуцсан мэргэжлийн байгууллагаар сургалтыг гүйцэтгүүлсэн, яамд болон салбар бүрт сургагч багш нарыг бэлтгэсэн. Мөн шинэчлэлийг хийхээс өмнө бусад орны шинэчлэлийн жишээг тухайлбал швейцарыг судалж сайн туршлагаас нэвтрүүлсэн. Аккруэл суурьт бүртгэлд шилжих үйл явцад олон талын оролцоо чухал бөгөөд түүний дотор парламент, европын холбоо, мэргэжлийн институтын оролцоо чухал түлхэц нөлөөг үзүүлсэн байна. Нэвтрүүлэлтийн стратеги төлөвлөгөө загварыг гаргахад судалгаа шинжилгээ зэрэгт нилээд цагийг зарцуулсан.
- Энэ шилжилтийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор 30 сая евро (зөвхөн аккруэл биш) зарцуулагдаад байна өнгөрсөн хугацаанд. Аккруэл суурьтай бүртгэл рүү шилжих зардал өндөр биш харин зохицуулалтын арга хэмжээг олон талаас авч хэрэгжүүлэх шаардлага тулгардаг тул дунд урт хугацаандаа чамбай төлөвлөлт шархуу хүчин чармайлтыг шаардана.
- Шинэчлэлийг хийхийн тулд сангийн яам цөөн хүн нэмэлтээр хөлслөн ажиллуулсан. Одоо байгаа ажилтнууд шинэчлэлийг боловсруулах, хэрэгжүүлэхэд маш сайн туршлагатай байж хангалттай оролцоотой байсан.

Бодлогод тулгарч буй сорилтууд

- Өнгөрсөн хугацаанд бэрхшээлгүй байсан гэвэл үгүй юм. Төслийн багийнхний урьдчилан хараагүй шийдвэрлэх шаардлагатай сорилтууд тулгарч байв. Тухайлбал шинийг хүлээж авах байгууллагын соёл. Зарим байгууллага маш хурдан зааврын дагуу явж байхад зарим шалтаг тоочин хойш суугчид байсан нь нийтэд буруу үлгэр дуурайлал болж байв. Сургалтын чанарыг ахиулахын тулд бурам-ташуурын бодлого барив. Өөрөөр хэлбэл та сайн суралцагч байгаад шинэчлэлийг зөв зүйтэй хурдтай хэрэгжүүлбэл ажлын үзүүлэлтийг нэмэгдүүлж

урамшуулах, харин үндэслэлгүйгээр хойш суусан бол хариуцлагын механизмыг тогтоож өгсөн.

- Түүнчлэн бас нэгэн бэрхшээл бол УСНББОУС нь улс орон болгонд яв цав сууж хэрэгжихэд учир дутагдалтай учир нь улс орон болгоны эрх зүйн харилцаа өөр өөрөөр тогтсон байдаг. Австри улсын тухайд техникийн болон улс төрийн шалтгааны улмаас стандарт бүрийг бүрэн хэрэгжүүлээгүй.

Австри улсын сургамж:

- Улс төрийн болон захиргааны дээд түвшний амлалт нь чухал
- Оролцогч талуудын ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай (төрийн албан хаагчид, улс төрчид, хэвлэл мэдээлэл, сонирхогч олон нийт)
- Өргөн хүрээний сургалт шаардлагатай
- Тууштай байдал
- Шинэ мэдлэгээ хадгалах + шинэ хэрэгслийг эрчимжүүлж, өргөжүүлэх
- Сургалтыг давтан үе шаттайгаар ахиулан хийсээр байх
- Байнгын харилцаа холбоо- талуудын эргэх холбоо тасалдалгүй байх
- Гарч буй зэрэг үр нөлөөг байнга сануулж байх. Ингэснээр энэхүү шижилтийн үнэ цэнэ, ашиг тусыг оролцогч талуудад давтан сануулсаар байх
- Илүү их цаг зарцуулах тууштай байж хэрэгжилтийг хангах анхан шатны нэгжийг тогтмол эрчимжүүлж тэдний оролцоо хэрхэн чухал болохыг сануулсаар байх.

Аккруэл бүртгэлийг нэвтрүүлсэн Австри улсын сайн туршлага, сургамж:

- Эрх зүйн орчны тогтвортой байдал. Шинэчлэлийг бүх шатны эрх зүйн актад ерөнхийгөөс тодорхой руу чиглэн тусгаж өгсөн байна. Тухайлбал, Үндсэн хууль, төсвийн хууль, бүртгэлийн хууль, холбогдох журамд шинэчлэлийг тусгаж гарын авлага зааврыг нарийвчлан боловсруулсан ингэхдээ бусад улсын сайн туршлагыг шингээж өгсөн байна.
- Урт хагацааны судалгаан дээр суурилсан нэвтрүүлэлтийн стратеги төлөвлөгөөг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлсэн.
- Сургалтыг өртөг зардал бага байхаар төлөвлөн мэргэжлийн институтын оролцоог хангасан байна. Ингэхдээ сургагч багшийг бэлтгэжээ.
- Эргэх холбоог сайтар харгалзан үзэж оролцогчдыг хөтөлбөрийн хэрэгжилт, ахицын талаарх мэдээллээр тогтмол хангаж ирснээр нэвтрүүлэлт амжилттай урт хугацаанд тогтвортой улс төр болоод гол оролцогчдын дэмжлэгтэйгээр ахицтай хэрэгжиж иржээ.
- Төсвийн сахилга батыг өндөрт эрэмбэлэн авч үзэж бүх санхүүгийн ажил үйлчилгээнд дөрвөн нүдний буюу давхар хяналтын зарчмыг суулгаж өгсөн нь тайлагналын үнэн зөв байдал хангагдахад чухал нөлөө үзүүлжээ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ШИНЭЧЛЭЛ ХАРИУЦСАН ТӨВ - Centre for Financial Reporting Reform (<https://cfrf.worldbank.org/programs/pulsar>)

Австри улсын Вена дахь Дэлхийн банкны оффист байрладаг Санхүүгийн тайлагналын шинэчлэлийн төв нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын хөтөлбөрүүд (Public Sector Accounting and Reporting-PULSAR)-ийг хэрэгжүүлдэг. Энэ нь бүс нутаг болоод тухайн оронд хэрэгжүүлдэг хөтөлбөр бөгөөд улсын секторын нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын хүрээг тогтоож энэ хүрээндээ олон улсын стандартууд болон шилдэг туршлагуудыг шингээж өгдөг. Өнгөрсөн хугацаанд баруун балканы болон европын холбооны зүүн түншлэлийн орнуудыг хамарч хэрэгжүүлсэн. Энэ нь 3 гол бүрэлдэхүүн хэсэгтэй:

- Тухайн шинэтгэлийн ач холбогдлыг ойлгох мэдлэг олгох
- Тухайн орны санхүүгийн тайлагналийн хүрээ бүтэц болон хэрэгжилтийн зарчмыг тодорхойлох
- Тухайн орны санхүүгийн ажилтны чадавхыг дээшлүүлэх

Энэ хүрээндээ гарын авлага боловсруулж хөтөлбөрт хамрагдсан орнуудад хүргүүлсэн үүнийг бусад орон авч ашиглахад нээлттэй цахим хуудастаа байршуулсан. Мөн аккруэл бүртгэлийн шинэчлэлийн ач холбогдол нэвтрүүлэлтийн өртөг зардлын тооцооны

талаар хийгдсэн судалгааны тайланг олон нийтэд хүргэж ажилладаг. Сар бүр тодорхой чиглэлээр судалгааны материал гаргаж цахим хуудсаараа олон нийтэд хүргэдэг.

Дээрх үндсэн хөтөлбөрүүдээс “тухайн орны санхүүгийн ажилтны чадавхыг дээшлүүлэх” хөтөлбөрийг дэлгэрүүлбэл:

- Сургалтын хөтөлбөрийг Сангийн яамнаас баталдаг. Энэ хөтөлбөртөө хамрагдах суралцагчид болоод хамтран хэрэгжүүлэх талуудыг тодорой тусгасан байдаг. Сургалтаа хэрэгжүүлэхдээ боловсролын байгууллагуудаа түшиц төв болгодог.
- Сургалтад оролцогч талуудын эргэх холбоог бат бэх тогтоож тогтмол сар бүр хэрэгжүүлсэн ажлын ахицаа ярилцахын зэрэгцээ дараагийн шатанд гарсан асуудлуудаа хэрхэн шийдвэрлэж энэхүү хөтөлбөрөө амжилттайгаар үргэлжлүүлэх вэ гэдгээ ярилцаж дундын шийдэл ойлголцолд хүрдэг нь чухал байдаг.
- Сургалтын модуль боловсруулсан. Их дээд сургуулийн хичээлийн агуулга бидний зохиод байгаа стандартуудыг агуулж байна уу гэдгийг анхаарах нь чухал.
- Сургалтын хөтөлбөрийг жил бүр шинэчлэн боловсруулах. Ингэхдээ өмнөх туршлагаасаа суралцан улам сайжруулдаг.

Стратегийн түншлэл: Засгийн газар, УИХ, бүс нутгийн ижил төстэй мэргэжилийн байгууллагуудтай холбоотой ажиллах нь чухал юм. Хамтарсан хэлэлцүүлэг хийдэг. Монголд авч хэрэгжүүлэх санал.

- Монголд энэхүү PULSAR хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судалж хариу ирүүлэхийг хүслээ. Учир нь тус хөтөлбөр нь зорилтод бүс нутагт чиглэсэн хөтөлбөр тул манай улсад хэрэгжүүлэх боломжийг тус төвөөс судалж хариу хүргүүлэхээр тогтов.
- Мөн тус байгууллагаас хэрэгжүүлдэг хөтөлбөрийн тайлангууд болон сар бүр гаргадаг бусад судалгааны тайлантай цахимаар танилцах бүрэн боломжтой байна.

АВСТРИ ДАХЬ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СИСТЕМ

Австрийн гарцад буюу үр дүнд чиглэсэн системийг дараах 2 арга хэрэгслийг ашиглан хэрэгжүүлдэг байна. *Нэгдүгээрт*, гүйцэтгэлийн удирдлага, *хоёрдугаарт*, зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ.

Үр дүнд чиглэсэн хандлага бол Сангийн яамтай яг холбоотой асуудал. Энэ тогтолцоог Австрид 2013 онд нэвтрүүлсэн, түүнээс өмнө их олон асуудал тулгардаг байсан. Үндсэндээ урт хугацааны төлөвлөлт гэсэн ойлголт байсангүй, төсвийн хувьд урт хугацааны төлөвлөлтгүй явж байсан байна. Санхүүгийн нөөц, хүний хүчин зүйл гэх зэрэг орцуудыг илүү их анхаардаг байсан. Шинэ төслүүд гээд одоо гарц, үр дүн дээр суурилчихаар асуудлаа бүгдийг нь шийднэ гэж бодсон чинь бас л тэдний эрэлхийлэл дуусаагүй байна.

Төсвийн төлөвлөлтийн хүрээнд эхний ээлжинд зорилтуудаа тодорхойлох ёстой. Зорилтууд улс төрчдөөс тунхаглагдаад гарч ирдэг. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс зорилт, зорилгуудаа тодорхойлж авна. Энэ зорилтыг үндэслээд үр дүнгээ тодорхойлдог. Гарц дээрээ суурилад тухайн гарцыг гаргахын тулд ямар орц хэрэгтэй вэ гэдгийг тооцдог, гадаад хүчин зүйлүүдийг заавал харгалздаг. Гадаад хүчин зүйл гэдэг нь Ковид, эсвэл Украины дайн гэх зэрэг гадаад хүчин зүйлийг зайлшгүй харгалзах хэрэгтэй байна. Учир нь эдгээр хүчин зүйл гарцад шууд нөлөөлдөг.

Зорилтуудаа улс төрчдийн, Засгийн газрын бодлогоос гаргаж авна, тэр зорилтуудаа цаашаа үр дүн болгож задалж байна. Жишээлбэл, замын аюулгүй байдлын чиглэлээр замын осол, эндэгдлийг бууруулах зорилтыг тодорхойлно гэж бодъё. Замын ослыг бууруулна гэсэн үр дүнд яаж хүрэх ёстой бэ? Энэ жишээн дээр өгөгдлүүдээ харахад ихэнх замын осол 5 дахь өдөр юм уу, хагас сайн өдөр гардаг. Энэ өдрүүдэд хүмүүс согтууруулах ундаа их хэрэглэж байна, 5 дахь өдрийн орой болон амралтын өдөр осол аваар их гарч байна гэсэн тийм статистик байдаг.


Эндээс үндэслээд ямар үйл ажиллагааг хэрхэн томьёолох вэ? гэхээр тээврийн хэрэгслийн жолооч нарын сургалтад их анхаарах хэрэгтэй. Иймээс шинэ журам нэвтрүүлнэ гэсэн үг. Энэ журмыг амжилттай нэвтрүүлэх юм бол зам тээврийн осол буурна гэсэн хүлээлт үүсэж байна. Сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн ч гэсэн тээврийн хэрэгслийн түгжрэл, эсвэл байгаль цаг уурын улмаас тээврийн аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй. Энэ гадаад хүчин зүйлийг заавал харгалзах ёстой.

Үр дүнд чиглэсэн системийг хэрэгжүүлэхийн тулд 2009 онд дунд хугацааны төсвийн зардлын хүрээгээ боловсруулсан (Дэлгэрэнгүйг танилцуулга слайдаас үзэх боломжтой). Стратегийн төлөвлөлтөө дараагийн 4 жилийн туршид хийж эхэлсэн. 2013 оноос эхлээд энэ үр дүнд чиглэсэн системийг бүрэн дүүрэн нэвтрүүлсэн.

Өмнө дурдсан 2 гол арга хэрэгслийг ашиглаж байна. Нэгдүгээрт, гүйцэтгэлийн удирдлага, энэ нь шууд төсөвтэйгөө холбогдож байгаа. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтээ томьёолоод гаргадаг. Салбарын яам болгон өөрийн үзүүлж буй үйлчилгээний үр дүнгийн мэдэгдлийг хийж өөрсдийн үзүүлэлтүүдээ томьёолж өгдөг. Ямар зорилтод хүргэх мэдэгдлээ салбарын яам болгон хийх ёстой. Төлөвлөгөө, хэрэгжилт, үнэлгээ, тайлагнал гээд дараа нь яг энэ мөчлөгөөрөө давтаад явдаг.

Хоср дахь арга хэрэгсэл болох “зохицууллын нөлөөллийн үнэлгээ” гэдэг бол шинэ хууль тогтоомжийн тухайд юм. Үүний мөчлөг нь адилхан төлөвлөгөө, хэрэгжилт, үнэлгээ, тайлагнал гээд яг тэр мөчлөгөөрөө давтагдаад явна.

Төсвийн болон гүйцэтгэлийн бүтцийг зурагт харуулав. Зүүн гар талд төсвийн бүтэц, баруун гар талд төсөвтэйгөө уялдсан гүйцэтгэлийн бүтцийг харуулж байна. Австрид төсөв 5 түвшинд хуваагддаг. Хөдөө аж ахуй, дотоод хэрэг гэх зэрэг чиглэлүүдээр хуваадаг. Үүний дараа глобал ерөнхий төсөв гэж гарч ирж байгаа. Ерөнхий төсөв цагдаагийн байгууллагынх гэж бодох юм бол, улмаар төсвийн задаргааг нь гаргавал бүс нутаг болгоны цагдаагийн албаны төсөв гэж задардаг. Гүйцэтгэлийн бүтцийн хувьд нийт бодлоготойгоо глобал төсвийн хувьд үр дүнгийн мэдэгдлүүдээ гаргаж ирдэг, өөрөөр хэлбэл, тэр үр дүнгийн хувьд ямар зорилтыг агуулж байгаа юм бэ гэдгээ тусгаж өгсөн байна.



Нарийвчилсан төсвийн түвшинд гүйцэтгэлийн гэрээндээ тусгадаг. Төсвийн зүйлээ бүлэг болгоноор хамгийн ихдээ 5 зорилтыг тодорхойлдог. Яагаад 5 байдаг гэхээр салбарын яамдад бодлогын нэн тэргүүний чиглэлийг тодорхойлох боломжийг олгож байгаа юм. Жил бүр салбарын яамд өөрсдийн бодлогын тэргүүлэх чиглэлээ тодорхойлох ёстой. Тэр зорилгуудын дор хаяж нэг нь заавал жендертэй холбоотой байх ёстой. Глобал төсөв болгоноор 5 хамгийн ихдээ үйл ажиллагааг тусгадаг. Үүний наанадаж нэг нь жендерийн өнгө аястай байх ёстой. Тэгээд дэлгэрэнгүй нарийвчилсан төсөв рүүгээ ордог байна. Улмаар гүйцэтгэлийн гэрээ болж задардаг байна. Салбарын яам бүрээр төсвийн түвшинд бүтцийн задаргааг ярилцдаг байна.

Жишээлбэл, боловсрол гэсэн төсвийн 30 дугаар зүйл анги байна. Боловсролын салбарын мэдэгдлээ тавьдаг. Тухайн жилд 3 гарцын зорилттой, эрх тэгш боловсролын зорилго агуулж байна, мөн боловсролын чанарын зорилгыг агуулна. Энэ зорилго, зорилт болгоноор үзүүлэлтээ томьёолж өгдөг.

Бодит үнэлгээ болон хүрэхээр зорьж байгаа үзүүлэлтүүдийг тусгаж өгөх ёстой. Эцэст нь цуглуулж байгаа бүх мэдээллээ нэгтгээд нэг хүснэгтэд оруулна. Зорилт болгоноор үзүүлэлтээ томъёолоод тооцоогоо хийнэ. Тэгээд суурь өгөгдлүүдээ томъёолно. Мөн зорилтот үзүүлэлтээ гаргаж ирнэ, түүнчлэн өмнөх жилийн үзүүлэлтийг заавал харгалзах ёстой. Жишээлбэл, 2015 оны гүйцэтгэлийн бүтцээ тодорхойлохдоо 2013, 2014 оны төсвийн тоонуудаа хардаг. Зорилтот тоонуудаа харж байж, 2015, 2016 оны дунд хугацааны төлөвлөлтийг эдгээр тоон дээрээ үндэслэж хийх ёстой. Салбарын яам бүрийн гүйцэтгэл, үр дүнгийн томъёоллыг ингэж хийдэг байна.

Аливаа үйл ажиллагааны хувьд яг одоогийн үнэлгээгээр тооцсон үнийн дүн болон ирээдүйн үнэлгээгээр тооцсон хүлээгдэж буй үр дүн гэсэн 2 баганаар тооцоогоо хийдэг. Нийт үйл явцын мөчлөгийг авч үзвэл эхлээд стратегийн төлөвлөлтөөсөө эхэлдэг. Дараа нь гарцын болон үр дүнгийн мэдэгдлүүдээ хийж байгаа. Тэгээд гүйцэтгэлийн гэрээндээ тусгаж байна. Хэрэгжилтийг зохион байгуулсны дараа үнэлгээний үйл явцыг эхлүүлдэг. Салбарын яамд дотоод үнэлгээгээ өөрсдөө хийдэг. Үнэлгээний үр дүнг тус яаманд ирүүлж, яам тэрийг нь хянаад чанарын баталгаа олгодог. Тус яам бүх мэдээллийг нэгтгээд, тайландаа тусгаад парламентад хүргүүлдэг.

Сангийн яам төсвийн зардлын хязгаарыг салбарын яам бүрээр тодорхойлно. Төрийн албаны яам хүний хүчин зүйл, боловсон хүчнийхээ нөөцийг тодорхойлно. Салбарын яам бүр Урлаг, соёл, төрийн алба болон спортын яам (УСТАСЯ)-нд мэдээллээ ирүүлээд, тус яам чанарын баталгаа гаргана, Сангийн яам мөн адил чанарын баталгаа гаргана.

Аудитын байгууллага мөн адил яамдын мэдэгдэлд нь аудитын хяналт, шалгалт хийж өөрсдийн дүгнэлтийг гаргана. Төсвийн саналыг тус яам хянасны дараа Сайд нарын зөвлөлдөө оруулдаг. Эцсийн шийдвэр гарсны дараа хэрэгжилт болон үнэлэлт дүгнэлт, үнэлгээний үйл явц өрнөдөг.

Дараагийн 4 жилийн стратегийн хүрээг тогтоох баримт бичгийг УСТАСЯ одоо боловсруулж байна, стратегийн хүрээний баримт бичгээ дараагийн 4 жилийг хамруулаад жил бүр боловсруулж гаргадаг.

Гуравдугаар үе шат бол *тайлагнал*. Үр дүнгийн үнэлгээ, тэгээд тайлагнал байна. Салбарын яам болгон дотоод үнэлгээ, мониторингоо хийнэ. Өөрсдийн анхлан хийсэн мэдэгдэл дээрээ өөрсдийнхөө үнэлгээ, дүгнэлтийг хийх ёстой. Тэгээд үнэлгээнийхээ үр дүнг УСТАСЯ-ны Гүйцэтгэлийн удирдлагын албанд хүргүүлдэг. Бүх яамдаас дотоод хяналт шалгалт, үнэлгээний тайланг хүлээж авдаг. Тус албанаас салбарын яам болгонд чанарын баталгаа гаргаж өгдөг. Нийт зохицуулалтыг тус албаны зүгээс хийдэг байна. Дараа нь салбарын яам болгонд тус албанаас өөрсдийн дүгнэлтээ хүргүүлдэг. Яамдын үнэлгээ дээр ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулах, хасах асуудлыг тус албанаас шийддэг байна. Тус албаны саналыг тусгасан шинэчилсэн тайланг яамдаас хүлээж аваад өөрсдийн дүгнэлтийг боловсруулан парламентад хүргүүлдэг байна. Энэ үр дүнг парламентаар хэлэлцэх ёстой. Үр дүнгийн хэлэлцүүлгийг өрнүүлсний дараа салбарын яам болгон дараа жилийн төлөвлөгөөгөө боловсруулдаг байна.

Энэ тогтолцоогоо яамны зүгээс мэдээллийн технологийн арга хэрэгслээр баталгаажуулж, дэмжиж ажиллуулдаг. Бүх тайланг тус яам цахимаар хүлээж аваад хийсэн үнэлгээнийхээ дүгнэлтийг цахимаар хүргүүлдэг. Энэ бүх багц мэдээллийг цахимаар болон цаасаар хэвлэж бэлэн болгодог.

Гүйцэтгэлийн менежментийн тайланг төсвийн зүйл анги болгоноор дүгнэж гаргадаг. Слайд дээр дугуйлсан цэгүүд дээр төсвийн зүйл ангиудыг бүгдийг нь тусгасан. Сонирхож байгаа зүйл анги дээрээ очоод дарахад төсвийн заалтын талаар нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээлэл гарна. Энэ мэдээллийн санд 2013 он хүртэлх бүх иж бүрэн цогц мэдээллийг хадгалсан байна. Энэ процессын гол санаа, зорилго нь нэгдүгээрт салбарын яамдыг орцод суурилсан хандлагаас татгалзахыг бид дэмжиж, хөшүүрэг болж байна. Мөн бусад нарийвчилсан төлөвлөгөөтэй ажиллах сэдлийг илүү дэмждэг. Үүний зэрэгцээгээр илүү нээлттэй, ил тод байдлаар парламенттай, олон нийттэй харьцах үүд хаалгыг нээж өгдөг байна. Ингэснээр иргэн бүр энэ улсын мөнгө хаанаас хаашаа яваад, юунд зарцуулагдаж байгаа, ямар төсөлд зарцуулагдаад, тэр төсөл нь ямар үр шим өгөөд байгаа юм бэ гэдгийг мэдэх эрхтэй болдог байдаг.

Үр дүнд чиглэсэн нөлөөллийн үнэлгээ: Холбооны менежментийн оффис болон Гүйцэтгэлийн менежментийн оффис 2 арга хэрэгслийг ашигладаг. Нэгдүгээрт, төсөвтэй нягт холбоотой үр дүнд чиглэсэн хандлагыг ашиглаж байна. Хоёрдугаарт, үр дүнгийн нөлөөллийн үнэлгээг хийж байна. Бусад оронтой харьцуулахад Австри их өвөрмөц юм. Зарим орнуудад ижил төстэй систем нэвтрүүлсэн байдаг. Төсөвлөөд, үр дүнд чиглэсэн гүйцэтгэлийн төсөвлөлт гэх зэрэг энэ чиг үүрэг, хариуцлагыг Сангийн яам гүйцэтгэдэг, энэ утгаараа парламенттайгаа их нягт ажилладаг. Нөлөөллийн үнэлгээг ихэнх орнуудад зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ гэж нэрлэж байгаа. Энэ чиг үүрэг нь Ерөнхий сайдын харьяанд, эсвэл Хууль зүйн яамны харьяанд байдаг. Жишээлбэл Германд биеэ даасан институциуд энэ нөлөөллийн үнэлгээг хийдэг. Тодорхой төслүүдийн хувьд яам нөлөөллийн үнэлгээг хийж байгаа. Үүний зэрэгцээгээр энэ гүйцэтгэлийн төсөвлөлтийг бас ашигладаг. Энэ 2 арга хэрэгслийг өөр хооронд нь цогцоор уялдаа холбоотой ашиглах ёстой. Тодорхой төслийн саналуудад хэдий хэмжээний төсөв хөрөнгө зарцуулсан бэ, тэр нь нийгэмд ямар үнэ цэнийг бүтээв гэдгийг энэ нөлөөллийн үнэлгээгээр гаргаж ирнэ гэсэн үг.

Концепцийн хувьд, нөлөөллийн үнэлгээг шинэ хууль батлаад, эсвэл шинэ журам нэвтрүүлснээр хэрэгжүүлдэг. Энэ арга хэрэгслийн талаар ЭЗХАХБ-ын зохицуулалтын бодлогын хорооноос санаанууд гардаг. Олон улсын түвшинд өөр өөр байгууллагууд, өөр өөр хороод энэ асуудлыг хариуцдаг. Зохицуулалтын бодлогын хувьд зөвхөн Австрид нөлөөллийн үнэлгээний цар хүрээг илүү өргөн нэвтрүүлсэн байна. Зөвхөн шинэ хууль тогтоомжоор хязгаарлахгүй, худалдан авах ажиллагааны үе шатууд, дэд бүтцийн төслүүд гэх зэрэг өргөн талбарыг хамарч байна. Өөрөөр хэлбэл аливаа нэгэн төслийн саналууд гарч ирэх юм бол бүгдэд нь нөлөөллийн үнэлгээ хийх ёстой.

Бүрэн дүүрэн нөлөөллийн үнэлгээ хийх үү, эсвэл нэг хуудас тайлбар дүгнэлт гаргахад болох уу гэдгийг тус алба санал бүр дээр гаргана. Үр дүнд чиглэсэн нөлөөллийн үнэлгээ гэдэг нь үндсэндээ үр дүнг нь илүүтэй хардаг байна. Энэ саналыг хэрэгжүүлэх юм бол эдийн засаг, нийгэмд ямар ач тустай юм бэ гэдгийг, яг тэр үр дүнгээр нь үнэлдэг байна. Энэ үр шимийг гаргахын тулд ямар үр дүнтэй байх ёстой юм бэ. Энэ үр дүнд хүрэхийн тулд юу хийх ёстой юм бэ гэдгээ томъёолно гэсэн үг. Аливаа нэгэн бодлогын чанартай саналын хүлээгдэж байгаа болон хүлээгдээгүй үр дүнгүүд бас гардаг, эдгээрийг бүгдийг үнэлдэг. Жишээлбэл боловсрол, санхүүгийн зах зээл дээр хүүхдүүдийн сургалтын чанарт яаж нөлөөлөөд байгаа юм бэ, хөрөнгийн зах зээлд орж байгаа өөрчлөлт нь нийгэмд ямар ашиг тустай юм бэ гэдгийг үнэлж гаргадаг байна. Үүнтэй холбоотой санхүүгийн мэдээллээ эцсийн бүлэгтээ төсөвтэйгөө холбож өгдөг гэсэн үг. Энэ утгаараа тус яам Сангийн яамтайгаа их ойрхон ажилладаг байна. Санхүүгийн мэдээллийн хувьд зайлшгүй ашиглах ёстой тэр нөлөөллийн үнэлгээг хийхдээ гарцаа яаж тодорхойлох юм, үр дүнгээ яаж тооцох вэ, тэр арга хэмжээ нь ямар үзүүлэлтүүдээр томъёологдож байгаа юм гэдгийг харж боловсруулдаг байна. Төслийн хүлээгдэж буй үр дүн нь мөн үү, хэрэв тэр үр дүн нь мөн бол бодлогын чанараар нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлж байна вэ гэдгийг үзүүлэлтээрээ дэмжинэ гэсэн үг байна.

Нөлөөллийн үнэлгээний тухайд улс орнуудын хувьд ялгаа бас байна. Зарим оронд нөлөөллийн үнэлгээг боловсруулах явцад нь гаргаад ирдэг, нөлөөллийн үнэлгээг жишээлбэл, Европын Холбоонд, Европ, Америкт эртний үе шат дээр нь нөлөөллийн үнэлгээнийхээ дүгнэлтийг гаргадаг.

Ямар нэгэн зүйлийг өөрчлөх гэж байгаа бол тэр өөрчлөлтийн арга хэрэгслүүд, бодлогын чанартай саналуудаа энэ процессын хамгийн эртний үе шат дээр нь үнэлдэг. Австрид бол харин хамгийн сүүлд процессынхоо эцэст нь нөлөөллийн үнэлгээг хийдэг байна. Жишээлбэл шинэ хууль нэвтэрлээ, шинэ журам нэвтэрлээ. Яамдын түвшинд хэлэлцэнэ, гол оролцогчдын саналыг тусгана, ямар проблем байна вэ гэдгээ томъёолно. Тэгээд юу хийх ёстой юм бэ гэдгийг томъёолсны дараа хуулийнхаа төслийг боловсруулж эхэлдэг. Ингэсний дараа тэр хуулийн нөлөөллийн үнэлгээг хийнэ гэсэн үг. Тэгэхээр орон оронд өөр өөр системтэй, зарчимтай байна. Гэхдээ гол санаа нь бол тэр хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх гэж байгаа аливаа нэгэн бодлогын чанартай арга хэмжээний чинь нөлөөлөл нь юу байх вэ гэдгийг үнэлэхэд оршиж байна.

Нөлөөллийн үнэлгээний хувьд ЭЗХАХБ-ын орнуудын дотор Австри бараг бүх үйл явцын дунд нь хийдэг орны тоонд ордог байна. Австри бол бүр төгсгөлд нь гэхээс илүү үйл явцын үр дунд нь нөлөөллийн үнэлгээг хийж байна.

Зохицуулалтын бодлогын бусад инструментыг, оролцогч талуудын оролцоо гэх зэргийг аваад үзэхэд зураглал өөр харагдаж болзошгүй. Засгийн газрын түвшинд оролцогч талуудаа байнга бодлого боловсруулах, бодлогоо үнэлэхэд оролцуулдаг, бүгдийнх нь оролцоог хангадаг. Худалдааны танхим, хувийн хэвшил, салбарын төлөөлөгч, үйлдвэрчний эвлэл оролцож байгаа. Гэхдээ бол яг эхнээс нь авахуулаад олон нийтийг татан оролцуулж, процесст оролцож байна уу гэхээр үгүй байна. ЭЗХАХБ-ын гишүүн зарим орнуудад зохицуулах орчны үнэлгээг бол хамгийн анхнаас авхауулаад олон нийттэй хамтарч хийдэг.

Гуравдугаарт зохицуулалтын арга хэрэгслүүд нь аливаа нэгэн үйл ажиллагаа явуулсны дараа нь үнэлгээ хийдэг, дүгнэлт гаргадаг учраас оролцоог бүрэн дүүрэн хангаж байна уу гэхээр дунд хавьцаа нь явдаг юм уу даа гэж ойлгохоор байна. Австрид аливаа нэгэн чухал үйл ажиллагаа явж байгаа, явуулж байгаа бол эхлээд эхний үнэлгээ хийгээд, 5 жилийн дараа тэр авсан арга хэмжээ нь хүлээсэн үр дүнгээ өгөхгүй бол тэр арга хэмжээний дараах үнэлэлт, дүгнэлт хийх зарчимтай байна.

Нөлөөллийн үнэлгээ гэж юу юм бэ, үндсэндээ бусад орнуудын туршлагаас харахад гол санаа нь Австрид үр дүнд чиглэсэн нөлөөллийн үнэлгээг хийж байна. Аливаа асуудлын нарийвчилсан анализыг хийж байна, яагаад хуулийг өөрчлөх ёстой юм бэ? Үүн дээр дорвитой анализ хийсэн гэсэн үг л дээ. Одоо үйлчилж байгаа хуульд ямар проблем байгаа юм гэдгийг үнэлэхээс эхэлнэ. Энэхүү баримт бичгийг, энэ хуулийн үндэслэлийг боловсруулж байгаа төрийн албан хаагчид үндэслэлээ сайн гаргахгүй тохиолдлууд байдаг. Тэр асуудал нь юунд оршиж байгаа, асуудал хэр ноцтой юм бэ, хэн үүнд хамааралтай байгаа юм бэ, ямар байгууллагууд энэ асуудлыг шийдвэл зохилтой юм гэх зэргээр бүгдээр нь судалгаа хийх, дүн шинжилгээ хийх ёстой байна.

Австрийн ихэнх хууль нь Европын Холбооны удирдамж зэргийг заавал хэрэгжүүлэх ёстой. Тус яамнаас Европын Холбооны шаардлагад нийцүүлж аливаа хууль тогтоомжоо боловсруулах үүднээс өөрсдийн үнэлгээ хийж, дүгнэлтээ гаргаж байна гэсэн үг. Европын Холбооны директив удирдамжид аливаа нэгэн том жижиг асуудлыг заавал тунгааж нягталж байх ёстой гэсэн зарчим тавьдаг байна. Хүсэлтийг Европын Холбооныхон маш нягт нарийн хянадаг. Тийм учраас тус яамны зүгээс санал боловсруулж байгаа хүмүүстээ асуудлаа маш сайн тунгааж, тусгаж бай. Үндэслэлээ маш бодитой гаргаж ирж бай гэсэн гол үндсэн шаардлагаа тавьдаг.

Хэрэв анхнаасаа асуудлаа зөв томъёолох юм бол нөлөөллийн үнэлгээ хийхэд хялбар болдог. Тухайн проблемын цар хүрээ, проблемын ноцтой байдлыг сайтар харж байх юм бол үнэлгээ хийх, засан залруулахад амар. Тухайн проблемын анализыг хийсний дараа тэр асуудлын мэдэгдлийг хийнэ. Өөрөөр хэлбэл нийгмийн хувьд юуг өөрчлөх гэж байгаа юм, юуг зориод, зорилт маань юу байна гэдгээ томъёолно. Тус яамны зорилго бол тодорхой хуулийг нэвтрүүлж хэрэгжүүлэх гээд байна, гэхдээ тэр хуулийн дагуу юу сайжрах юм. Замын аюулгүй байдал сайжрах уу, эсхүл хөдөлмөрийн зах зээлийн оролцооны түвшин нэмэгдэх гээд байна уу, эсхүл тодорхой насны бүлгийн ажил эрхлэлт сайжрах гээд байна уу гэх зэргийг маш нарийн томъёолдог байна. Зориод байгаа нийгмийн бүлэг нь хэн юм бэ, асуудлаа томъёолчихлоо, зорилтоо томъёолчихлоо өөрчлөх арга хэмжээ, алхмуудаа томъёолоод дараа нь гарцаа томъёолдог байна.

Гарц, үр дүн нь шинэ хууль тогтоомж байж болзошгүй, эсхүл мэдлэг дээшлүүлэх хөтөлбөр байж болно. Мөн аливаа нэгэн хуулийн хэрэгжилтийг хангах тодорхой зорилтот арга хэмжээнүүд ч байж болно.

Дөрөвдүгээрт, нөлөөллийг их гярхай харах хэрэгтэй. Нөлөөлөл гэдэг чинь чухам юу юм бэ гэхээр тэр хуулийнхаа төслийг аваад үзье, журмынхаа төслийг хараад яг ямар бодлогын талбарыг энд хөндөөд байгаа юм бэ, энэ хууль журамд. Жишээлбэл хурдны зам барьж байна гэж бодъё. Тэгэхээр гарц нь бүс нутгийн тээврийн нэвтрэх хүчин чадавхыг нэмэгдүүлэх байж болно. Нөлөөлөл чинь байгаль орчинтой холбоотой байж болно. Эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл байж болно, эдийн засагт сөргөөр болон эергээр нөлөөлж болно. Нөлөөлөл нь гарах зардлаас илүү цар хүрээтэй байх ёстой. Тэр өөрчлөлтийг авчирснаар

бусад хэмжээс талбаруудад хэрхэн нөлөөлөөд байна вэ гэдгээ томъёолно. Энэ нөлөөллийг бас үнэлээд дүгнэлт гаргах ёстой байна.

Тав дахь алхам дотоод үнэлэлт, дүгнэлт гаргахад төлөвлөгөө төлөвлөх ёстой. Аливаа нэгэн арга хэмжээ авч хууль нэвтэрсний дараагаар үнэлэлт, дүгнэлт хийх ёстой. Эцсийн үр дүнгээ яаж үнэлж байна, ямар тоон мэдээллийг цуглуулж үнэлгээ хийх ёстой юм бэ, хэн үүнийг цуглуулж үнэлгээ хийх ёстой юм бэ. Үндсэндээ 5 жилийн дараа тухайн салбарын яам дээрээ очоод нөгөө арга хэмжээ, гарц чинь ямар нөлөөлөл үзүүлсэн юм бэ гэж асууна. Гэтэл тэр гарцаа үнэлэх ямар нэгэн тоон мэдээлэл, өгөгдөл байхгүй гэж хэлэх эрхгүй. Тоон мэдээллээ найдвартай цуглуулж, хуримтлуулж хадгална гэдэг бол маш их чухал асуудал.

Австрид нөлөөллийн тухай олон хэмжүүрүүд байдаг хуульдаа заагаад өгсөн. Эдгээр хэмжүүрийг заавал анхааралдаа байлгаж байх ёстой. Жишээлбэл, Тээврийн яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого нь эдийн засагт нөлөөлж байна, Нийгмийн хамгааллын яамны бодлого нь эдийн засаг болон хүүхэд, залуучуудын мөн эмэгтэйчүүдийн эрх тэгш байдалд нөлөөлнө. Тээврийн салбарын төрийн албан хаагч, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрийн чиглэлээр ажиллаж байж болно. Өөрсдийн хариуцаж байгаа талбар, салбар хайрцагсаа хальж сэтгэх хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл, зөвхөн тээврийн салбарт яаж нөлөөллөө үзүүлж байна гэдгийг харахын зэрэгцээгээр эргээд энэ тээврийн салбарын энэ гарц нь нийгмийн салбартаа ямар нөлөөллийг бий болгоод байна гэдгийг харах нь чухал.

Жишээ дурдъя. Энэ нөлөөллийн хэмжүүрүүдийг яаж практик дээр хардаг вэ. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлын хэмжүүр байна гэж бодъё. Хуульд заасан тэр хэмжүүрүүд нь ерөнхий байдаг. Дэд хэмжүүрийг гаргаж ирнэ гэсэн үг. Жишээлбэл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал нь хэд хэдэн дэд хэмжүүрээр хэмжигдэнэ. Үндэсний хуулийн этгээдийн хийж байгаа төлбөр, ажил эрхлэлт, орлого, боловсрол, цалингүй ажил, улсын орлого, эрүүл мэнд, хүүхдийн цэцэрлэгийн хөтөлбөр, цэцэрлэгт хамрагдалт мөн цэцэрлэгийн санхүүжилтийн хөтөлбөр гэх зэрэг хэмжүүрээр үнэлнэ гэсэн үг. Дэд хэмжүүрийн тухайд, бүгдэд зарим босго тогтоож өгдөг. Гаргаж байгаа санал энэ дэд хэмжүүрүүдэд нөлөөлж байна уу, үгүй юу. Тэр босгыг даваад байна уу, үгүй юу гэдгийг заавал харж байх ёстой. Настай хүмүүсийн асуудлыг шийдвэрлэж байгаа хууль нэвтрүүлж байна гэж бодъё. Тэр настайчуудыг гэр бүлийн гишүүд нь асардаг шүү дээ. Гэтэл энэ нөхцөл байдал цалингүй ажил эрхлэлтэд яаж нөлөөлөөд байна вэ гэдгийг тооцоолох ёстой. Энд 10 мянгаас дээш хүн ийм цалингүй энэхүү төрлийн ажил эрхлээд байгаа бол маш нарийвчилсан эдийн засгийн нөлөөллийн судалгаа хийх шаардлагатай болчихно. Энэхүү арга хэмжээнээс нөлөөлөл гарч байна уу гэхээр тиймээ гарч байна, ямар төрлийн нөлөөлөл гарч байна. Энэ бодлого хөндөж байгаа, амьдралыг нь хөндөж байгаа тэр этгээдэд энэ асуултыг тавьж хариултыг нь заавал авч дараагийн бодлогодоо тусгах нь зүйтэй юм.

Процессын тухай эргээд очиход, нөлөөллийн үнэлгээг олон зүйлд, шинэ хууль тогтоомжид хийж байна, мөн санхүүжилтийн хөтөлбөр, ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаанд нөлөөллийн үнэлгээг хийж байна. Шинэ хуулийн нөлөөллийн үнэлгээний цар хүрээ нь гол асуудлын цар хүрээнээс их хамаардаг. Шинэ хууль тогтоомжоо харах юм бол шууд парламентаараа мэдээллээ солилцдог бол хүүхдийн цэцэрлэг болоод замын аюулгүй байдал гэдэг нь бас бусад яамтай харьцаж байгаа учраас цар хүрээ нь өөр байдаг байна. Шинэ хууль тогтоомжийн саналыг оруулж ирж байгаа, шийдвэр гаргаж байгаа гол яам нь тэр зорилтуудаа тодорхойлоод, үзүүлэлтүүдээ тодорхойлоод, хүлээгдэж байгаа гарцаа тодорхойлоод энэ нөлөөллийн үнэлгээг хийдэг байна.

Энэ үе шатанд нөлөөллийн үнэлгээг хийж байгаа яам нь бусад салбарын яамдаас туслалцаа авч болно. Жишээлбэл Тээврийн яамны оруулж ирж байгаа санал нь байгаль орчинд нөлөөлөхөөр бол Байгаль орчны яамнаас нөлөөллийн үнэлгээний үр дүнтэй холбоотой саналыг нь авах ёстой байна. Заримдаа өөр яамнаас саналыг нь авах амаргүй байдаг. Учир нь зарим салбарын яамд өөр яамны боловсруулж байгаа хуулийн төсөл дээр суурь мэдээллээ өгөх төдийлөн сонирхолгүй байдаг. Тээврийн яам юу гэж байгаль орчны яамнаас хамаарч байдаг юм гэсэн хандлага гардаг. Тийм учраас танай бодлого бусад салбарын бодлогыг хөндөөд байгаа бол зайлшгүй ийм хамтын яриа хэлэлцээрийн үндсэн дээр эцсийн концепцоор шийдэгдэх ёстой гэдгийг байнга тайлбарлаж тэр чиглэлээр ажиллаж ирсэн байна. Энд салбар хоорондын уялдаа холбоо маш чухал байгаа нь

харагдаж байна. Бусад яамнаас дэмжлэг, туслалцаа хүсэхийн оронд хамтарсан нөлөөллийн үнэлгээ хийх нь илүү үр бүтээлч хандлага болох нь нотлогдсон юм. Яамдын хооронд ялгаа байдаг, бүтцийн ялгаа байж болно, бодлогын ялгаа байж болно. Нэг салбарынхан нөгөө салбарынхантайгаа хууль тогтоомж боловсруулахад хамтарч ажиллах нь маш ховор юм шиг байна. Аливаа нэг салбарын бодлого дан ганцаараа оршдоггүй, бусад салбараас ч гэсэн хамааралтай байдаг учраас үүнийг, нэн ялангуяа байгаль орчны хамгаалалт, байгаль орчинтой холбоотой, нийгмийн нөлөөлөлтэй холбоотой асуудлыг зайлшгүй тухайн хариуцаж байгаа яамтай нь хамтарч үнэлгээг нь хийх шаардлагатай болдог байна.

Төмөр замыг хариуцдаг алба нь бусадтай ажиллах дургүй байдаг. Учир нь төмөр замаа өмчилчихсэн байдаг юм шиг байгаа юм тэр яам нь. Тэгээд төмөр замын өөрсдийн мэдлийн хүрээнд хэнийг ч оруулахгүй гэсэн тийм сэтгэхүй байх гээд байдаг. Гэтэл тэр нөлөөллийн үнэлгээг хамтарч хийх тэр журам гаргачих юм бол хүссэн хүсээгүй хамтрах хэрэгтэй болдог.

Тус яамнаас чанарын баталгаагүй хийж байгаа бодлогын чанартай зөвлөгөөнүүдэд дэмжлэг үзүүлдэг. Салбар яам тус яаманд хандаж, өөрсдийнхөө үнэлгээний тайланг ирүүлж, яамны саналыг авдаг. УСТАСЯ та нар өөрсдийнхөө мөнгөөр шал өөр зүйл хийх ёстой гэж хэзээ ч хэлдэггүй, танай санхүүжилт чинь энэ юм бол та нар энэ проблемоо ийм өнцгөөс нь харвал яасан юм бэ, мөн түүнчлэн ийм үзүүлэлтүүд илүү зохистой юм биш үү, энэ тохиолдолд та бүхний санхүүжилт үр дүнгээ өгөх юм гэсэн саналыг яам өгдөг байна. Тухайн зөвлөгөөг яамд аливаа нэгэн төсөл хэрэгжүүлж бодлого хэрэгжүүлэхээс өмнө ирж саналыг авбал илүү зохилтой байгаа юм. Олон нийтэд мэдээллээ хүргүүлж, олон нийтийн сонсголыг явуулах үедээ тус яамтай хамтрах тохиолдлууд багагүй гардаг байна.

Олон нийт хуулийн төсөлтэй танилцах үед оролцогч талууд мэдээллээ бас олж авах нөхцөл байдал үүсдэг байна. Заримдаа хожимдсон байдаг. Учир нь хуулийн төслийн гол рамыг зангидсан байхад бусад оролцогчийг оруулж ирнэ гэдэг оройтсон хэрэг. Иймд нөлөөллийн үнэлгээгээ эерэг гаргахыг зорьж байгаа бол процессын эхний үе шат дээр хамтарч ажиллах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл цаг хугацаа хэмнэнэ, хөрөнгө хэмнэнэ. Түүнчлэн бусдын оролцоог илүүтэй татах боломжийг олгодог байна.

Яамд өөрсдийн дотоодын нөлөөллийн үнэлгээ хийхэд УСТАСЯ өөрсдийн дүгнэлтийг гаргаж өгдөг. Иж бүрэн байх ёстой, ойлгомжтой байх ёстой, уялдаа холбоотой байх ёстой гэсэн шаардлагууд тавьдаг, саналаа хүргүүлдэг. Яамны саналыг үндэслээд зөвлөмжийг нэг бол биелүүлэх ёстой, нөлөөллийн үнэлгээгээ саналын дагуу өөрчлөх юм уу, зарим асуудлыг шинээр үнэлэх шаардлага тавигддаг.

Хэрэв саналыг хүлээж авах боломжгүй бол өөрсдийн үндэслэлийг гаргаж ирэх ёстой. Биелүүлэх боломжгүй, саналыг хүлээж авч чадахгүй гэдэг үндэслэлээ мөн гаргах учиртай байна. Цаг хугацааны учир шалтгаан байж болзошгүй, мөн түүнчлэн үзүүлэлтүүд нь ойлгомжгүй томъёологдсон байж болно.

Чанарын баталгаа олгох ажил хэзээ амжилттай болдог гэхээр аливаа асуудал нэг шөнийн дотор шийдэгддэггүй гэдэг үүднээс санаж байх ёстой. Нөлөөллийн үнэлгээг хоорондоо ярилцаж, харилцан ойлголцож байж хийх ёстой гэдгийг ойлгох ёстой. 2013 онтой харьцуулж нөлөөллийн үнэлгээний чанарыг аваад үзэх юм бол өнөөдрийнхөөс тэс ондоо чанартай байсан. Өнөөдөр шалгаж байгаа, үнэлгээ өгч байгаа нөлөөллийн үнэлгээнүүдийн чанар хамаагүй сайжирсан. Нөлөөллийн үнэлгээнд, тайланд тусгасан зүйл нь ойлгомжгүй байсан ч гэсэн процессыг зогсоох эрхгүй. Ямартай ч гэсэн тэр салбарын яамнаас орж ирж байгаа асуудлыг парламентад уламжлах үүрэгтэй.

Аливаа хуулийг парламентад оруулахдаа заавал энэ хуулийн нөлөөллийн үнэлгээг хийсэн дүгнэлттэй хамт оруулдаг. Тийм учраас салбарын яамдын хувьд тухайн яамнаас гаргах чанарын баталгаа маш их ач холбогдолтой болдог байна. Энэ утгаараа тус яам чанарт нөлөөлж байна уу гэхээр нөлөөлж байна. Эдгээр нөлөөлөл тийм амар процесс биш, цаг хугацаа шаарддаг процесс.

Австрийн парламент өөрөө шинэ хуулийг санаачлах эрхтэй. Сайд нар хууль оруулж ирээд парламентад хүргүүлдэг. Хоёрдугаарт, парламентын гишүүд өөрсдөө хууль

санаачлах эрхтэй байдаг. Парламентын гишүүд хууль санаачилж байгаа нөхцөлд нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй. Сайд нар хууль оруулж байгаа бол заавал нөлөөллийн үнэлгээ хийнэ. Парламентын гишүүн хууль санаачлах, эсвэл нэмэлт, өөрчлөлтийн санал оруулж байгаа бол байнгын хороодоор оруулаад батлуулдаг. Энэ тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй.

Дээр дурдсанчлан 5 жилийн хугацаанд буюу 5 жил тутамд заавал үйл ажиллагааны дараах нөлөөллийн үнэлгээг хийх журамтай. Нөлөөллийн үнэлгээг хийгээд, тайлан илтгэлээ боловсруулаад, парламентад хүргэдэг байна.

Яам болгон 5 жил хүртэлх хугацаанд нөлөөллийн үнэлгээ хийх ёстой. Шинэ технологи нэвтрэх юм бол тэр дэвшилтэт технологиор бүх үнэлгээг хийдэг болж болзошгүй, зүйрлэх юм бол сургуулийн сургалтын хөтөлбөрөө өөрчилж гэж бодъё. Австрид бүх дүрэм журмыг заавал бичсэн, томъёолсон байх ёстой. Жишээлбэл ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт ороход хүртэл хууль гаргах ёстой. Гол, нуур, усан тээврийн дүрэм журамд өөрчлөлт оруулахад ч гэсэн заавал түүнийг хуульчилж байх ёстой байна.

Зарим бодлогын хэрэгжилт удаан байдаг, үр дүнгээ өгтөл нэлээд удаан хэрэгжиж байдаг. Зарим бодлого тэр дороо хэрэгждэг, үр дүнгээ өгчихдөг. 1, 2, 3 жилийн дараа энэ бодлого болсон байна уу, зөв байна уу, буруу байна уу гэдэг нь харагдчихдаг. Замын дүрмийг өөрчлөх, дугуй унадаг хүмүүс малгай өмсөх ёстой гэсэн дүрэм, журам нэвтрэх юм бол хүмүүс маргаашаас эхлээд хэрэгжүүлж эхэлнэ.

Яагаад 5 жил вэ гэхээр зарим бодлого хэрэгжихэд цаг хугацаа шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг нэгдүгээрт. Өөрөөр хэлбэл, тухайн бодлогыг нэвтрүүлсний улс төрийн хариуцлагыг хэн нэгэн хүлээх ёстой, тийм учраас 5-аас доош жилийг тусгаж өгч байгаа юм. 15 жил гээд тусгах юм бол 15 жилд Засгийн газар 3 солигдоно гэсэн үг. Аль Засгийн газар хариуцлагаа хүлээх вэ гэдгийг шийдэх болно. 5-аас бага жил гэдэг нь тухайн эрх барьж байгаа Засгийн газар өөрийн хариуцлагаа хүлээх хангалттай хугацаа юм гэж үздэг байна.

Холбогдох яамд өөрсдөө дотооддоо нөлөөллийн үнэлгээ хийх ёстой, өөрсдийн дотоодын нөлөөллийн үнэлгээ хийнэ гэдэг тухайн салбарын хүмүүс өөрсдөө ажлаа мэдэж байгаа. Түүнийгээ бусдаас илүү хийнэ гэж үздэг хандлагатай холбоотой байна. Өөрийн бодлогоо үнэлнэ гэдэг амаргүй, нэг талыг баримталсан дүгнэлт гарч болзошгүй. Нөгөө талаас салбарын яамд өөрсдөө өөрийнхөө ажилд шүүмжлэлтэй хандах хөшүүрэг болж өгдөг.

Хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд өртөг зардалтай болчихдог. Хүмүүс хөлсөлж авна, цаг хугацаа илүү ордог. Тиймээс яамдыг хараат бус үнэлэлт, дүгнэлт хийлгэхийг хэдийгээр дэмждэг ч гэсэн юуны өмнө өөрсдийн дотоодын нөлөөллийн үнэлгээгээ анхлан хийгээд өөрсдийн дүгнэлтээ гаргаж ирэх нь зүйтэй гэдэг бодлогыг УСТАСЯ дэмждэг байна.

Зарим бодлогын чанартай асуудлыг гадаадын хөндлөнгийн үнэлгээний багуудыг авч ажиллуулдаг байна. Шинжлэх ухааны яам, шинжлэх ухаантай холбоотой бодлого, технологи, инновацтай холбоотой бодлогын хэрэгжилтийн нөлөөллийн үнэлгээг их, дээд сургууль бусад хөндлөнгийн экспертүүдийг авч ажиллуулж үнэлгээ хийлгэдэг байна. Зарим санхүүжилтийн программ хэрэгжилтийн талаар гэх зэрэг асуудлаар ол яамд өөрсдөө дотоодын нөлөөллийн үнэлгээг хийх нь илүү дээр байдаг юм.

Үүнийг гаднын экспертүүдээр, үүнийг дотоодынхоор хийлгэнэ гэдэг зааг байдаггүй. Хөдөө аж ахуйн яам хоёр өөр фермерийн төслийн үнэлгээ хийх болсон. Энэ тохиолдолд шинээр нэвтэрсэн бодлого тэр фермерт хэрхэн нөлөөлж байна, ямар гарцтай байна гэдгийг дүгнэх хэрэгтэй байсан. Тэр фермерийг дэмжих төсөл маш их өртөгтэй төсөл байсан, их хөрөнгө оруулсан. Эхний төсөл дээр бүх санхүүжилтээ зарцуулсан байсан. Хоёр дахь фермерийн төсөл дээр мөнгөө бүгдийг нь зарцуулж чадаагүй байсан.

Хоёр дахь төслийнхөн юу гэж хэлсэн гэхээр бид нар мөнгө хэмнэлээ, энэ амжилттай байгаа биз дээ, фермерүүдэд мөнгө хэрэггүй болсон гэсэн асуудал ярьсан. Тэгэхээр энэ бол буруу юм. Мөнгө хэмнээд байвал сайн, мөнгө хэтрүүлээд байвал муу гэсэн үнэлгээ

байхгүй. Өөрөөр хэлбэл хүлээгдэж байсан зорилтоо гүйцэлдүүлж чадаж уу гэдгийг илүүтэй анхаарах ёстой юм. Тэрэнд дотоодын нөлөөллийн үнэлгээ чиглэх ёстой юм.

Яамд үр дүнд чиглэсэн үнэлгээ хийж чадаж байна уу, үгүй юу. Үр дүнгээ томъёолсны дагуу хэрэгжүүлж чадаж байна уу, үгүй юу гэдгийг харах ёстой. Нөлөөлөл ярихад ерөнхий чанарын дэвшил болоод байгаль орчны нөлөөлөл гэх зэрэг олон хэмжүүрт асуудлууд ярих ёстой. Иж бүрнээр нь нөлөөллийн үнэлгээ хийхэд амаргүй. Яагаад гэхээр чанартай холбоотой маш их тоон өгөгдлүүд шаардлагатай болдог. Нөлөөллийн үнэлгээг бүх талбарт хийдэг гэж хэлж байсан. Ханган нийлүүлэлт, санхүүжилтийн хөтөлбөрүүд, сургалтын хөтөлбөр гэх зэрэг үнэлгээнүүдийг их хийж байгаа.

УСТАСЯ цахимаар олон мэдээллийн баазыг цуглуулаад нөлөөллийн үнэлгээ хийх загвартай болсон байна. Хүмүүс үндсэндээ түүнийг ашиглаад өөрсдийнхөө тоонуудыг оруулж нөлөөллийн үнэлгээг гаргаж болдог байна. Яамд өөрсдийн өгөгдлөө дата баазад оруулаад нөлөөллийн үнэлгээгээ хийдэг. Ингэж хийгдсэн нөлөөллийн үнэлгээнд УСТАСЯ чанарын баталгаа гаргаж өгдөг. Тэр нөлөөллийн үнэлгээнд үндэслээд дүгнэлтийн тайлан гаргадаг. Үүнийг олон нийтэд хүртээмжтэй байлгах чиглэлээр тус яам ажилладаг. Дүгнэлтийн тайлангаа төсвийн дэд хороонд хүргүүлдэг байна. Парламентын Төсвийн дэд хороо үр дүнгийн хэлэлцүүлгийг өрнүүлдэг байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Австри Улсад төсвийн төлөвлөлтийг зөвхөн тухайн төсвийн жилийн хүрээнд хийдэг байсан бол төсвийн бодлогын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, 4 жилээр төлөвлөдөг болсноор дор дурдсан хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэж чаджээ:

- Урт хугацааны хөгжлийн бодлогогүй, урт хугацаанд төсвийн удирдлага, төлөвлөлтийг урьдчилан харах хууль эрх зүйн зохицуулалтгүй
- Төсвийн удирдлагатай холбоотой мэдээлэл дутмаг
- Жижиг хэмжээтэй, уян хатан бус төсвийн бүтэцтэй байсан бөгөөд төсвийн ил тод байдал нь учир дутагдалтай
- Зөвхөн орцод анхаарлаа хандуулж байсан: Хэн хэдийг авах вэ гэдэг чухал байсан.
- Төсвийн төлөвлөлтийг том зургаар хардаггүй: Төсвөөр бид юунд хүрэхийг хүсч байна вэ?

Урт хугацааны төлөвлөгөө гэсэн ойлголт байгаагүй. Мөн менежерүүдтэй холбоотой мэдээлэл байсангүй. Уян хатан биш төсвийн бүтэцтэй байж, институтийн хооронд төсвөө шилжүүлэх асуудал байдаггүй, орцын асуудал хамгийн хурц асуудал байсан байна. Яамдад хэдий хэмжээний орцыг өгч байна гэдэг гол асуудал байжээ. Нийгмийн чанартай асуудал гарвал санхүүжилт шууд хийдэг, санхүүжилт нь үр дүнгээ өгөхгүй байсан ч нэмж санхүүжилт өгдөг байсан байна.

Төсвийн төсөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой эдгээр олон хүндрэлийг 2009, 2013 онуудад хэрэгжүүлсэн төсвийн шинэчлэлийн бодлогын хүрээнд үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагын системг нэвтрүүлснээр амжилттай шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, орцод биш гарцад суурилсан хандлагыг илүүтэй үзэх болсон.

Гүйцэтгэлийн удирдлагын алба 2 арга хэрэгслийг ашигласнаар энэ үр дүнд хүрчээ. Нэгдүгээрт, төсөвтэй нягт холбоотой үр дүнд чиглэсэн хандлагыг ашигласан. Хоёрдугаарт, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлого, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гарцын нөлөөллийн үнэлгээг хийж, чанарын баталгааг олгодог болсон байна.

Аливаа бодлогын арга хэмжээний нөлөөллийн үнэлгээ 5 жилийн хугацаанд заавал хийдэг болж, Урлаг, соёл, төрийн алба болон спортын яам нь цахимаар олон мэдээллийн баазыг цуглуулж нөлөөллийн үнэлгээ хийх загвартай болсон байна. Энэ цахим системийг салбарын яамдын албан хаагчид ашиглаад өөрсдийнхөө тоо, мэдээллийг оруулж нөлөөллийн үнэлгээг хялбар гаргадаг болсон байна.

Яамд үр дүнд чиглэсэн үнэлгээ хийж чадаж байна уу, үгүй юу. Үр дүндээ томъёолсны дагуу хүрч чадаж байна уу, үгүй юу гэдгийг харах ёстой юм байна. Яамд өөрсдийн өгөгдлөө дата баазад оруулан хийсэн нөлөөллийн үнэлгээнд УСТАСЯ чанарын баталгаа гаргадаг.

Энэхүү нөлөөллийн үнэлгээнд үндэслэн дүгнэлтийн тайлан гаргадаг байна. Мөн энэхүү тайлангаа олон нийтэд хүртээмжтэй байлгах чиглэлээр ажилладаг. Дүгнэлтийн тайлангаа төсвийн дэд хороонд хүргүүлдэг байна. Парламентын Төсвийн дэд хороо үр дүнгийн хэлэлцүүлгийг өрнүүлдэг байна.

Нэгтгэн дүгнэвэл дээр дурдсан эдгээр асуудлыг бид үйл ажиллагаандаа авч хэрэглэвэл зүйтэй гэсэн саналтай байна.

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС ТӨСӨВТ ХЯНАЛТ ТАВИХ, ТӨСӨВ БАТЛАХ ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОЖ БУЙ АРГА, ХЭЛБЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕХАНИЗМ

ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ

Европын холбооноос гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2013 онд Австри улсын төсвийн зөвлөлийг байгуулсан. Төсвийн зөвлөл нь Австри улсын төрийн байгууллагуудын төсвийн сахилга батыг хянах үүрэгтэй бие даасан байгууллага юм. Зөвлөлийн 15 гишүүн нь бие даан ажиллах үүрэгтэй төрийн санхүүгийн мэргэжилтнүүд юм. Үүнд: Холбооны засгийн газраас 6, эдийн засгийн танхимаас 3, холбооны хөдөлмөрийн танхимаас 3, мужуудын засаг дарга нарын бага хурлаас 1, Хотын захиргааны холбооноос 1, Хот, сууринуудын холбооноос 1 гишүүнийг томилдог. Мөн тус байгууллагуудаас гишүүдийг хуралдаа оролцох боломжгүй үед орлох 15 гишүүдийг мөн давхар томилдог. Түүнчлэн Төсвийн зөвлөлийн хурал бүрд Үндэсний банкнаас 2, УИХ-ын Төсвийн албанаас 2 томилогдсон төлөөлөгч хуулийн дагуу зөвлөхөөр оролцох эрхтэй. Зөвлөлийн гишүүдийг 6 жилийн хугацаагаар томилдог бол 12 саналын эрхтэй, 3 нь саналын эрх байдаггүй. Ажлын албанд албаны дарга, ахлах эдийн засагч, эдийн засагч, судалгааны туслах гэсэн 7 хүн ажилладаг.

Төсвийн зөвлөлийн үүрэг

- Австрийн төсвийн байдлыг үнэлж, төсвийн таамаглалыг бэлтгэх
- Улсын өрийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийх
- Австри улсын төсвийн бодлогын тогтвортой байдал, үр дүнд дүн шинжилгээ хийх
- Дүн шинжилгээ, үр дүнгээ Австрийн парламентад жил бүр тайлагнах
- Австри улсын төсвийн бодлого, дунд хугацааны төсвийн төлөв байдлын талаар бичгээр зөвлөмж өгөх
- Австри улс үндэсний болон ЕХ-ны төсвийн дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг тогтмол хянах тавих
- Олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, зохион байгуулах
- Макро эдийн засаг, төсвийн төсөөллийн чанарт тогтмол үнэлгээ хийх
- Үндэсний болон олон улсын хэмжээн дэх хурал, цуглаанд идэвхтэй оролцох

Тайлагнал

- Төсвийн зөвлөлөөс хавар болон намар 2 удаа гол шинжилгээг хийж нийтэлдэг. 6 дугаар сард: Австрийн засгийн газраас тогтвортой байдлын хөтөлбөр болон Дунд хугацааны зарлагын тооцоог өнгөрсөн жил, өнөө жил болон ирэх 4 жилээр тооцоолон Европын холбоонд хүргүүлдэг. Сангийн яамнаас хүргүүлсэн дээрх баримт бичгүүдэд төсвийн дүрэм журмуудыг баримталсан байгаа байдалд шинжилгээ хийж хянадаг. 12 дугаар сард: сангийн яамнаас хүргүүлсэн төсвийн төсөл болон дунд хугацааны зарлагын хүрээний мэдэгдэлд шинжилгээ хийж үр дүнг өөрийн вэбсайтад шууд нийтэлдэг. Үүний гол зорилго нь олон нийтэд мэдээллийг хүргэх явдал юм. Төсвийн төсөлд шинжилгээ хийхдээ өнгөрсөн жилийн төслийн гүйцэтгэлийг статистикийн газар, харин макро-эдийн засгийн төсөөллүүдийг судалгааны хүрээлэнгүүдээсээ авдаг.
- Мөн 2 жилийн өмнөөс 4, 10 дугаар саруудад богино хэмжээний тайлан, илтгэлүүдийг гаргаж нийтэлж байгаа. Үүнд: Сангийн яамнаас тогтвортой байдлын төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөөгөө яг гаргаснаас 1, 2 долоо хоногийн дараа тайлан илтгэл гаргадаг.

Таамаглал: Орлого, зарлагын 60 орчим зүйл ангиуд байдаг бөгөөд энэхүү зүйл анги тус бүрээр таамаглал хийдэг.

Шинэчлэлийн өмнөх бодлогоо өнөөгийн өөрчлөлттэй харьцуулан тооцооллыг хийдэг. Мөн макро эдийн засгийн үзүүлэлтүүд өөрчлөгдөж байгаа тохиолдолд тэрхүү өөрчлөлтийг мөн тусгадаг. Нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөн тохиолдолд экспертийн зөвлөмжийг аваад ерөнхий чиг баримжаагаар тооцоолдог.

Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа маш чухал учир аливаа таамаглалыг олон нийтэд ойлгомжтой байдлаар хийдэг. Сангийн яам болон судалгаа шинжилгээний байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Бусад байгууллагуудын төсвийн прогнозыг сайн ойлгох нь чухал юм. Учир нь таамаглалын зөрүү юунд байна вэ гэдгийг ойлгох нь тайлбар хийхэд амар байдаг.

Сорилтууд

- Мэдээллийн хүртээмж
- Бэлэн мөнгө болоод аккурэл сууриар илэрхийлэгдсэн мэдээллүүдийг нэгтгэх
- Цар, тахал, дайны тодорхой бус байдал, эрсдэлүүд
- Холбооны улсын төсөв бол маш том учир хэд хэдэн төрлөөр зардлыг бүтцийг илүү боловсронгуй болгох шаардлагатай байгаа. Жишээ нь: боловсрол, хүүхэд асрах, нийгмийн бусад салбаруудын бүтэц
- Зарлагын дүрэм болон орлогын дүрмүүдийг европын холбооны дүрмээс авч дотоодын хуульд суулгаж өгөхөд тэр бүр амархан байдаггүй

Санал: Бүгд Найрамдах Австри Улсын төсвийн зөвлөл нь 15 гишүүн, ажлын албаны 7 албан хаагчийн бүрэлдхүүнтэйгээр төсөв, төсвийн бодлого, төсвийн дүрэм, дунд хугацааны задлын хүрээ, улсын өр зэрэгт хараат бус дүн шинжилгээ хийн Парламент болон олон нийтэд мэдээллэх үүргийг гүйцэтгэж байна. Манай Улсын хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь 9 гишүүн, ажлын албаны 2 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд ТТБЗ-ийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх олон улсын зөвлөхөөр Паул Гарденар ажилласан бөгөөд түүний өгсөн зөвлөмжид ТТБЗ доод тал нь 5 үндсэн ажилтантай байж макро эдийн засаг, төсвийн төсөөлөл боловсруулах боломжтой талаарх дурдсан болно. Иймд зөвлөлийн ажлын албаны орон тоог нэмэгдүүлэн гишүүдийг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж УИХ-ын гишүүд болон олон нийтэд тогтмол мэдээлж байх нь чухал.

АВСТРИ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН АЛБА


Австрийн парламент

Австрийн Холбооны Үндсэн хуулиар хагас ерөнхийлөгчийн засаглалт бүхий парламентын тогтолцоотой. Парламент нь хоёр танхимтай бөгөөд нэг Үндэсний зөвлөл 183 гишүүнтэй бол нөгөө нь Холбооны зөвлөл 61 гишүүнтэй. Үндэсний тэнхим нь хууль боловсруулах, батлах, холбооны засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг бол Холбоо зөвлөл нь 9 мужийн эрх, ашиг, сонирхлыг хамгаалах болон төлөөлж байдаг танхим юм. Төсвийн асуудлыг үндэсний зөвлөл хариуцдаг бол холбооны зөвлөл энэ асуудалд оролцдоггүй.

Үндэсний Зөвлөлийн Төсвийн эрх мэдэл

- Сангийн сайд төсвийн төслийг боловсруулж, Үндэсний Зөвлөлд танилцуулдаг.
- Үндэсний зөвлөл Холбооны Дунд хугацааны зардлын хүрээний (ДХТЗХ) тухай хууль, Холбооны санхүүгийн тухай хуулийн төслийн гурван удаагийн хэлэлцүүлэг хийнэ.
- Үндэсний Зөвлөл нь төсвийн тухай болон (ДХТЗХ) -ын хуулийг батлах ёстой бөгөөд өөрчлөлт оруулж болно.
- Үндэсний Зөвлөл нь Холбооны Санхүүгийн тухай хуулиар онцгой нөхцөл байдалд тодорхой хэмжээний дотор батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлэх эрхийг Сангийн Яаманд олгож болно.
- Үндэсний Зөвлөл нь Төсвийн хорооноос Үндэсний зөвлөлийн төсвийн удирдлага/зохицуулалт, хяналтын чиг үүргийг дэмжсэн хэд хэдэн тайланг хүлээн авна.
- Үндэсний Зөвлөл нь хуулийн дагуу санхүүгийн тайланг батална.

Төсвийг хэлэлцэх, батлах – замын зураглал



Байнгын хорооны үйл ажиллагаа – Хуралдаан

- Тогтмол хурлаар (regular meeting) хэлэлцэх асуудлууд:
 - Төсвийн гүйцэтгэлийн тайлан (жишээ нь: төсвийн хяналт, төсвийн сарын гүйцэтгэл)
 - Урьд нь хийсэн нөлөөллийн үнэлгээний үр дүн, үнэлгээний талаарх мэдээлэл
 - Төсвийн хороонд хамаарах шинэ хууль тогтоомжууд
 - Европын Семестртэй (Европын төсвийн засаглалын шинэ хүрээ) холбоотой баримт бичгийн төсөл (жишээ нь Австрийн тогтвортой байдлын хөтөлбөр, Үндэсний шинэчлэлийн хөтөлбөр)
- Төсвийн хорооны хуралдаанаар Аудитын Газрын жилийн санхүүгийн болон аудитын тайланг хэлэлцдэг
- Парламентын Төсвийн Албаны дарга нь хуралдаануудад байнга оролцдог бөгөөд шинжээчийн хувьд зөвлөгөө өгч болдог.

Байнгын хорооны үйл ажиллагаа – Хяналт, шалгалт ба нэмэлт өөрчлөлтүүд

- Парламент дахь бүлгүүд төсвийн бүлэг тус бүртэй холбоотой бодлогын чиглэлээр мэргэшсэн гишүүдийг өөрсдийн байнгын хороог төлөөлүүлэн томилж болно.
- Парламент дахь бүлгүүдээс нэр дэвшүүлсэн мэргэжилтнүүдийн нээлттэй сонголыг Төсвийн хорооноос зохион байгуулдаг
- Парламентын Төсвийн Алба (РВО) нь төсвийг бүхэлд нь болон бүлэг тус бүрд дүн шинжилгээ хийж танилцуулна.
- Төсвийн Хороо нь дараагийн 5 өдрийн дотор Сангийн сайд болон холбогдох салбарын сайд нартай төсвийн бүлэг тус бүрээр (нээлттэй бус) ганцаарчилсан хэлэлцүүлэг хийнэ.
- Төсвийн хороо төсвийн тухай хуулийн төсөлд ямар нэгэн өөрчлөлт оруулж болно
- Парламент нь өөрчлөлт оруулах эрхтэй ч үндсэндээ багахан өөрчлөлт төсөвт оруулдаг.

Парламентын төсвийн алба

Засгийн газраас хараат бус, бие даасан шуурхай мэдлэг мэдээллээр Парламентыг хангах шаардлагын тухай болон парламентын зүгээс засгийн газартай харьцах байр суурийг бэхжүүлэх талаар гаргасан олон жилийн хүчин чармайлтын үр дүнд тус албыг Австрийн үндэсний ассамблейд төлөөлөлтэй бүх улс төрийн намуудын улс төрийн гэрээ/зөвшилцөл, Төсвийн хорооны мэдэгдлийг үндэслэн 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан.

Австрийн Парламентын Төсвийн Алба (РВО) нь тусгайлсан хуульгүйгээр дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- Хараат бусаар, бие даасан статустай ажиллана, мэргэжлийн өндөр ур чадвартай байх;
- Хийсэн дүн шинжилгээгээ бүх улс төрийн намуудад хүргүүлнэ;
- Ил тод байдлыг хангах, зөвлөмж, судалгааны үр дүнгээ парламентын сайтад нийтлэх;
- Төсвийн асуудлаар Парламент, тухайлбал Төсвийн Байнгын хороог дэмжиж ажиллах;
- Орон тоо: нийт 8 ажилтан (6 академик өндөр боловсролтой шинжээч, 2 туслах ажилтантай)

Үндсэн чиг үүрэг:

- Холбооны төсвийн тухай хуулийн дагуу Засгийн Газраас өргөн мэдүүлсэн төсвийн асуудлуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, дүн шинжилгээ хийх, богино хэмжээний судалгаа хийх зэргээр Төсвийн Хороонд дэмжлэг үзүүлэх (жишээлбэл, төсвийн хүрээ, төсвийн төсөл, тайлан, санхүүгийн тайлан боловсруулах гэх мэт);
- Төсвийн хорооны гишүүдийн хүсэлтээр товч мэдээлэл бэлтгэх;
- Шинээр гарах хууль, тогтоомжуудын нөлөөллийн үнэлгээ (impact assessment) хийх замаар Парламентын бусад хороодод дэмжлэг үзүүлэх;
- Төсвийн гүйцэтгэл болон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үр нөлөөтэй эрх тэгш байдлыг хангах (жендерийн төсөв) асуудлаар парламентад зөвлөгөө үзүүлэх;

Парламентад тулгарах сорилтууд

- Төсвийн шинэ хууль, дүрмийн дагуу ЗГ-т нэмэлт эрх олгосон тул төсвийн гүйцэтгэлд Парламентын зүгээс тавих хяналтыг чангатгах шаардлагатай байгаа;
- Европын төсвийн засаглалын шинэ хүрээ (Европын семестр) төсвийн үндэсний дэг журамд нөлөө үзүүлж, үндэсний төсвийн хүрээг хязгаарлах болсон;
- Ил тод, хариуцлагатай байдлыг дэмжинэ;
- Мэдээллийн үлэмж тэгш бус байдал байгааг үл харгалзан төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;
- Олон нийтийг төсвийн талаарх мэдээллээр хангах;

Төсвийн шинэ бүтэц

- Төсвийн шинэ хуулиар хуучин Парламентын төсвийн асуудлаарх эрхийг илүү нэгдсэн үзүүлэлтүүдэд төвлөрүүлсэн (1100 гаруй бие даасан төсвийн шугамын оронд 73 глобал төсөв).
- Төсвийн тодорхой чиглэлүүдийн жижиг хуваарилалтуудын талаарх өмнөх нарийвчилсан асуултуудын оронд илүү бодлого, стратегийн мэтгэлцээн өрнөх болсон.
- Төсвийн хуваарилалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл улс төрийн хэлэлцүүлэг хийхэд чухал шаардлагатай хэвээр байна.
- Дунд хугацааны зарлагын хүрээ (хавар) болон жил бүрийн төсвийн хуваарилалт (намар)-ын талаарх стратегийн асуудлуудыг тус тусад нь хэлэлцүүлэх болсон.

Хавсралт 5. Өдрийн сонинд өгсөн ярилцлага

Д.Даваасамбуу: НДШ-ийг буцааж олгох нь нийгмийн эмзэг хэсэгт очих мөнгөнөөс хумсалдаг, хавтгайрсан халамжийн шинж

УИХ-ын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуутай ярилцлаа.

- **2022 оны төсвийн тодотголын төслийг Засгийн газраас өргөн барилаа. Энэ талаар ярилцлагаа эхэлье. Төсвийн тодотголын төсөл Төсвийн тухай хуулиа барьж чадав уу?**

Засгийн газар 2022 оны Төсвийн хуулиар батлагдсан алдагдлын хэмжээнд тодотгол хийхээр УИХ-д хуулийн төсөл барьжээ. Орлого, зарлагыг хоёулангаас нь хассан хэрэг. Алдагдлыг нэмээд ч түүний санхүүжүүлэх эх үүсвэр гадаад дотоодоос олдох нь хязгаартай. Бас үнэтэй болох учраас төлөвлөгөөт алдагдлыг багасгах чиглэлээр Сангийн яам маань ажиллах байх гэж найдаж байна. Сангийн сайд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахаа саяхан болсон эдийн засгийн форумын үеэр мэдэгдсэнийг талархан хүлээн авч байгаа.

Манай улс дэлхий нийтийн жишгийн дагуу орлогоороо зарлага нөхдөг төсөвтэй болох, алдагдал гаргавал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтрүүлэхгүй байх. Засгийн газрын өрийг мөн ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх хуулийн хязгаарлалт, шалгуурыг 2010 онд хуульчлан тогтоосон. Гэвч тогтоосон хязгаарлалтыг зарим үед мөрдөхгүй явж ирснийг зогсоож, УИХ, Засгийн газраас эдгээрийг мөрдүүлэхэд нь санаа дохио өгөх, түмэн олон, хэвлэл мэдээллийнхэндээ үнэнийг хэлж дэмжлэг авч ажиллах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийг 2018 онд байгуулж, ажиллуулж байна.

Бид төсвийн алдагдал манайх шиг жижиг хөгжиж буй оны хувьд гадаад өрийг нэмэгдүүлж, эдийн засгийн хараат байдлыг алдагдуулах үр дагавартай гэдгийг сануулсаар байна. Манай зарим улстөрчид Япон, Хятад, АНУ зэрэг орнууд төсөв нь алдагдалтай, өр үүсгээд болоод байгаа тухай ярьж, ард иргэдийг тайвшруулахыг оролддог. Эдгээр болон эдгээртэй төсөөтэй өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн чадавхи асар их ээ.

- **Тодруулж хэлэхгүй юу?**

Жишээ нь, Японы эдийн засаг дахь хадгаламж, харилцах, сангууд зэрэг нийт мөнгө ДНБ-ээс гурав дахин, Хятадынх хоёр дахин их байхад Монголын нийт мөнгө ДНБ-ний 40 хувьд хүрэхтэй үгүйтэй байна. Японы Засгийн газар энэ их хуримтлагдсан мөнгөний нэлээд хэсгийг зээлдэн авч эргэлдүүлэх нь үндэснийх нь эрх ашигт нийцдэг байх аа. Хятад мөн адил.

Дэлхийн улс орнуудын, жишээ нь Хятадын 3.2, Японы 1.2 их наяд доллартай тэнцэх валютын нөөцийн ихэнхийг ам.доллар бүрдүүлж, АНУ-ын эдийн засагт эргэлдэж, төсвийнх нь алдагдлыг нөхөж байна.

Харин бидний хувьд бол эдийн засгийн бодлогын нэг номерын асуудал бол хуримтлал, хадгаламжийг нэмэгдүүлэх арга хөшүүргийг бий болгоход оршино. Үүний нэг нь төсвийн дүрэм алтан дүрэм болох дээрх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, төсөв, төрийн сандаа хуримтлалтай болох учиртай байна. Ард иргэдээ ч энэ зүг рүү хандуулах ёстой болж байна. Ийм ч учраас хүүхдийн хуримтлал, өндөр насны тэтгэврийн хадгаламж, хуримтлалыг бий болгохыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл уриалж сурталчилж байна.

- **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс УИХ-ын Төсвийн байнгын хороонд төсвийн тодотголын төсөлтэй холбоотой саналуудыг хүргүүлж байгаа юм байна. Ямар асуудлыг онцолж байгаа юм бэ?**

Төрөөс аливаа тэтгэмж, дэмжлэг болон татвар, шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхдээ иргэдийн орлоготой холбох, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, улс орныхоо зээлжих зэрэглэлд илүүтэй анхаарч, өрийг багасгах, төсөвт онцгой нөлөөтэй нүүрс зэргийн борлуулалтыг

дэмжих арга замыг олох, үнэгүйдээд буй мал аж ахуй зарим түүхий эд үнэгүйдлийг багасгах чадавхийг сайжруулах зэрэг санал санаачилга гаргаж байгаа.

Гадаад орчин маш ээдрээтэй, хаашаа ч эргэж болзошгүй байгаа тул төсвийн зардлыг хасах эрхээ Засгийн газар УИХ-аас өөртөө авч, шуурхай ажиллах, төсвийн орлогын бүрдүүлэлтийн хэмжээнд санхүүжилтийн эрхээ авах, Сангийн яамны хяналтыг тойруулж, төсвийн шинжтэй задлыг гаргаж, улс орныг ерөнд оруулдаг сувгуудыг ил болгож, хязгаарлах, тайлан мэдээлэл тогтмол хийж байхыг санал болгож байгаа. Жишээ нь, төсвийн шинжтэй зардлуудыг гаргадаг Төв банк, Хөгжлийн банк, концесс, төрийн өмчийн байгууллага, компаниуд зэрэг далд сувгуудад анхаарал тавин ажиллаж байна.

- **Эдгээр саналуудаас дэлгэрүүлж тодруулмаар байна. Дундаж цалингаас доош орлоготой иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг түр хойшлуулах саналыг гаргаж байгаа үндэслэлийг тайлбарлахгүй юу?**

Нийгмийн даатгалын шимтгэлийн зарим хэсгийг буцааж олгох нь зөв байж болох ч бас л амьдралын ялгааг үл хамаарсан, нийгмийн эмзэг хэсэгт очих мөнгөнөөс хумсалдаг, хавтгайрсан халамжийн шинж гэж үзэж байгаа. Бага болон дундаж орлоготой иргэдэд шимтгэлийн тодорхой хэсгийг буцааж өгөхийг дэмжиж байна. Шударга ёс зүйг сахиулахгүй бол амьдралын ялгаварлал улам нэмэгдэж нийгэм бухимдалтай байх талтай.

- **Тендерээс татгалзаж дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шууд гэрээгээр худалдан авах ба үнэ нь олон улсын зах зээлийн үнээс 20 орчим хувь өндөр байхыг зөвшөөрөх тухай санал анхаарал татаж байна. Шууд гэрээгээр худалдан авах нь эрсдэл дагуулдаг гэж ойлгодог. Хуулиараа заавал тендер зарлах ёстой биш үү?**

Тендер аль хэдийний олон тохиолдолд дүр эсгэсэн ажиллагаа болсон хэмээн бизнес эрхлэгчид ярьдаг юм билээ. Тийм ч байх. Ихэнх орнуудад захиалагч хамгийн шилдэг үйлдвэрлэгчдийг урьж уулзаад гэрээ хэлцлээ хийдэг болсон. Харин сонголт буруу хийсэн байвал тухайн захиалагч хариуцлагаа хүлээдэг байх аа. Захиалгаар дүүрээд зарим үйлдвэрлэгчид урилгаас татгалзсан байх талтай. Манайд масс, бөөн хэмжээний үйлдвэрлэл бараг байхгүй болсон шиг байна. Төр асар том худалдан авагч болохоор дотоодынхоо бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлийн үнээс 20 хувиар өндөр үнээр авахыг зөвшөөрч, хамгийн бага үнийн зарчмаас зоригтой салах санал дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл, дотоод үйлдвэрлэл явагдаж ажлын байртай болж байвал 20 хувийн зардал аяндаа нөхөгдөнө. Шударга өрсөлдөөнийг хамгийн их сурталчилдаг АНУ саяхнаас дотоодын бүтээгдэхүүнээ 25 хувиар өндөр үнээр дотоод зах зээлээс авах шийдвэр гаргалаа.

- **Зэс, төмөр, нүүрсний ханш, үнийн өсөлтөөс олох орлого гэдэг өнөөдрийн байдлаар хэр бодит вэ. Учир нь хил гааль хязгаарлалттай байгаа үед эдгээр бүтээгдэхүүний экспорт төлөвлөсөн хэмжээгээр гарч чадаж байгаа юу?**

Тийм. Тоо хэмжээний хувьд 30 гарсан сая тонн нүүрс гаргаж чадахгүй байх. Мөн төмрийн хүдрийг ч санасан хэмжээнд экспортлоход хүндрэлтэй байх нөхцөл үүсэхээр байна. Иймээс үнэ хүргэж худалдах, ханшийн уналт, үнийн өсөлтөөс олж буй нэмэгдэл орлогодоо тайвшрахгүйгээр хүчин чармайлтыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

- **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргын хувьд Хөгжлийн банкны алдагдалтай холбоотой ямар байр суурьтай байна вэ. Хөгжлийн банкны олгосон зээлээс төсөв хариуцах зарим зээлд өрийн баталгаа гаргаж бусдыг нь зээлдэгчидтэй хамтран төлүүлэх мастер төлөвлөгөө гаргуулж батлуулах ёстой гэж үзсэн байна. Энэ асуудлыг дэлгэрүүлэхгүй юу?**

Энэ асуудал хэвлэл мэдээлэл хийгээд УИХ дээр зөндөө яригдлаа. Үр дүнгээ өгч байна гэсэн дүгнэлттэй байна. Зээл төлөгдөж байна. Хамгийн чухал нь зээлийг эргүүлэн төлүүлж, улсыг хохиролгүй болгох явдал юм. Хүндэрсэн банкуудад хоёр жилийн өмнө манайд хийсэн Дэлхийн банкны судалгаагаар зээлдэгч болон зээл гаргагчидтай хамтран ажиллах нь бусад орнуудтай харьцуулахад ихээхэн доор түвшинд, бараг тэг үнэлгээ авсан харагдсан. Үүнээс санаа авч ажлаа мэдэх хүмүүсийг хөндийрүүлж, улсыг хохироох, мөн бас ял завшуулах байдал гаргаж болохгүй.

- **Бондын эргэн төлөлтийн асуудал олны анхаарлын төвд байгаа. Монгол Улсын хувьд төлөх чадамж бий юу, ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?**

УИХ-аас өрийн удирдлагын стратеги баталсан. Авсан, өгсний зөрүүгээр өр буурсан байх зарчим тогтоосон. Үүнийг хэрэгжүүлж, 2023 онд төлөгдөх бондын наад зах нь 20-оос доошгүй хувийг төлж, үлдсэнийг нь дахин зээллэгжүүлэх бэлтгэлийг одооноос хангах ёстой. Үүний тулд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулж болох аливаа эрсдлээс зайлхийж, төсвийн алдагдлыг багасгах, Хөгжлийн банкны төлбөрийн чадварыг дээшлүүлж, бондынхоо төлбөрийн шийдлийг хямд аргаар шийдэх санаа юм. Зориглоод төлчихвөл их ачаа хөнгөрч, төсвөөс гардаг хүүний төлбөр яваандаа багасна. Одоо нэг их наяд төгрөг болж байна.

- **Дарханы арьс ширний үйлдвэрийг түшиглэн мэргэжилтнүүд бэлтгэх шаардлагатай гэж үзсэн байна. Хэтийн үр дүн, ач холбогдлыг юу гэж харж байна вэ?**

Сүүлийн жилүүдэд арьс, ширний үнэ унаж, бараг хог дээр хаягдахад хүрч байна. Энэ салбар уг нь улсын төсөвт ихээхэн орлого оруулж, олон хүнийг ажлын байраар хангах боломжтой. Бид Улаабаатар, Дарханы зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцсан. Тэнд сайн инженер, гадаадын мэргэжилтэн, арьс, ширний анхан шатны тордолтоос эхлээд зөөлөн шир, торгон арьс болтол бүх технологийг мэддэг залуус байсан. Миний бие бас зарим оюутан аспирантуудын судалгаатай танилцахад манай их сургуулиудад энэ чиглэлийн суралцагчид, заадаг багш бараг байхгүй байсан.

Дарханд арьс ширний томоохон цогцолбор барих төлөвлөгөө гарсан байна. Хориод сая богийн арьс, хоёр сая орчим бодын арьс бол асар их нөөц. Олон улсад арьс шир эргээд сэргэх шинжтэй болж, технологи сайжирч буй мэдээ байгаа. Эдгээрийг бодолцож, олон улсын жишгийн дагуу үйлдвэрийг бараадуулж, хүнийг сургаасай гэсэн дохио, мэдээ гэх үү дээ. Тэнд хүмүүсээ сургаад улс даяар сургагч багш нарыг бэлтгэж, өргөн цар хүрээтэй сургалт хийж, хүмүүсээ чадавхжуулах боломж байна гэж харж байгаа. Монгол Улсын Шинэ сэргэлтийн бодлогын нэгэн чухал жишиг асуудал бол энэ агаад цаашаа ноос, мах, сүү гээд хөврөөд баяжаад явах цар хүрээтэй. Сум орон нутгийн төсвийн баазыг бэхжүүлэх жишиг болох нэн чухал ажил болно гэж найдаж байна.

Б.ЗАЯА

Хавсралт 6. Өдрийн сонинд өгсөн ярилцлага

Д.Даваасамбуу: **Баялгийн өгөөжийг хувь хүний хуримтлалд зарцуулах нь илүү үр дүнтэй**

УИХ-ын дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023-2025 оны төсөөлөл, өрийн стратегийн байдалд санал дүгнэлтээ өгөөд байгаа. Үүнтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуутай ярилцлаа.

- **Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгнө үү. Инфляцийн түвшин, төсвийн байдал ямар байгаа талаар болон хүндрэл хэрхэн үүссэн талаар, өрийн байдал ямар байгаа талаар бодит мэдээллийг тодруулж өгөхгүй юү?**

Эдийн засгийн сэргэлт, өсөлт манай орны хувьд ч дэлхий дахинд ч хүлээгдэж байсан хэмжээнд хүрэхгүй нь. Олон улсын валютын сангийн саяхны тооцоогоор манай эдийн засгийн бодит өсөлт 2022 оны хувьд 1-2 хувьд эргэлдэх аж. Өмнө нь 4-6 хувийн өсөлтийг төсөөлж байсан юм.

Монгол Улс “Ковид-19” цар тахалтай хоёр жил гаруйн хугацаанд вакцинжуулалтаас эхлээд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилласны үр дүнд эдийн засгаа гадаад дотоотод нээж чадсан нь томоохон үр дүн. Цар тахлын хязгаарлалттай үед иргэдийнхээ амьдралд илүүтэй анхаарал тавьж төсөвтөө ихээхэн ачаалал авч, бүх нөөцөө шавхан дайчилсан жилүүд байлаа. Төсвийн хүрээнд эсвэл төсөвт яваандаа нөлөө үзүүлэх төсвийн гадуурх сувгууд болох уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн өнөөгийн болон ирээдүйн орлогыг барьцаалж, зээл сунгах, хүчингүй болгох, орлого тараах, цахилгаан дулааны үнийг төлүүлэх, Монголбанк, Хөгжлийн банкаар дамжуулан төсвийн шинжтэй зээл санхүүжилт олгуулах зэрэг арга хэмжээнүүд энэ жилүүдэд дээд цэгтэй хүрсэн. Жишээ нь, Монгол Улсын 2020, 2021 оны нэгдсэн төсвийн нийт орлого нь урсгал зардлыг санхүүжүүлэхээс хэтрэхгүй, хөгжил, хөрөнгө оруулалтад зарцуулах төсвийн өөрийн эх үүсвэргүй болж, гадны зээл, төсвийн тогтворжуулалтын болон ирээдүйн өв сан, төсөвт хуримтлагдсан нөөцөө бүрэн ашигласан. Төсвийн урсгал зардлын мөн чанарыг айл гэрээр төсөөлбөл тухайн өрх бүх орлогоо хоол хүнс, цахилгаан дулаан, хувцас, гэр ахуйн хэрэглэл зэрэг өдөр тутмын хэрэглээнд ашиглаад дуусч нэг оёдлын машин ч авч чадахгүй байгаатай адил ойлголт билээ.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төсвийн алтан дүрэм бол төсвийн урсгал тэнцлийг ямагт ашигтай байлгаж, ашгаар нь эдийн засгийн хөгжлийг дэмжихэд хөрөнгө оруулдагт оршдог. Иймээс Засгийн газраас санаачилсан төсвийн хэмнэлтийн бодлогыг талархан хүлээн авч дэмжиж, цаашдаа төсвийн дунд хугацааны хүрээний мэдэгдлээр дамжуулан байнгын механизм болгох санал дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл, төсвийн суурь зардлуудад урт хугацаанд мөрдөх лимит болгон тогтоож, түүнээс хэмнэлт гаргах, ончтой зүйлд шилжүүлэн зарцуулах эрх олгох зэргээр төсөв захирагчдын төсөв хэмнэх сонирхол, хариуцлагыг өндөрсгөх хөшүүрэг болгох санааг хэлж байгаа. Олон оронд ийм туршлага дэлгэрч буй юм билээ.

- **Өгөөжтэй санаа байна. Гэхдээ дотоодын эдийн засгийн хувьд тулгарч байгаа бэрхшээлүүд юу байна вэ?**

Эдийн засгийн хандлагаа дагаад 2022 оны төсөв, санхүүгийн тодорхойгүй орчин үргэлжилж, шинэ сорилтууд тулгарч байна. Ялангуяа гадаад орчноос нэн хамааралтай сорилт хүнд байгаа. Тодруулж хэлбэл, БНХАУ-ын төр засгаас “Ковид-19” цар тахалтай холбогдуулан авч буй хатуу хориг арга хэмжээ, ОХУ-ын Украины эсрэг явуулсан цэрэг дайны ажиллагаатай холбогдсон нөхцөл байдал, санхүү эдийн засгийн төрөл бүрийн хориг, дэлхий дахиныг хамарсан инфляц, үнийн өсөлт зэрэг нь манайд сөрөг нөлөөгөө үзүүлж байна. АНУ тэргүүтэй өрнөдийн орнуудын 6-8 хувьтай инфляцын өсөлтийг богино хугацаанд тогтоон барьж, хоёр хувь, түүнээс доош оруулахад чиглэсэн төсөв, сангийн бодлого явуулж эхлээд байна. Энэ нь эдийн засаг дахь мөнгийг хязгаарлаж, улмаар дэлхийн хөгжил 2022 оны хувьд саарч зогсонги байдалд хүрч болзошгүй. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх ОУВС-гийн судалгаанаас үзэхэд өмнөх төсөөллийг бараг хоёр дахин бууруулсны дотор манай хоёр хөршийн нөхцөл илүүтэй хүндэрч болзошгүй байна. Хятадын эдийн засгийн өсөлтийн хурд бараг хоёр дахин буурч, ОХУ-ын эдийн засаг 8.5 хувиар агшихаар байна.

Дэлхийн хэмжээнд зэс, төмрийн үйлдвэрлэл, хэрэглээний 50-аас дээш хувийг эзэлдэг БНХАУ-д эрэлт буурах, өрнөдийн эдийн засгийн өсөлтийн сааралт зэрэг нь манай улсын экспортын гол

бүтээгдэхүүн болох зэс, төмрийн хүдэр, төмрийн хүдэр хайлдаг коксжих нүүрс зэргийн үнэ, эрэлт, нийлүүлтэд доголдол гарах эрсдэлтэй байна. Сүүлийн өдрүүдэд зэс, төмрийн үнэ буурах хандлага руу орж байгаа. Эдгээр таваарын бүтээгдэхүүнүүд дэлхий дахины доргилтод нэлээд өртөмтгий байдгийг бид бас мэдэрч байсан шүү дээ. Жишээ нь, зэсийн үнэ 2008 оны эхний хагас жилд 9000 ам.доллар давж байснаа оны сүүлд гурав дахин буурсан түүх бий. Дээр нь цахилгаан дулаан, газ, бензин шатахуун, үр тарианы гол тоглогч ОХУ-д үйлдвэрлэл буурна гэдэг нь энэ төрлийн таваарын бүтээгдэхүүний үнийн өсөлт 2022 оны турш үргэлжлэх эрсдэлтэй. Энэ нь юуны өмнө манай төлбөрийн тэнцэл, өр төлбөрт сөрөг нөлөөтэй. ОУВС-гийн ээлжит үнэлгээнээс үзэхэд 2022 онд манай улсын төлбөрийн тэнцэл ихээхэн алдагдалтай, ялангуяа 2022-2023 онуудад өсч, ДНБ-ний 14-18 хувь болох, импортын бензин шатахууны үнийн өсөлт дангаараа нийт импортыг 25-30 хувиар нэмэгдүүлэхээр байна.

- **Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн санал дээр тодруулмаар байна. Монгол Улсын нэгдсэн төсвийг 2023 оноос эхлэн алдагдалгүй болгохоор төсвийн төсөл, төсөөлөлд тусгахыг хамгийн түрүүнд онцолсон байсан. Үндэслэл нь юу вэ?**

Манай гол нэрийн экспортын бүтээгдэхүүний үнэ 2023 онд харьцангуй өндөр байх төсөөлөл байгаагийн дээр Оюу толгойн далд уурхай ашиглалтад орно. Ийм боломжийг ашиглан улсынхаа санхүүг алдалгүй болгох ажилд зориглон орох хэрэгтэй гэж үзэж байгаа. Үүнд чиглэсэн эдийн засгийн стратеги, чиглэлийг төсөв-сан, мөнгөний бодлогууд, тэдгээрийн хэрэгсэлтэй холбон явуулаасай гэсэн хүсэлт юм.

Дээр хэлсэнчлэн төсвийн алтан дүрэм, төсөв дээрээ өр төлбөр үүсгэхгүй байх, хуримтлал бий болгох тухай Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтуудыг чандлан мөрдөж, хувийн хэвшлийг давамгайлан оролцуулах нөхцөл боломжийг илүүтэй авч үзэж, бүтээмжтэй ажлын байр бий болгоход оюун ухаанаа уралдуулцгаана уу гэсэн уриалга юм. Манай орны, дэлхий дахины номер нэг асуудал болсон инфляцийг импортлон оруулахыг хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэл, тээвэр ложистикийн сүлжээг орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан бий болгож удирдахад илүү анхаарал тавих хэрэгтэй байна. Гадаад орчноо, үнэ ханш тогтоодог гэрээ хэлэлцээрийг чамбай хийхийг сануулах нь илүүц биз ээ. Үүнд төр ч туслах ёстой, өнөөгийн геополитикийн нөхцөлийг зөв ашиглах, миний ойлголтоор бензин, шатахуун дээр үр дүн гарсан гэсэн ойлголт байна. ОХУ, БНХАУ-тай худалдааны хэлэлцээрийг эрчимжүүлж, татварын хөнгөлөлт олж авах нь чухал байна.

Дэлхийн банк, ОУВС-гаас хамтран 30 тэрбум ам.долларын санхүүжилт бүхий хүнсний аюулгүй байдлын тухай хөтөлбөр зарлагдлаа. Энэ хөтөлбөртэй манайх бодлогоо зохицуулах боломжийг холбогдох яам, газрууд судлана байх аа.

Бидний зүгээс хүсч ирсэн бас нэг зүйл бол ядахдаа төсвийн зардлаар импортыг дэмжихгүйн тулд дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ ажлын байр бий болгоход чиглэсэн худалдан авалтыг тендергүйгээр дэмжих боломжийг судлах саналыг 2022 оны төсвөөс эхлэн тавьж байгаа. Татварын хууль, орон нутгийн засаг захиргааны удирдлагын шинэ хуулиар хүн амын орлогын татвар 100 хувь сум дүүрэгт, аж ахуйн нэгжийн татварын 60 хувь орон нутгийн төсөвт орно. Энэ зарчим хоёр жилийн өмнө зарлагдсантай зэрэгцээд халамжаас ажлын байранд гэсэн бодлогын шинэчлэл өнгөрсөн оноос эхэлсэн, үр дүнгээ хүлээж байна. Одоо бүх шатны Засаг дарга, нутгийн удирлагаас хуулийн хэрэгжилтийг асууж, 2023 оноос үр дүнд хүрэхийг “шаард” гэсэн захиалга юм. Ажлын байр олон болвол хот хөдөөгүй хүмүүс орлоготой болж, төсөвт эерэг нөлөө үзүүлнэ. Төсөв жинхэнээрээ тогтворжино. Мөнгөний бодлогын тухайд өндөржүүлсэн хүүгээр инфляцийн өсөлт ялангуяа дайн, хоригтой холбогдсон хүнс, үр тариа, бензин шатахууны үнийн өсөлтийг хязгаарлахад түвэгтэй гэдгийг зарим судлаачид хэлж байна. Төв банкныхаа хүүг АНУ 0.5 хувь нэгжээр энэ ондоо багтаан гурван удаа нэмэх, Европын бүс энэ оны 6-7 дугаар сараас 0.25 хувь нэгжээс эхлэн аажмаар нэмэгдүүлж нэг хувь болгох тухай зорилт тавин ажиллаж байна. Эдгээр орнуудад инфляци 6-8 хувь, түүнээс эрчим хүч, хүнсний үнийн өсөлтийг хасаж цэвэрлээд гурав орчим хувийн суурь инфляцитай гэж тооцон түүнийг онилж багасгах тухай мэдээлж байна. БНХАУ бол эдийн засгийн өсөлт саарахаас сэргийлж, мөнгөний бодлогын зарим элементүүдийг сулруулж, эдийн засгаа мөнгөжүүлэх зорилт тавьж байна. Энэ бүхэн нь юуг харуулж байна вэ гэхээр том эдийн засагтай орнууд инфляци 2022 онд багтаан бууруулж аваад 2023 оноос эдийн засгийн сэргэлт газар сайгүй явагдах нөхцөл

бүрдүүлэхийг хичээж байна. Энэ ч бас бидэнд хамааралтай, тэднээс санаа авч, инфляцийн түвшинг түргэн хугацаанд доошлуулах нь чухал юм.

- **Мэдээж ирэх гурван жил бол Монгол Улсын хувьд маш хариуцлагатай цаг хугацаа. Оюутолгойн орд бүрэн ашиглалтад орсны дараах эдийн засгийг бид хэрхэн тооцоолж, төлөвлөх ёстой вэ?**

Зэсийн нөөц, үйлдвэрлэлийн цар хүрээгээрээ дэлхийн хэмжээний Оюутолгойн ордыг 2023 оноос эхлэн бүрэн хэмжээгээрээ ашиглаж эхэлнэ. Өмнийн говийн төмөр замын бүтээн байгуулалтууд дуусч, нүүрс зэрэг баялгийн экспорт нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Тэнд цахилгаан станцаа сүндэрлүүлэх ёстой. Энэ бүхэн бол Монгол Улсад сүүлийн 50 жилд олдож буй, цаашид гарах эсэх нь тодорхойгүй хувь заяа. Үүн дээр алдаа гаргаж огт болохгүй. Нийгмийн хүлээлтийг зөв удирдах учиртай, ололт амжилт, алдаанаас дүгнэлт хийж, гадны туршлагын цаад утгыг ухаж ойлгох үндсэн дээр ончтой шийдвэр гаргах нь чухал.

- **Ирээдүйд хоёр төрлийн хуримтлал үүсгэх, энэ чиглэлээр төсвийн хүрээний мэдэгдлийг сайжруулах ёстой гэж үзсэн байна лээ. Ямар байдлаар хэрхэн хуримтлал үүсгэх ёстой вэ. Олон улсад энэ төрлийн жишиг юу байна?**

Хүүхдийн мөнгийг ирээдүйд нь зориулж хуримтлал болгох тухай Засгийн газар, Сангийн яамны санал ихэнх эцэг эхчүүдийн санаа бодолд нийцнэ гэж ойлгож байна. Хоёр гурван жилийн өмнө зарим сумдаар орж, банкны салбарынхаас асууж тодруулахад хүүхдийн мөнгөнийхөө 40-50 хувийг эцэг эхчүүд хадгаламж болгодог гэж байсан. Дээрээс нь жаахан шахалт болгон хуулийн шаардлага, үндэслэл бий болговол иргэд дагана гэсэн бодол байна. Мөн Монголын хөгжлийн ирээдүй гэгээлэг болно. Монгол Улс жилдээ нэг их наяд төгрөгийн хүүхдийн хадгаламж бий болгож, чадвал энэ мөнгө хадгаламжийнхаа хүүгийн хамт хөдөлмөрийн насанд хүрэх 16 жилийн турш нийтдээ улсын хэмжээнд 50 их наяд төгрөг болно. Үүнийг өнөөгийн ДНБ 40 орчим их наяд төгрөгтэй харьцуулан бодоход асар их мөнгө, банк, санхүүгийн салбарт цугларч, зээл, хөрөнгө оруулалтын урт хугацааны томоохон эх үүсвэр бүрдэнэ. Хувийн тэтгэврийн хадгаламжийн тогтолцоотой ихэнх орнуудад тэтгэврийн хадгаламжийн үлдэгдэл ДНБ-ээс голчлон давсан мэдээ байна. Жишээ нь, тэтгэврийн даатгалын актив ДНБ-ийх нь АНУ-д 157 хувь, Их Британид 135 хүрснийг “Файнэншил Таймс” сонин онцолж, Хятадын иргэдийн тэтгэврийн хадгаламжийн үлдэгдэл 2020 оны байдлаар 285 тэрбум ам.доллар байгааг өнгөрсөн дөрөвдүгээр сард мэдээлсэн. Энэ бол хөгжлийн асар их нөөц, хөдөлгөгч хүч, хөрөнгө оруулалтын сангуудын эх үүсвэр болдог юм байна.

Монгол түмэн төдийгүй олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хүлээлтэд орсон бас нэг асуудал бол өндөр насны тэтгэврийн шинэчлэл юм. Дэлхий дахинд насжилт нэмэгдэж төр дангаараа өндөр насны тэтгэврийн санхүүжилтийг хариуцах нь эрсдэлтэй болсон. Иймээс хувь хүмүүс ажил олгогчтой энэхүү эрсдэл зардлыг төр хуваалцах, нас өндөр болсон үедээ хэвийн сайхан амьдрахад хэрэг болох хувийн тэтгэврийн нэмэгдэл хадгаламжтай болгох зам руу бараг орнууд ороод байна. Манай орны хувьд өнөөгийн тэтгэврийн тогтолцоог богино хугацаанд бүрмөсөн өөрчлөх боломж хязгаарлагдмал байна. Гэхдээ даатгалд хамралтыг яаж өсгөх, ямар хөшүүрэг байх, тэтгэвэртээ гарахдаа хувийн нэмэгдэл тэтгэврийн хадгаламжид хэдэн төгрөгтэй болгох түүнийгээ 50 нас хүрэхээр зарим зүйл эмчилгээ, орон байрны зээлийн төлбөр зэрэгт ашигладаг болох явдал юм. Энэ үүднээс тэтгэврийн хувийн хадгаламжийг 2023 оноос бий болгох санал тавьж байгаа. Чингэхдээ хувийн өндөр насны хадгаламжид насанд хүрсэн цагаасаа тэтгэвэртээ гартлаа хамрагдаж, харин 50 нас хүрэхээр тодорхой зүйлд дээр хэлсэнчлэн зарцуулах эрхийг нь нээх, хувь хүмүүс, ажил олгогчдод дарамт бага учруулах арга замыг тодорхойлж болно гэж үзэж байгаа. Гол зарчим нь таныг өөрийн тэтгэврийн хадгаламжид мөнгө хийвэл улс түүнийг нэмэгдүүлж урамшуулдаг байх явдал юм гэсэн хувилбараар судалгаа хийж байна. Тал бүрийн оролцоог хангах замаар жилдээ улсын хэмжээнд 300-500 тэрбум төгрөгийн албан журмын хувийн тэтгэврийн хадгаламжийг бүрдүүлэх зорилт тавьж түүндээ хүрч чадвал тэтгэврийн шинэчлэл аяндаа явагдаж, нийгмийн баталгаа, хөрөнгө оруулалтын сангууд үүсэх болно. Тэтгэврийн хадгаламж хүүнийхээ хамт 7-10 жил тутам хоёр дахин өсөөд явна. Ер нь АНУ, Англи, Хятад, Австрали зэрэг тэтгэврийн шимтгэл нь 100 хувь өөрсдийнх хадгаламжийн дансанд ордог тогтолцоонд хүрэх сэтгэл зүй, санхүүгийн бэлтгэл манайд хангагдаагүй байж болох ч бага ч гэсэн хэмжээгээр тэтгэврийн хадгаламжийг эхлүүлэх нь зүйтэй болов уу.

Хувийн хадгаламжийн баталгааны хуулиар нэг хүний 20 сая төгрөгийн эрсдэлийг улс хариуцдаг, энэ хэмжээний дотор иргэдэд хохирол гарахгүй болно. Хүүхдийн мөнгийг хадгаламж болгох, өндөр насны тэтгэврийн албан журмын нэмэгдэл хадгаламж бий болгох саналын гол цаад агуулга нь жирийн иргэд, амьдралаа чадан ядан залгуулж буй нийгмийн хэсгийг юуны түрүүнд хадгаламжтай болгож, амьдралын баталгааг нь нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Энэ бүхэн эцсийн дүндээ Үндсэн хуулинд 2019 онд орсон өөрчлөлтөөр байгалийн баялгийн өгөөжийг одоо ба хойч үедээ тэгш хүртээнэ гэсэн зарчмын заалтыг хэрэгжүүлэхдээ хүүхдийн мөнгөний хуримталал, өндөр насны хуримтлал бий болгож, хойч үедээ зориулсан хуримтлал үлдээх нь асуудал гэж үзэж байна. Энэ хуримтлал банкуудад хадгалагдаж, хөрөнгө оруулалтын хийгээд хөгжлийн сан болох юм. Ийм хуримтлалыг хувь хүмүүсийн нэр дээр, тэдний дансанд хадгалуулж, тодорхой хугацаанд үржүүлдэг дээрх арга хэрэгсэл манайд зохимжтой, найдвартай хөдөлшгүй зүйл болно гэж үзэж байгаа. Хувь хүний мөнгийг төр дайчилж авах нь Үндсэн хуулиар хориотой.

- **Норвегийн, Чилийн эсвэл Ботсван зэрэг орнууд уул уурхайн орлогоосоо тэтгэвэр, хөрөнгө оруулалтын сан байгуулж амжилтад хүрсэн гэдэг. Манайд ч ирээдүйн өв сан байна. Та бүгдийн санал үүнээс юугаараа ялгаатай юм бэ?**

Таны дурдсан орнуудын жишгийг баримжаалан манай улс гэнэтийн ашгийн буюу зэс зэрэг бүтээгдэхүүний үнэ тодорхой босгоос өндөр гарвал түүнийг их ашиг гэж үзэн 68 хувийн татвар ногдуулан хөгжлийн сан байгуулах шийдвэрийг гаргаж, 2006-2007 оны үед хэрэгжүүлж байсан ч манай орны хувьд боломжгүй гэж үзээд тухай шийдвэрийг цуцалж байсан билээ. Норвеги улс газрын тосны нөөцтэй, үүнийг ашиглаж буй аж ахуйн нэгжүүдэд 75 хувийн татвар ногдуулж, 50 хувийг тэтгэврийн сандаа хуримтлуулж, асар их нөөц үүсгэж, түүгээрээ олон улсын санхүү, хөрөнгийн зах зээлд оролцож байна. Өндөр хөгжилтэй Норвеги улс дэд бүтэц, амьдралын чанар, эдийн засаг, байгаль цаг уурын орчноороо дэлхийд эхний байранд ордог орны хувьд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид 25 хувийн ашгийн маажин дээр ажиллах сонирхолтой байдаг биз ээ.

Чили зэс ихтэй, үйлдвэрлэлийн дэд бүтэц сайтай, хөрөнгө оруулалт татах таатай орчинтой гэж үзэж, ашигт ажиллагааны түвшин 15 хувиас дээш гарвал тодорхой хэмжээний нэмэгдэл ашгийн татвар авч, тогтворжуулалтын сан бүрдүүлж байсан. Ботсваны хувьд асар их үнэ хүрдэг очир алмааз ихтэй, түүний олборлолтын ашгаас 50 шахам хувиар татвар авч, түүний зарим хэсгийг хуримтлуулдаг байсан. Бидний хуримтлал үүсгэх санал бол хувь хүмүүсийн сонирхол эрх ашигт нийцсэн, тэдний болон банкуудын хариуцлага чадавхид түшиглэсэн байгаа. Үүгээрээ ялгаатай.

Байгалийн баялгийн үнэ нэмэгдэж, ашиглалт нь идэвхжсэн 2005-2006 оноос эхлээд өнөөг хүртэл төрийн мэдэлд уул уурхайн орлогоос эдийн засгийн хөгжлийн сан, хүний хөгжлийн сан, төсвийн тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан зэрэг сайхан нэр хаягтай олон сангуудыг төрийн мэдэлд байгуулсан ч өдгөө бүгдийг нь “аргагүй” шалтгааны улмаас ашиглаад бараг дууссан мэдээтэй байна. Иймээс хувь хүмүүсийн мэдэлд байлгах нь илүү найдвартай, хөгжлийн манлайд хүрэх гэрэлт замыг нээнэ гэж үзэж байна. Чингэхдээ манай орны хувьд хүүхдийн дансанд хуримтлал үүсгэж, насанд хүртэл нь хадгалж үржүүлэх, хөдөлмөрийн насанд хүрсэн бүх иргэдээ ирээдүйн тэтгэврийн даатгалд албан журмаар давхар хамааруулж, урт удаан хугацааны хадгаламж хуримтлалтай болох санал дэвшүүлж байгаа юм. Ийм хоёр төрлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болох хэрэгтэй байна. Үүнийг Оюутолгойн зэс, Тавантолгойн нүүрсний ордын идэвхтэй ашиглалт эхлэх 2024 оноос эхлэх нь зөв гэж үзэж дээрх хоёр санал гаргасан хэрэг. Арилжааны банкуудад урт хугацаанд хадгалагдах эдгээр эх үүсвэрүүдийг ашиглаж, банкууд дотоод, гадаадын хөрөнгө, санхүүгийн зах зээлд оролцдог болно биз ээ. Одоохондоо иргэдийн мөнгийг хадгалж үржүүлж буй гол бүтэц манай орны хувьд банкууд байна. Харин тэднийхээ чадавх, боломжийг нь улам сайжруулж, тэдэнд түшиж ажиллахаас өөр арга замгүй. Аажимдаа хөрөнгө оруулалтын сангууд, тэдгээрийг удирдах компаниуд, хувьцааны зах зээл хөгжихийг үгүйсгэхгүй. Гагцхүү эдгээрийн гол нөхцөл нь удаан хугацааны тэтгэврийн хадгаламж, төрөл бүрийн хувийн сангууд болно.

- **Зөвлөлөөс Засгийн газрын өрийн удирдлагын стратегид тусгайлан санал өгсөн байсан. Томоохон бондуудын эргэн төлөлт тун удахгүй эхэлнэ. Өрийн дарамт ямар нөхцөл байдалтай байна вэ. Төлөх боломж, бололцоо манайд хэр байх юм?**

Олон улсад зээлийн хүү нэмэгдэх эрсдэл байна. Дэлхий дахины сөргөлдөөн, санхүүгийн хоригууд, тээвэр ложистк, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, үнэ ханшийн өсөлтөөс үүдэлтэйгээр олон улсын санхүүгийн зах зээлд зээллэгийн үнэ өндөр байх төлөвтэй. Нөгөө талаар ирэх жилүүдэд төлөгдөх Засгийн газрын болон Монгол Улсын Хөгжлийн банкны бондуудын төлбөрийг бүхэлд нь өөрийн нөөцөөс албан ёсны зээл, тусламжийн хүрээнд барагдуулах боломж нэн ховор бөгөөд зөвхөн Олон улсын санхүү, үнэт цаас, бондын зах зээлтэй харилцаж шийдвэрлүүлэх учиртай гэж ойлгож байгаа. Иймээс Засгийн газрын хийгээд төрийн мэдлийн Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг хэвийн хэмжээнд байлгах тухай Сангийн яамны хүчин чармайлтыг УИХ-аас дэмжиж тодорхой арга хэмжээ авч байх шиг байна. Дөнгөж нэг хоёр хоногийн өмнө Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтвортой гэсэн дүгнэлтийг зарим үнэлгээний байгууллага гарсан нааштай мэдээ олон улсад цацагдсан. Гэхдээ Монгол Улсыг өр ихтэй орны хувьд баялгаа зөв ашиглаж, өрийн дарамтаа багасгах найдварыг олон улсын хэмжээнд тавьж байна. Өр зээл нэмэгдсэнээс болж, экспортын орлогын бараг 50 орчим хувийг өрийн үйлчилгээнд зарцуулах болж байгаагийн дотор зөвхөн Засгийн газрын зээлийн хүүний төлбөр дангаараа нэг их наяд төгрөг орчим болж, боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, тэтгэмж зэрэг нийгмийн үйлчилгээг хязгаарлах болж байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн заалтуудыг мөрдөх хугацаанд төлөгдөх хуваарьтай бондын 20-оос доошгүй хувийг төлж, үлдэх хэсгийг дахин санхүүжүүлэх арга хэмжээ авах санал тавьж байна. Мөн бонд зэрэг арилжааны зээл дахин авахыг дээрх дахин санхүүжилтээр хязгаарлаж, албан ёсны хөнгөлөлттэй зээл, тусламж авахыг хичээх зөвлөмж өгч байгаа.

- **Засгийн газрын өрийн үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцдог эрх зүйн үндсийг өөрчилж, бодит байдалд нийцүүлэх ёстой гэж үзжээ. Ямар арга зам байна вэ?**

Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 онд батлагдсан хуульд өрийн үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцно гэсэн байдаг. Энэ заалт маань амьдралаас хоцорсон, өрийн хэмжээг хиймлээр бууруулж харуулдаг учраас өөрчлөх ёстой гэж үзэж байна. Олон улсын байгууллагууд, гадаад орнуудад улс орнуудын өрийг өнөөгийн үнэ цэнээр тооцохгүй байгаа юм.

Б.ЦЭЦЭГ

Д.Даваасамбуу: Төсөв алдагдалгүй байх бүрэн боломж бий

Б.НЯМСҮРЭН

УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэд төрийн мөнгийг хэрхэн зарцуулж байгаад хяналт тавьдаг “хоточ нохой”-н үүрэгтэй зөвлөл бий.

УИХ-аар Төсвийн төслийг хэлэлцэж байгаа энэ үед Төсвийн байнгын хорооны дэргэдэх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуутай ярилцлаа.

- **2023 оны төсвийн төслийг Их хурлаар хэлэлцэж байгаа. Таны хувьд ирэх жилийн төсвийн төслийг ерөнхийд нь хэрхэн харж, дүгнэж байна вэ?**

Нэгдүгээрт, дэлхий дахин дайнтай, цар тахлын хүндрэлтэй, хаашаа ч эргэж магадгүй нөхцөл байдалд байна. Гэхдээ одоогийн дүр зургаар харвал, өнгөрсөн жил ам.долларын ханш 2800 төгрөг байсан бол одоо 3400 төгрөгт хүрч байна. Тэгэхээр экспортын орлого өсөх хандлагатай. Эдийн засаг одоогийн таамаглалаар дөрвөөс таван хувиар өсч магадгүй. Инфляци дунджаар зургаан хувьтай байх болов уу. Ингээд бодохоор төсвийн орлого 25 хувиар өсөх прогноз байна. Эдийн засгийн өсөлт 2022 оныхоос 3,3 их наядаар илүү байгаа. Гэхдээ дээр дурдсан эрсдлийг тооцох ёстой. Одоогийн байдлаар бид 4-5 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний нүүрс гаргах боломж байна уу үгүй юу. Хоёрдугаарт, зэсийн үнэ бууралттай байна. Нэг тонныг нь 8500 ам.доллараар төсөөлж байсан бол одоогоор 7000 орчим ам долларын ханштай байна.

- **Таны хэлснээс ойлгоход төсвийн алдагдал буурсан, эдийн засаг өсөлттэй сайн үзүүлэлттэй байна гэж үзэж болох уу?**

Эдийн засгийн өсөлтийн 3.3 их наядаас шалтгаалж төсвийг алдагдалгүй байлгах боломж бас байна. Төсвийн алдагдал ДНБ-ий 2,8 хувь буюу мөнгөн дүнгээр тооцоход 1,6 их наяд гэж үзэж байгаа. Ер нь төсөв алдагдалтай байх нь хэвийн юм шиг ойлголт байгаад байна. Уг нь төсөв алдагдалтай байна гэдэг өрөнд орно, бусдын хараанд орно л гэсэн үг. Гэр бүлийн хувьд нэг өрөө нөгөөгөөр дардаг бол тэр айл яах билээ. Эргээд нөгөө хүнийхээ эрхшээлд орно, хэлснийг нь хийнэ. Улс орны хувьд ч энэ нь адилхан. Эргээд үндэсний аюулгүй байдалтай холбоотой том асуудал болдог. Ойрын 15 жилд эдийн засагт эерэг үзүүлэлтүүд бий болох боломж бас байна. Оюутолгойн гүний уурхай ашиглалтанд орно. Ойрын жилүүдэд хэд хэдэн замуудаа актив замуудтай холбоод, ачаагаа нааш цааш зөөчихдөг, бараа өнгөрүүлэх чадавхиа дээшлүүлээд, терминалууд байгуулчих боломж байна. БНХАУ-д өнгөрсөн оны сүүлээс эхлээд нэлээд том эрчим хүчний хямрал бий болсон. Хуучин уурхайнууд нь ажиллахаа больж, цахилгаан станцууд доголдоод зөвхөн коксжих гэлтгүй эрчим хүчний нүүрс их хэмжээгээр авах шаардлагатай болсон. Манай улсын хувьд асар их эрчим хүчний нөөцтэй, тиймээс Хятадын энэ хямрал бидний хувьд нэг талаар боломж гэж ойлгож болно. Тэгэхээр төр үүнийг дэмжих хэрэгтэй. Хэрэв төрөөс зөв дэмжээд ухаалаг бодлогоор, зөв замаараа явчихвал Монголд нэлээд ашигтай. БНХАУ-ын нийт эрчим хүчний 60 орчим хувь нь нүүрсэн дээр төвлөрдөг. Мэдээж сүүлийн үед энэ нь багасч байгаа ч ирээдүйн 30 жилдээ алга болчихгүй.

- **Таны тэргүүлж буй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хэзээ байгуулагдсан, ямар үүрэгтэй байгууллага юм бэ?**

Төсвийн хяналтын зөвлөлийг Олон Улсын Валютын сангийн шаардлагаар, төсөвт хөндлөнгөөс дүгнэлт хийх, мөн 2010 онд баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гэсэн хоёр үндсэн үүрэгтэйгээр байгуулсан. Орон тооны бус өсөн хүний бүрэлдэхүүнтэй. Үгээ хэлэхдээ улс төрөөс ангид, аль болох нийгмийнхээ дуу хоолойг дамжуулахыг хичээдэг, үнэлэлт дүгнэлтээ үндэслэлтэйгээр өгөхийг эрмэлздэг.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт гэхээр гурван чухал заалт байгаа. Нэгдүгээрт, төсвийг алдагдалгүй байлгах буюу орлогоороо зарлагаа нөхөх, бүр болохгүй

бол хоёр хувиас хэтрүүлэхгүй байх, хоёрдугаарт Засгийн газрын өрийг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх, гуравдугаарт уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсвөл цаашид хуримтлал бий болгох гэсэн үндсэн зарчим байгаа. Эдгээрийг хэрэгжүүлж чадаж байна уу гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй гэж энгийнээр ойлгож болох юм.

- **Үндэсний аудитын газрын тайланд бас энэ талаар дурдсан байсан. 2023 оны төсвийн төсөл эхний хоёр шаардлагыг хангасан гэсэн үнэлгээг Аудитын газраас өгсөн байсан. Таны хувьд үүнтэй санал нийлж байгаа юу?**

Хоёр шаардлагын хувьд нэг талаар хангагдсан, нөгөө талаар бас эргэлзээтэй. Цаасан дээр хангагдсан гэж дүгнэх өөр. Нөгөө талаар манай Их хурал асуудал хэцүүдээд ирэхээр хуулиа өөрчлөөд түүнийгээ хангагдсан гэж аудитаар дүгнүүлчихээд байгаа юм. Миний санал бол асуудал хүндэрсэн бол хууль өөрчлөхөө урьтал болгохгүй, тухайн заалтаа түдгэлзүүлээд, эргээд боломжтой болсон үедээ биелүүлэх ёстой гэж байгаа юм. Энэ жил гэхэд өрийн таазыг 40 байсныг 60 болгоод өөрчилчихсэн. Уг нь хуулийн талаас харвал буруу юм байхгүй л дээ. УИХ хууль тогтоох бүрэн эрхтэй учраас хуульд өөрчлөлт оруулах эрхээ хэрэгжүүлж байгаа. Гэхдээ нөгөө талдаа өөрсдөдөө тааруулж хуулиа өөрчилчихөөд, хуулийн заалтаа биелүүллээ гэж яриад хэрэггүй юм.

- **Гурав дахь зарчим буюу хуримтлалын сангийн тухайд та юу хэлэх вэ? Баялгийн сан байгуулах, түүнийгээ ирээдүйдээ ашиглах мөн өнөөгийн хөгжлийн томоохон бүтээн байгуулалтдаа зарцуулдаг жишиг уул уурхайд түшиглэсэн улс орнуудад түгээмэл байдаг жишиг. Харин манай улсын хувьд энэ хэрэгжилт ямар “дүн” авахаар хэмжээнд байна вэ?**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Хүний хөгжлийн сан, Хүүхдийн сан, Ирээдүйн өв сан, Тогтвортой хөгжлийн сан зэрэг олон сан байгуулж овоо мөнгөтэй ажилласан. Гэхдээ цар тахлын үед одоогоор бүх мөнгөө шавхчихсан байгаа. Тийм учраас миний хэлж байгаа нэг санал бол энэ бүх сангуудыг төрийн мэдэлд байлгаж болохгүй юм. Мэдээж зарим нь хүүхдийн мөнгөний хэлбэрээр, өөр нэг нь хөдөлмөрийн насны иргэдийн тэтгэврийн урамшууллын хэлбэрээр ч юм уу байх хэрэгтэй. Залуу гэр бүлүүдээ дэмжих зорилгоор хүүхэд бүрийнх нь нэр дээр ирээдүйд хэрэглэх хуримтлалын сан бий болгож болж байна. Мөн сүүлийн үед иргэд нийгмийн даатгал төлөх дургүй болж. Тэгвэл нийгмийн даатгал төлөх хөшүүрэг болгож, тухайн татварт төлсөн мөнгөний 40 хувьтай тэнцэх урамшууллыг тэтгэврийн хадгаламжийн данс болгоод үүсгэчихье. Иргэн 100 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төллөө гэхэд тэтгэврийн дансанд нь 40 мянган төгрөг бодитоор тэр хүний нэр дээр бий болно гэсэн үг. Энэ нь баялгийг ирээдүйдээ зориулах тухай Үндсэн хуулийн заалтад ч бас нийцэж байгаа юм. Гэхдээ энэ төрлийн сангууд байгаа ч Засгийн газрын мэдэлд баймааргүй байгаа юм.

- **Засгийн мэдэлд байлгаж болохгүйн шалтгаан юу байна. Таныхаар хэний мэдэлд байх ёстой вэ?**

Бүх ард түмний мэдэлд байх боломжтой. Иргэн ямар банкаар мөнгөө авахаа өөрөө сонгоод, ирээдүйд тэтгэвэрт гарах үедээ хэрэглэх хуримтлалын сангаа бий болгоно л гэсэн үг.

- **Энэ их мөнгийг арилжааны банкинд байршууллаа гэхэд банк дампуурчихвал яах вэ гэдэг эрсдэл бас бий шүү дээ?**

Бүх банк дампуурна гэж байхгүй. Нэг хоёр банкны асуудал эвгүйдээд, янз бүрийн асуудал үүслээ гэхэд хуулиараа иргэдийн 20 сая төгрөг хүртэлх хадгаламжийг төр хариуцах заалттай. Хоёрдугаарт, банкиг нүдний цөцгий мэт хамгаалж байж улс орон хөгждөг, эргээд таны мөнгө баталгаатай болдог. Ер нь банк руу дайрч болдоггүй.

- **Энэ удаагийн төсвийн нэг онцлог нь анх удаа олон нийтийн саналыг цахимаар хүлээж авсан. Харин иргэдийн санал хэр тусч чадсан бол...?**

Анх удаа төсвийг олон нийтээр хэлэлцүүлж, санаа бодлыг нь тусгаж байгааг би бүрэн дэмжиж байгаа. Иргэдийн саналыг сонссон төсөв гэдэг утгаараа чухал үр дүнтэй болсон гэж үзэж байна. Цаашдаа төсөв боохоос өмнө буюу зургаа, долдугаар сард ч юм уу хэлэлцүүлээд, ард түмэн ийм санал өглөө гэдгээ тайлагнаад, үүнийгээ дараагийн төсөвт

тусгах зэргээр эртнээс бэлтгэдэг баймаар байна. Энэ удаад жаахан хожуу ч гэлээ ард түмэн сайхан сэргээд авлаа. Нийгэмд өгсөн маш зөв дохио боллоо.

- **Олон нийтийн зүгээс ямар саналыг илүү түлхүү өгсөн байна вэ?**

Нэгдүгээрт, төсвийн алдагдлаа багасга гэж байна. Хоёрдугаарт, давхардсан халамжийг багасгах талаар хүмүүс их шүүмжилж байна. Ер нь хөдөлмөрийн чадвартай хүнд халамж гэж бэлэн мөнгө битгий өгөөч, архины мөнгийг нь битгий бэлдээч гэж хэлээд байна.

- **Монгол Улсын төсөв ер нь цаашид алдагдалгүй байх эдийн засгийн чадавх бий юу?**

Тийм чадавхыг байлгаж гэж хичээхгүй л бол хэзээ ч бий болохгүй. Ер нь чадавхийг хүчээр бий болгодог юм. Би түрүүнд хэлсэн. 3.3 их наядоор орлого нэмэгдээд байхад яагаад алдагдал ихсээд байна вэ гэдгийг бодох хэрэгтэй. Төсөв алдагдалгүй байх боломж бий.

- **Төрийн хэмнэлтийн тухай хуулиар 500-аад тэрбум төгрөг хэмнэсэн гэж Сангийн сайд илтгэлдээ дурдсан байсан. Энэ хэр бодит хэмнэлт болсон бэ?**

Урсгал зардлаа багасгаж 500 гаруй тэрбумыг хэмнэж чадсан нь маш сайн. Яг энэ мөнгөөрөө цалин багатай төрийн албан хаагчид, эмч, багш нарынхаа цалинг нэмэх боломжтой. Ер нь хүн “Чамд 20 тэрбум төгрөг өгье. Энийг зөв зарцуулаад хэмнэж чадвал тэр хэрээр урамшуулъя” гэвэл хэмнэхдэг юм.

- **Танай зөвлөлөөс ирэх оны төсвийн талаарх өөрсдийн зөвлөмжийг хүргүүлсэн гэж байсан. Гэхдээ энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхгүй нь Засгийн газрын дурын асуудал гэсэн үг үү?**

Нэгдүгээрт, Засгийн газрын хувьд дурын асуудал. Хоёрдугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулсан тогтоолын хүрээнд гаргасан дүрэм гэж бий. Энэ дүрэмд тухайн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн биелэлтэд ямар хариу өгснөө эргээд Засгийн газар тайлагнаж байна гэсэн албан ёсны заалт оруулах шаардлагатай байгаа юм. Манай зүгээс өнгөрсөн хоёр, гурван жилд өгсөн санал зөвлөмжүүдээ Сангийн сайдад хүргүүлээд хэрэгжилтийн байдлын талаар мэдээлэл авсан. Ихэнх нь хэрэгжиж байгаа гэсэн тайлан мэдээлэл ирсэн. Дээр хэлсэн эргэж тайлагнах тухай заалтыг дүрэмд оруулж өгснөөр хариуцлагын нэг хөшүүрэг болох юм уу гэж бодож байна.

- **Ирэх жилээс эхлэн өндөр орлоготой иргэдийн давсан орлогоос нэмэлт татвар авахаар болсон. Энэ нь хэр шударга гэж та бодож байна?**

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу иргэн хүн орлого олсон л бол татвар төлөх ёстой. Хоёрдугаарт Монгол Улсын иргэд бүгд тэгш орлоготой биш. Тиймээс өндөр орлоготой иргэд, аж ахуйн нэгж нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийнхээ тодорхой хэсгийг авч явах ёстой. Үүний хүрээнд жишээ нь 20 саяас дээш орлоготой иргэн байлаа гэхэд 20 саяас илүү орлогоос нь бага хэмжээний татвар нэмэгдүүлж авах л зохицуулалт юм.

- **Манай улсын зээлжих зэрэглэл харьцангуй тогтвортой, В үнэлгээтэй байгаа гэж илтгэлд дурдсан байсан. Энэ нь хэр сайн үзүүлэлт юм бэ?**

Манай хувьд дээд хэмжээний л үнэлгээ л дээ. 2016 оны үед бараг С рүү орчихсон юм. Тэр үед төсвийн алдагдал бараг 5, 10 хувь руу ч орж байсан. Сүүлийн үед дэлхий даяараа мөнгө олдохгүй, мөнгө үнэтэй болж байна. Тиймээс Монгол Улсын Засгийн газар бага хүүтэй зээл авах, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад ОУВС-ийн үнэлэлт дүгнэлт бас чухал нөлөөтэй гэдгийг хаа хаанаа ойлгох хэрэгтэй юм.

ОУВС-гийн гаргасан дүгнэлтээр бусад улс орнууд харилцдаг. Энэ сангийн хамгийн том хувьцаа эзэмшигчид нь АНУ, Англи, Франц, Япон, Хятад зэрэг орноос байгаа. Тэгэхээр эдгээр улсуудтай сайн харилцаатай байж Олон улсын валютын сангийн дэмжлэгийг авна гэсэн үг.

Нэг зүйлийг онцолж хэлэхэд, ОУВС-аас сануулж байгаа “Төсвийн сахилга батыг бэхжүүлэх зарчмыг хэрэгжүүлэх” нь бидэнд юу юунаас илүү чухал. Монгол Улсын нэр хүнд, зээлжих зэрэглэл өндөр, төрийн бодлого нь тогтвортой байна гэдгийг ОУВС-аар дамжуулж дэлхий

нийтэд дохио болгон өгч байж цаашид дараа дараагийн жилүүдэд төлөгдөх ёстой зарим өр төлбөр, ялангуяа бондуудын асуудлаа нааштай шийдэх боломж бүрдэнэ.

- **Засгийн газар өмнө гаргасан бондын өрийг дараагийн бонд гаргаж, дахин санхүүжүүлэх маягаар гал намжаах тохиолдол бишгүй. Иргэдийн хувьд өрийг өрөөр дарсан энэ байдлыг багагүй шүүмжилдэг. Ер нь үүнээс өөрөөр шийдэх гарц, гаргалгаа үнэхээр байхгүй юу?**

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хувьд өрийг өрөөр дарж болно, гэхдээ төлөх өрийнхөө 20-иос доошгүй хувийг заавал төл гэсэн санал тавьж байгаа. Өөрөөр хэлбэл, үндсэн өрийн 20-иос доошгүй хувийг төлөөд явахад урт хугацаандаа өр нь багасаад төлөгдөөд дуусна.

- **Та яриандаа инфляц зургаан хувьд байх болов уу гэж хэлсэн. Ер нь цаашид инфляц хэр тогтвортой байх бол?**

Инфляци дээд төвшиндөө хүрчихсэн байгаа, одоо яваандаа буурна. Гэхдээ бид ханшийн талаар их л ярих тусам инфляц дээшээ өгсчихдөг. Долларын ханш ч бас адилхан.

- **Жил бүрийн төсөв батлагдсаны дараа тодотгол хийдэг нь бараг жишиг болсон. Ирэх оны төсвийн хувьд тодотгол хийхгүй байх боломж бий юу?**

Тодотгол хийхгүй байх гэж найдаж байна. Хийлээ ч оны сүүлээр болох биз.

- **Та 1992-1995 онд Монгол Улсын Сангийн сайдаар ажиллаж байсан. Таныхаар Монгол Улсын сүүлийн 30 жилд явуулж буй төсвийн бодлого хэр зөв голдрилоор явж ирсэн гэж хардаг вэ?**

2008 он хүртэл зөв байсан, 2008 оноос хойш буруу тийшээ явсан гэж боддог. Тэр үед Монгол Улсад алтан боломж гарсан юм. Зэсийн үнэ хоёр, гурван мянгаас хэтэрдэггүй байсан бол 8000-9000-д хүрсэн. Нүүрс 20-хон ам.доллар байсан бол 80-100 ам.долларт хүрч байлаа. Энэ үед сонгуулийн сурталчилгаанд зориулж, баялгийг хүн бүрт хуваарилна гээд нэг сая төгрөг, 500 мянган төгрөг гэх мэтээр мөнгө тараалтын уралдаан болсон. Энэ нь хүмүүсийг ажил хийхгүйгээр хөнгөн маягаар төрөөс мөнгө авчих хүсэлтэй, бэлэнчлэх сэтгэлгээтэй болгочихсон. Үнэнийг хэлэхэд энэ муу зангаасаа бид одоо хүртэл гарч чадахгүй байна. Тэгэхээр өнөөдрөө бодсон, нийтийн баялгийг хувийн улс төрийн бодлогод зориулдаг ийм зарчимгүй байдлыг зогсоох ёстой юм.

- **Мэдээж Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэдэг. Туршлагатай санхүүч хүний нүдээр харахад манай улсын хувьд төсвийн орлогоо бодитоор нэмэгдүүлэх өөр ямар салбар байна вэ?**

Хамгийн эхэнд гэвэл эрчим хүчний салбар байна. Хоёрдугаарт, төмөр зам. Мөн хөнгөн, хүнсний үйлдвэрүүд ч боломжтой. Манай банкуудын хувьд иргэдийн хадгаламж дээр суурилдаг учраас өнөө маргаашийн зээлийн хэрэгцээгээ л хангаж чадаж байна. Дунд хугацаандаа ядаж 10 жилийн зээлийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Тийм учраас удаан хугацааны хуримтлалын эх үүсвэр бий болгоод, түүнийгээ зөв зохицуулалт хийж чадвал тэр нь өнөөгийн нүүрс, зэс шиг мөнгө эргэлдэх механизм бий болчих юм. Ер нь аж ахуйн нэгжүүд эргэлтийн хөрөнгө байхгүй учраас Монгол Улс хүссэн хүсээгүй олон жижиг үйлдвэртэй, тэр нь өөрсдийнхөө амийг л аргацаасан байдалтай болчихоод байгаа юм. Тэгэхээр бид хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болоод массив үйлдвэр буюу томоохон хэмжээний үйлдвэрлэлийн суурь баазыг хөгжүүлж чадвал төсвийн орлогын 30-аас доошгүй хувь нь хөнгөн хүнсний үйлдвэрээс бүрдэх нөхцөл боломж бий болно.

- **Та мөн ИБУИНВУ-д эх орноо төлөөлөн Элчин сайдаар ажиллаж байсан дипломатч хүн. Тиймээс дэлхий дахинд өрнөөд байгаа өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байна вэ. Олон улсын эдрээтэй энэ цаг үед Монгол Улс цаашид гадаад харилцааны хувьд ямар зарчим, бодлогыг барих нь зүйтэй гэж та үзэж байна?**

Мэдээж нэгдүгээрт хоёр хөрштэй ам зөрөхгүй байх тухай асуудал Монгол Улсын гадаад харилцааны чухал бодлого. Гэхдээ энэ нь шаардсан бүгдийг нь хэрэгжүүлэх ёстой гэсэн үг биш. Бид гадаад бодлогын хувьд хоёр хөрштэй зарим талаар санал нийлэхгүй үе байж болно. Гэхдээ бид Үндэсний болон ард түмнийхээ эрх ашигт нийцсэн бодлого явуулж

байгаа гэдгээ хоёр хөршдөө тодорхой илэрхийлдэг байх ёстой. Хоёрдугаарт, гурав дахь хөрш буюу Япон, Өмнөд Солонгос, АНУ, Европ, Австрали зэрэг улс орнуудтай бүх талаар харилцаатай байж, тэдний дэмжлэгийг авч хамтран ажиллах ёстой. Чухал, найрсаг харилцаатай орнуудтайгаа хоёр хөрштэй ижил бодлого явуулах хэрэгтэй. Мөн гурав дахь хөршийн бодлогыг манай улс ямагт хоёр хөршийнхтэй ижил, эн тэнцүү авч явах ёстой. Миний харж байгаагаар, манай гадаад харилцааныхан, төр засгийн удирдлагууд ч үүнийг маш сайн ойлгож, нэлээд өндөр төвшинд сурсан гэж ойлгодог.